

С
363.2
Б-342

Албан хэрэгцээнд зориулав

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Баянмөнх

Хэвлэлийн хуудас: 10.9 х/х

Цаасны хэмжээ: А.4

Өрөлтөд орсон огноо: 2024.11.20

Дугаарыг эрхлэн гаргасан: Доктор (Ph.D) Б.Баянмөнх

ISBN 978-99962-8882-2-7

2024 №3 (40)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

Ж.Долгорсүрэн Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Б.Пүрэв Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор

Ж.Заанхүү Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор

Г.Гантөмөр Хууль зүйн доктор, (Ph.D), профессор

Ч.Нямсүрэн Хууль зүйн доктор (Ph.D), профессор

З.Төрмандах Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Т.Оюунчимэг Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Сэтгүүлийн эрхлэгч: Хууль зүйн доктор (Ph.D), профессор Бө.Бат-Эрдэнэ

Нарийн бичгийн дарга: Хууль зүйн доктор (Ph.D) Б.Баянмөнх

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

Т.Бямбаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

О.Цэцэгмаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Д.Энхжаргал Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)

Д.Мягмарцэрэн Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Ш.Ариунбилэг Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Б.Баянмөнх Хууль зүйн доктор (Ph.D)

Г.Бямбадорж Хууль зүйн доктор (Ph.D)

*Манай хаяг: Дотоод хэргийн их сургууль Баян зүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, хилчиний гудамж-1, утас: 99878219
мэйл хаяг: b.bayadaa2007@gmail.com*

ЦАГДАА СУДЛАЛ
Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл
(дугаар 2024 №3)

АГУУЛГА

ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Р.Баярмагнай. Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүй, анхаарах асуудал.....	4
Ү.Хосбаяр. Нууц мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал /ОХУ, Украин, Казахстан, Киргизстан улсын жишээ дээр/.....	12
Н.Бадраа. Кибер аюулгүй байдал ба кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь.....	17
Д.Бат-Эрдэнэ. Хууль бусаар ан агнах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал	24

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Т.Саруултөгс. Гадаадын зарим оронд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг хуульчилсан байдал, түүнд хийсэн харьцуулалт.....	33
Б.Даваадорж. Гэмт хэргийн социологи: үндсэн асуудал, чиг хандлага.....	38

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Н.Сайнбаяр. Эрүүгийн процесс дах хөөн хэлэлцэх хугацааны учир холбогдол.....	42
Б.Баярсайхан. Хуш модны үр идээг түүж бэлтгэсэн үйлдэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй байдал, хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх арга зам.....	46

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Одбаатар. Цагдаагийн байгууллагын стратеги төлөвлөлт, түүний хэрэгжилтэд хийсэн шинжилгээ.....	55
Б.Баянмөнх. Жагсаал, цуглааны үеийн хэв журам сахиулах цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тулгарч байгаа зарим хүндрэл бэрхшээл.....	63
Д.Бямбахүү. Объектын судалгаа явуулахад хиймэл оюун ухаан ашиглах нь.....	70

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ ПРАКТИК

Д.Нямдорж, В.Номинчулуун. Замаас үүдэн гарсан осол, хэргийг шалгах хэрэгцээ шаардлага.....	76
С.Индра. Хүүхэд тээврийн хэрэгслийн зорчигч хэлбэрээр зам тээврийн осолд өртөж буй өнөөгийн байдал.....	84

СУРГАЛЦАХУЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Н.Пүрэвдорж. Е-Сургалт түүний мөн чанар, давуу болон сөрөг тал.....	91
Ц.Өнөболд. Дотоод хэргийн их сургуулийн багш, сонсогч, суралцагчдын харилцаанд анхаарах асуудлууд.....	104

АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АРГА ЗҮЙ,
АНХААРАХ АСУУДАЛ

METHODOLOGY INVESTIGATION OF CORRUPTION
CRIME, ISSUES TO CONSIDER

Р.Баярмагнай

Хууль зүйн доктор, профессор

Хураангуй: Авлигын гэмт хэргийг төлөвлөгөөний дагуу хойшлуулшгүй, хэргийн нууцлалыг хангаж мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн, мэдээ сэлт дээр тулгуурлан мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь илүү өндөр үр дүнтэй бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны өнөөгийн байдалд судалгаа шинжилгээ хийж, тухайн ажиллагааг зохион байгуулахад анхаарах асуудлын талаар дүгнэлт гаргахад оршино.

Abstract: It is more effective to carry out an investigation based on the results and information of the secret investigation, which cannot be delayed according to the plan and ensures the confidentiality of the case.

Түлхүүр үг: Авлига, гэмт хэрэг, мөрдөн шалгах ажиллагаа, анхаарах асуудал, тактик, арга зүй.

Key words: Corruption, crime, investigation, issues to consider, tactics, methodology.

Нэг. Эрх зүйн зохицуулалтын талаар

Авлигатай тэмцэх, авлигыг таслан зогсоох, авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах эрх зүйн зохицуулалтыг улс орон болон олон улсын түвшин тэдгээрийн хамтын ажиллагааны мэргэжлийн байгууллагуудын хувьд нэн тэргүүлэх зэргийн ач холбогдолтой асуудал юм. Учир нь авлигын гэмт хэргийн субъект нь цагаан захтан гэгдэх төрийн удирдах албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий тушаал шийдвэр гаргах этгээдүүд холбогдох бөгөөд энэ гэмт хэрэг нь хахууль өгсөн, авсан, түүнчлэн давуу байдал олгож байгаа болон давуу байдал олж авч байгаа хоёр этгээдийн хооронд үйлдэгдэж байгаа мэт боловч эрх бүхий албан тушаалтны өөрийн ашиг сонирхлын үндсэн дээр гаргаж буй хууль бус тушаал, шийдвэрийн улмаас улс орны эрх ашиг, эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг, гэмт хэргийн хор уршиг нь нийгмийн давхарга ялгахгүйгээр гишүүн бүрт учирдгаараа бусад төрлийн гэмт хэргээс эрс ялгаатай, гэмт хэргийн ангиллын хувьд хүнд төрлийн гэмт хэрэгт тооцогддог.

НҮБ-ын Конвенцод хахууль авах гэмт хэргийн “албан тушаалтан” гэдэг нэр томъёог бус “нийтийн албан тушаалтан” (Public Official) ашиглаж улмаар түүнийг тодорхойлохдоо:

1.Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн томилогдсон, сонгогдсон, түр, байнгын, цалинтай, цалингүй бүх төрлийн албан тушаалтан,

2.Дотоодын хуулиар тодорхойлсноор нийтийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа, эсвэл нийтэд аливаа үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээдийн ажилтан, эсвэл аливаа хувь этгээд,

3.Дотоодын хууль тогтоомжоор “нийтийн албан тушаалтан” гэж тодорхойлсон бүх албан тушаалтныг бүгдийг нь хамруулна гэж тодорхойлжээ¹. Эндээс дүгнэхэд НҮБ-ийн Конвенц нь авлигын гэмт хэрэгт “нийтийн албан тушаалтан” (Public Official) гэсэн нэршлийг ашиглаж, түүнийг маш өргөн хүрээгээр тодорхойлж өгсөн байна.

¹ Гэрэлтуяа.Г нар. Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудлууд. Уб. 2022., 25-26 дахь тал.

Эндээс харахад НҮБ-ийн Конвенц нь авлигын гэмт хэрэгт “нийтийн албан тушаалтан” (Public Official) гэсэн нэршлийг ашиглаж, түүнийг маш өргөн хүрээгээр тодорхойлж өгсөн байна.

Нийтийн албан тушаалтан гэдэг нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 Нийтийн албан тушаалтан гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээдийг хэлнэ² гэсэн бөгөөд уг хуулийн 4.1-д энэ хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан албан тушаалтан хамаарна гэж заажээ. Үүнээс үзэхэд улс төрийн, төрийн тусгай, захиргаа, үйлчилгээний удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан болон бусад зарим албан хаагч хүртэл авлигын гэмт хэргийг субъектэд хамаарах юм.

Уг тусгай субъектийн онцлогийн хувьд авч үзвэл өндөр боловсролтой, ажил мэргэжлийн дадлага туршлагатай, хуулийн болон эдийн засгийн өндөр мэдлэгтэй, тогтвортой харилцдаг, танил талын өргөн хүрээтэй, нийгэмд тодорхой байр суурь эзэлсэн, олон нийтэд болон тодорхой салбарт нэр хүндтэй, танигдсан, эдийн засгийн хувьд бэхэжсэн, улс төр, нам, олон нийтийн сонгуульт ажилтай тодорхой салбарт удаан жил ажилласан нөлөө ихтэй ялангуяа хууль хяналтын байгууллагад төлөөлөлтэй байдаг³.

Энэхүү гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын хэмжээ нь бусад төрлийн гэмт хэрэгтэй харьцуулахад их хэмжээний мөнгөн хохирлыг нийгэмд учруулж байдаг тул хууль бус мөнгөний шилжилт хөдөлгөөнийг тодорхойлох, эцсийн эзэмшигчийг нь тогтоон баримтжуулах нь гол зорилго юм. Хууль бус эх үүсвэртэй мөнгө хаанаас, хэзээ орж ирсэн, хэн хүлээн авсан, хаана хадгалсан, улмаар хэрхэн зарцуулж байгаа нь хэргийн нотлох үйл ажиллагааны гол үндэслэл суурь болдог.

Мөнгөн гүйлгээтэй холбоотой санхүүгийн ул мөрийг бэхжүүлэх ажиллагаа нь хэрэгт холбоотой баримт, үйл явдал, нөхцөл байдлыг логик болон үйл явдлыг дэс дараатайгаар бүрэн зураглалаар харуулах, нөгөөтэйгүүр гэмт хэргийн хамтран оролцогчдын үйл ажиллагааг тодорхойлох, тэдгээрийн санаа сэдэл, хэлбэрийг тогтооход ач холбогдолтой.

Авлигын гэмт хэрэг нь эдийн засгийн гэмт хэргийн ялангуяа мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болдог тул мөрдөн шалгах ажиллагааг цаг алдалгүй явуулах нь гэмт хэргийн улмаас олсон хууль бус мөнгөн орлого, хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг олж тогтоох, улмаар чанар байдал, үнэ үнэлгээг алдагдуулахгүйгээр хураан авах ажиллагааг явуулах шаардлагатай байдаг. Ингэснээр гэмт хэргийн улмаас олсон хууль бус эх үүсвэртэй хөрөнгө, орлогыг эргэлтэд оруулах, хувиргах, угаах боломжийг бууруулж, хэргийг нотлоход өндөр ач холбогдолтой байдаг.

Авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа эрх бүхий мөрдөгч нь мэдүүлэг авах, нэгжлэг, үзлэг хийх, хураан авах зэрэг уламжлалт арга барилаас гадна орчин үеийн техник технологийн дэвшил, цахим хэрэгслээр дамжуулан интернет эх сурвалж ашиглах, банк санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримтыг нягтлах, санхүүгийн тайлан мөрдөх, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааг явуулж хууль бус эх үүсвэртэй мөнгөн гүйлгээ, түүний эцсийн эзэмшигчийг тогтоох зорилгоор хөөж шалгах, мөрдөгчийн магадлагааг түлхүү хэрэглэх, бусад улс орнуудын хамтын ажиллагаа, сайн туршлагыг судалж, суралцан арга барилаа сайжруулж байх зайлшгүй шаардлагатай юм.

Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагуудын онцлогоос шалтгаалан гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх бүхий мөрдөгчдийг дагнан ажиллуулах, ил болон мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажлыг хослуулан явуулах, эрх бүхий байгууллагууд хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллах зэргээр ээдрээ төвөгтэй, нууц далд

² Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль//Төрийн мэдээлэл. УБ., 2012. №35

³ Бумнанжил.Д, Мягмарцэрэн.Ш, Авлига, албан тушаалын гэмт хэрэг мөрдөх аргачлал. УБ., 2011, 9 дэх тал.

аргаар үйлдэгддэг авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэж болох хууль, эрх зүйн зохицуулалттай.

Дэлхийн бусад орны нэгэн адил Монгол улсад жил ирэх тусам "авлига, албан тушаалын" гэмт хэрэг ихээр нэмэгдэн гарч, өмнө үйлдэгдэж байсан гэмт хэргийн үйлдлийн арга улам бүр нарийсаж, хил дамнан үйлдэгдэж байгаа билээ. Эдгээр гэмт хэргүүдийн үйлдлийн арга улам нарийсаж, гэмт хэргийн тоон үзүүлэлт нэмэгдэж байгаа энэ цаг үетэй зэрэгцэн тухайн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий алба хаагч бүр энэ талын мэдлэг эзэмшсэн байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Авлигын гэмт хэргийг мөрдөхөд мөрдөгч нь хуульд заасан үндсэн шалгуураас гадна дараах чадваруудыг эзэмшсэн байх зайлшгүй шаардлагатай. Үүнд:

1. Хууль хэрэглэх чадвар.
2. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны мэдлэг.
3. Гадаад хэлний мэдлэг.
4. Багаар ажиллах.
5. Мэдүүлэг авах тактик арга, зүй.
6. Үзлэг, нэгжлэг явуулах тактик, арга зүй.
7. Компьютер техник, технологийн мэдлэг.
8. Хуульд заасан мөрдөн шалгах буцсад ажиллагаа буюу Мөрдөн шалгах нууц ажиллагааны талаарх мэдлэг, туршлага зэргийг шаарддаг онцлогтой.

Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгахад мөрдөгч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн талаар зохих мэдлэгтэй, мөрдөн шалгах ажиллагааны туршлагатай байх ёстой. Учир нь дээрх төрлийн гэмт хэргийн хамрах хүрээ их, шалгах асуудал нь өргөн бөгөөд шалгагдаж байгаа этгээд нь зохих хэмжээний боловсролтой, гэмт хэргээ нуун далдлах талаар тодорхой мэдлэгтэй, уг гэмт хэргийг шууд санаатай үйлдсэн байдаг нь энэ хэргийн онцлог юм.

Хоёр:Өнөөгийн нөхцөл байдал. Сүүлийн 5 жилийн байдлаар 2019 онд 2104, 2020 онд 2282, 2021 онд 2314, 2022 онд 2785, 2023 онд 3749 гомдол, мэдээллийг хүлээн авч, нийт гомдол, мэдээлэл 78 хувиар өссөн байна⁴.

Хүснэгт:1.Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Сүүлийн 5 жилийн байдлаар 2019 онд 1300, 2020 онд 1331, 2021 онд 1307, 2022 онд 1520, 2023 онд 1837 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж 2019 оноос хойш 41 хувиар нийт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа нэмэгдсэн байна⁵.

Хүснэгт:2. Хэргийн шийдвэрлэлт

⁴ Авлигатай тэмцэх газрын 5 жилийн гэмт хэргийн тоон мэдээ. Уб., 2023. 2 дахь тал

⁵ Авлигатай тэмцэх газрын 5 жилийн гэмт хэргийн тоон мэдээ. Уб., 2023. 3 дахь тал



2007-2018 онд жилд дунджаар 67.3 хэрэг шилжүүлсэн бол 2019 онд 156 болж тогтмол өссөн 2023 онд нийт 325 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлсэн нь 2019 онтой харьцуулахад 2 дахин өссөн өссөн үзүүлэлттэй байна.


Авлигатай тэмцэх газар үйл ажиллагаа явуулж эхэлсэн 2007 онтой харьцуулбал энэ тоо 20 дахин өссөн дүнтэй байна.

2007-2018 онд шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг дунджаар 38.45% байсан бол 2019 онд 43%, 2023 онд 59% болж өссөн үзүүлэлттэй байна.

2019 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлсэн хэргээс 68 эрүүгийн хэрэг анхан шатны шүүхээр шийдвэрлэгдэж байсан бол 2023 онд 192 хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж, шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг 2.8 дахин өссөн байна.

Авлигатай тэмцэх газар үйл ажиллагаа явуулж эхэлсэн 2008 онтой харьцуулбал энэ тоо 7.3 дахин өссөн дүнтэй байна⁶.

Хүснэгт: 3. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэл



2007-2018 онд жилд дунджаар нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 4.07 тэрбум төгрөг, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 24.1 тэрбум төгрөг, гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын хэмжээ 1 их наяд 133 тэрбум төгрөг байсан бол 2019 оноос хойш дээрх үзүүлэлтүүд бүгд огцом өссөн.

2023 онд нийт учирсан хохирол 845.7 тэрбум төгрөг, үүнээс нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 238.7 тэрбум төгрөг, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 17.1 тэрбум төгрөгөөр үнэлэгдэж байна.

2023 оны байдлаар нийт учирсан хохирлын 28.22 хувийг нөхөн төлүүлсэн ба хахуулийн 8,680,730,871 төгрөгийн үнэ бүхий бэлэн мөнгө, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хураан авсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24.1 дүгээр зүйлд заасны дагуу сүүлийн 3 жилийн байдлаар 2021 онд 25 хэрэгт холбогдуулан нийт 80 объект, 2022 онд 44

⁶ Авлигатай тэмцэх газрын 5 жилийн гэмт хэргийн тоон мэдээ. УБ., 2023. 4 дэх тал

хэрэгт холбогдуулан нийт 275 объект, 2023 онд 60 хэрэгт холбогдуулан 334 объект, нийт 129 хэрэгт 689 объектод нэгжлэг хийж, хураан авах ажиллагааг явуулсан байна.

Үүнээс үзвэл авлигын гэмт хэрэг нь цаашид өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна. Тиймээс авлигын гэмт хэргийн нэгжлэг хийх, хураан авах ажиллагаа болон , мөрдөгч нарын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэн, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлж нотлох ажиллагааг илүү сайжруулах шаардлагатай байна. Тэгвэл энэхүү гэмт хэргийн нэгжлэг, хураан ажиллагааг явуулахад анхаарах асуудлыг тодорхойлох асуудал үүнээс үүдэн гарч ирж байна.

Авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах процессын үед нотолгоо болон нотлох баримт гэж ангилан хууль тогтоомжид тайлбарласан байдаг. Нотолгоо нь хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан шийдвэр гаргахын тулд тодорхой этгээдээс нотолгооны зүйлийг гэмт хэргийн бүрэлдэхүүн болон түүнтэй холбогдон бий болох бусад нөхцөл байдлуудыг тогтоох үйл явцыг хэлдэг⁷.

Харин Нотлох баримт гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг ойлгох⁸ ба нотлох баримтуудаар тогтоогдсон нөхцөл байдал буюу дүр зургийг үйл баримт гэж тайлбарладаг. Авлигын гэмт хэргийг илрүүлэх явцад нэгжлэг хийх, хураан авах ажиллагаагаар хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулан, бэхжүүлж авч, хэргийг тал бүрээс нь бүрэн дүүрэн нотлох шаардлага тулгардаг.

Гурав:Авлигын гэмт хэрэгт мөрдөн шалгах тактик, арга зүйн талаар

Авлигын хэрэгт үзлэг, нэгжлэг хийх, тактик, арга зүйн талаар: Үзлэг, нэгжлэгийн өмнө хийж гүйцэтгэх ажиллагааг сайтар төлөвлөж, үзлэг, нэгжлэг хийх гэж буй газрыг судалж учирч болох эрсдэлийг урьдчилан тооцох шаардлагатай.

Мөн орон байранд нэвтрэн орох үед нэгжүүлэгчийн зүгээс зэвсэгт эсэргүүцэл үзүүлэх, амиа хорлохоор сүрдүүлэх тохиолдолд гаргасан үед боломжит аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээг авч түүний сэтгэхүйд нөлөөлж, тайвшруулах, эсэргүүцэл үзүүлэх боломжийг нь хаах, зэвсгийг нь хураан авах, ажиллагааг хэвийн явуулах арга хэмжээг нэн тэргүүнд авах хэрэгтэй.

Нэгжлэг хийх байранд ормогц мөрдөгч өөрийгөө танилцуулж, бичиг баримтаа үзүүлээд, нэгжлэг хийх тухайгаа тайлбарлан, нэгжлэг хийх тухай тогтоолыг уншиж сонсгоод нэгжүүлэгчээр гарын үсэг зуруулсны дараа нь гадна хаалганы дэргэд хамгаалалт гарган, нэгжлэг хийх байранд байгаа хүмүүсийг хэн болохыг нь шалгана.

Нэгжлэг хийж буй газрын эзэнд хандаж эрж хайж байгаа зүйлийг сайн дураараа гаргаж өгөхийг хүснэ. Эрж хайж байгаа зүйлийг гаргаж өгсөн тохиолдолд мөрдөгч тухайн зүйлийг бүрэн гүйцэт байна гэж үзвэл нэгжлэг хийлгүй, хураан авах ажиллагаа явуулна. Гэвч практикт гэмт этгээдүүд болон тэдний хань хамсаатан мөрдөгчийн мэдэж хайж байгаа зүйлийг сайн дураараа мэт гаргаж өгөөд цаанаа өөр бусад эд мөрийн баримт, хэрэглээнд хориглогдсон зүйлүүдийг нууж авч үлдэхийг санаархдаг. Ийм тохиолдолд мөрдөгч нь хэрэгт ач холбогдолтой гэж үзсэн эд зүйлс, мэдээлэл, баримт бичиг, бэлэн мөнгө гэх зайлшгүй тогтоон шалгах шаардлагатай нөхцөл байдлыг урьдчилан тооцоолж ажиллагааг дуусгах эсхүл үргэлжлүүлэн явуулах үнэлэлт дүгнэлтийг хийх шаардлагатай байдаг. Нэгжих ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, эрж буй зүйлийг устгах боломжийг хаахын тулд тэнд байгаа хүмүүсийг нэг өрөөнд оруулж хоорондоо ярих, утсаар холбоо барих, нэгжлэг дуустал гадагшаа явахыг хориглож байгааг тайлбарлаж өгнө.

Нэгжлэгийн үеэр гаднаас ирж буй хүмүүсийн зорилгыг асууж, бичиг баримтыг шалгаад нэгжлэг дуустал тэнд түр байлгах арга хэмжээг авах нь зүйтэй бөгөөд харин ажил

⁷ Өнөрмаа.Б. Галдаа.Б нарын Авлигын гэмт хэрэг ба прокурорын хяналт.Уб., 2022. 116 дахь тал

⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль//Төрийн мэдээлэл. Уб., 2017. №34

үүргийнхээ дагуу яваа хүмүүсийг саатуулахгүй боловч тэдний үйл хөдөлгөөнд хяналт тавьж, нэгжлэг хийж буй ажиллагааны нууцлалыг задруулахгүй байхыг урьдчилсан сануулна.

Нэгжлэгийн үеэр тактикийн дараах аргуудыг хэрэглэнэ. Үүнд:

1. Нэгжлэгийг нэг цэгээс нөгөө цэг руу гэсэн дэс дараалалтай хийх,
2. Ач холбогдол бүхий тодорхой хэсгийг сонгон авч нэгжих,
3. 2-3 мөрдөгчдийн баг нь том объектод нэгжлэг хийх болбол угталцан нэгжих, /2 талын цэгээс төв цэгт уулзах замаар/
4. Зэрэгцэн нэгжих,
5. Орон байр, жижиг талбай бүхий оффис байранд цагийн зүүний дагуу нэгжлэг хийх,
6. Хэд хэдэн мөрдөгчид нь зэрэгцэн нэгжлэг хийх зэрэг болно.

Мөрдөн шалгах явцад мөрдөгч нэгжлэг хийхдээ бичгийн нотлох баримтуудыг хураан авахын зэрэгцээ компьютер, хард, флаш, гар утас, таблет, компьютерийг хураан авч, нууц үгийг өөрөөр нь тайлуулах нь зүйтэй байдаг. Тухайн цахим мэдээлэл хадгалдаг төхөөрөмжид агуулагдаж буй мэдээллүүд нь хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байдаг тул түүний анх ямар мэдээлэлтэй байхад нь хэрхэн хураан авсан зэргийг тэмдэглэлд сайтар тусгаж, онлайнаар хоёрдогч, гуравдагч этгээд интернетээр дамжин мэдээллийг өөрчлөхөөс сэргийлж онгоцны горим дээр идэвхижүүлэн хураан авах нь зүйтэй.

Холбогдогч этгээд нь өөрийн мэдээллийг цахим мэдээлэл хадгалдаг зөөврийн компьютер, хард диск, icloud, флаш диск-нд хадгалагдаж байгаа хар данс тооцоо, мөн хахууль авахдаа цахим крипто валютаар авсан, түүнийгээ хөдөлгөөнгүй болгож хадгалсан флаш дисктэй төстэй Cold wallet болох ledger, мөн идэвхитэй эргэлтэд орж захиран зарцуулалт хийж Hot wallet-ийн нэвтрэх нууц нэр, код бичсэн бичвэр зэргийг анхааралтай нэг бүрчлэн үзэж тэр даруй хураан авч үзлэг хийх шаардлагатай байна.

Мэдүүлэг авах тактик, арга зүйн талаар:

Мэдүүлэг авахын өмнө мэдүүлэг авах гэж буй хүний талаарх судалгааг зайлшгүй хийсэн байх шаардлагатай. Судалгааны хэсэгт цугларсан баримтуудыг судлан үнэлэлт дүгнэлт өгч эдгээр хүмүүсийн болон хэргийн нөхцөл байдлын талаар судалгаа шинжилгээ хийж, цаашдын чиглэлийг тодорхойлно.

Зайлшгүй мэдүүлэг авах хүмүүсийн дарааллыг тогтоохдоо хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл агуулж буй тухайн хэрэгт хувийн сонирхолгүй, хэргийн талаар мэдээлэл сайтай, мэдэж буй зүйлээ бүрэн бодитой мэдүүлж чадах хүнийг эхний ээлжид байцаах нь зүйтэй. Тухайн хэрэгт нотлогдвол зохих байдал, мэдээлэл өгөх хир хэмжээ зэргээр байцаалтын гол асуудал, хэмжээ хязгаар тодорхойлогдоно.

Мэдүүлэг өгөгчид тавих асуултыг зөв томьёолон урьдчилан бэлтгэж тавих нь өөр хоорондоо шалтгаант холбоо бүхий үйл явдал, нөхцөл байдлыг сэргээн санах бололцоо, хэрэг нотолгооны гинжэн хэлхээг мөрдөгчид олгодгоороо давуу талтай өндөр ач холбогдолтой ажиллагаа юм.

Мэдүүлэг өгч буй этгээдийн судлах ажиллагаа нь бүхэлдээ мэдүүлэг авах хүний талаар мэдээлэл олж авах, түүнтэй сэтгэл зүйн холбоо тогтоож, хэрэгт ач холбогдолтой бүхий нөхцөл байдлын талаарх мэдээлэл авах аргыг боловсруулахад анхаарах нь зүйтэй.

Мэдүүлэг авах гэж буй этгээдийн талаарх мэдээллийг хойшлуулшгүй ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтуудад үндэслэх, бусад хүмүүсийг мэдүүлэг, нэгжлэг хийх явцад мөн мэдээлэл, баримт бичиг гаргуулах авах зэрэг ажиллагаагаар авч болно. Гэрч, хохирогч, яллагдагчаас мэдүүлэг авахаар төлөвлөхдөө аюулгүй байдлаа хангаж, мэдүүлэг авах газраа тодорхойлж асуултуудаа боловсруулж урьдчилан бэлтгэсэн байх шаардлагатай. Гэрч нь өөрийн сэтгэл зүйн онцлог, хувийн зан байдлаас шалтгаалж өөрийн үзэж харсан, сонссон, мэдэж байгаа зүйлээ өөр өөрөөр тайлбарлаж ярих тохиолдол байж болно.

Иймд тухайн гэрчээс мэдүүлэг авахын өмнө өөрийнх нь мэдүүлэг хэрэгт ихээхэн ач холбогдолтой гэдгийг ойлгуулах, хэрэв худал мэдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага

хүлээлгэх талаар урьдчилан сануулдаг. Үүнээс гадна тухайн гэрчид хөндлөнгийн ямар нэгэн нөлөөлөл байгаа эсэхийг сайтар ажиглаж мэдэх шаардлагатай юм.

Авлигын гэмт хэрэгт холбогдогчид ихэвчлэн мэдүүлэг өгөхдөө урьдчилан бэлтгэсэн байдаг ба мөрдөгчид ямар баримт байгааг мэдэхийг тандсан байр суурьтай байдаг учраас энэ байдлыг нь алдагдуулахын тулд тэднээс юу сонирхдог, ямар боловсрол, мэргэжил эзэмшсэн, ямар ажил хийж ирсэн зэргээр намтрыг нь яриулах, хэнтэй найзалж нөхөрлөдөг, юу хийх дуртай гэх мэт зүйлийг асууж, тодруулж байгаад гэмт хэрэг гарсан цаг үе рүү аажмаар шилжин орох нөхцөлийг бүрдүүлсэн асуулт тавьж мэдүүлэг авах ажиллагааг ерөнхий асуултаас тусгайлан бэлдсэн асуулт руу чиглэх байдлаар явуулна.

Мэдүүлгийг чанартай, үр дүнтэй болгох гол нөхцөл нь мөрдөгчөөс хавтас хэрэгт авагдсан нотлох баримтуудыг нарийн судалж үйлдэл болгоныг мэдэж байхын зэрэгцээ байгаа нотлох баримтыг хэрхэн ямар үед ашиглах, нотолбол зохих нэмэлт ажиллагааг хэрхэн, оновчтой гүйцэтгэх аргыг бодож төлөвлөх хэрэгтэй.

Мөрдөгч гэрч, яллагдагчаас мэдүүлэг авахдаа энгийн яриа өрнүүлж, бие, сэтгэхүйн саадыг арилгах, тайвшруулж мэдүүлэг өгч буй этгээдийг аль болох чөлөөтэйгөөр өөрийн мэдэж байгаа зүйлийг саадгүй ярих нөхцөл боломжоор хангаж өгөх, нууж хаах зүйл байхгүй болсныг ойлгуулах хэрэгтэй болно.

Мөн Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудлын талаар. Үүнд:

Нэг. Болсон үйл баримтын талаар дүгнэлт хийх, /Болж өнгөрсөн үйл явцыг мэдээллийн эх сурвалжтай харьцуулах/,

Хоёр. Үйл баримтыг үндэслэн эрх зүйн ямар төрлийн харилцаа хөндөгдөж байгааг тогтоох /ямар салбарт хэрхэн үйлдэгдсэн болох Боловсрол, Татвар, Гааль, Тендер г.м/

Гурав. Тухайн харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжийг тодорхойлох, /Салбарын хууль тогтоомжийг сайтар судлах/,

Дөрөв. Хууль тогтоомжийн ямар зүйл, заалтын гипотез нь уг харилцаанд нийцэж байгааг тогтоох, /эрх мэдлээ хэтрүүлсэн, урвуулсан, эс үйлдэхүй, албаны нэр нөлөөг ашигласан үйлдэл, Хяналтын шатны шүүхийн 2016-05-20 № 141, 2015- 06-26 № 222/

Тав. Зүйлчлэхдээ зохих үе шат, алхмаар шалгах, таамаглал дэвшүүлж, төсөөтэй гэмт хэргийг шалгаж, мухарлах,

Зургаа. Зүйлчлэхдээ эрх зүйн үндсэн ойлголт, ухагдахуун, нэр томъёог тайлбарлах, тодорхойлох, /албан тушаалтан болох нь ямар хуулиар тодорхойлогдож байгаа Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд хамаарах субъект мөн эсэх, эрх үүрэг нь салбар хуулийн ямар зүйл заалтаар зохицуулагдсан зэргийг яллагдагчаар татах тогтоолд бүрэн тусгах/,

Долоо. Эрх зүйн өрсөлдөх бусад хэм хэмжээ байгаа эсэх, тэдгээрийг хэрэглэх боломжтой эсэхийг шалгах,

Найм. Авлига болон мөнгө угаах гэмт хэргийг шалгахын зэрэгцээ хүндрүүлэх болон хөнгөрүүлэх шалтгаан нөхцөл, холбоо зэрэг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн Хууль ёсны зарчим, Шударга ёсны зарчим, Гэм буруугийн зарчим, Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх, Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна үйлчлэх зэргийг анхаарахаас гадна гэмт хэрэг үйлдэгдсэн бүхий л үе шатыг тогтоох зүйтэй юм.

Дүгнэлт: Авлигын гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэх, мөрдөн шалгах тактик, арга зүйн асуудлыг цогц байдлаар авч үзэн, улмаар анхаарах асуудлын талаар шинжлэх ухааны судалгааны үндсэн дээр дэвшүүлэн гаргаж үнэлэлт, дүгнэлт өгөх нь энэхүү судалгааны ажлын үндэслэл, онол, практик хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг тодорхойлж байгаа хэрэг бөгөөд судалгааны ажлыг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

Хэдийгээр нэг талаас 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Улсын их хурлаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль шинэчлэгдэн батлагдаж эрх зүйн зохицуулалтын орчин боловсронгуй болж, нэгжлэг, хураан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал, хүндрэл бэрхшээл байхгүй мэт ойлгогдох боловч газар орон, объектод

нэгжлэгийн ажиллагааг явуулж хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтуудыг илрүүлэн хураан авах гэхэд хяналтын прокурорын олгогдож буй зөвшөөрөл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “...илрүүлэхээр...” гэж **хуульчилсан нь** мөрдөгч шууд хураан авах зохицуулалтыг тусгаагүй байна.

Мөрдөгчийн зүгээс тухайн нөхцөл байдалд прокурорт мэдэгдэж явуулсан ажиллагаагаар тогтоогдож буй эд зүйлсийг хураан авах талаар мөрдөн шалгах ажиллагааг хүчинтэйд тооцуулах санал гаргаж дахин хүргүүлж хураан авсан эд зүйлийг хүчинтэйд буюу нотлох баримтаар тооцуулж байгаа нь хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго, зорилтыг хангахад цаг хугацаа алдах, улмаар нотлох баримтын шинж чанар алдагдах гэх зэрэг асуудал үүсэж байна.

Мөн нөгөө талаас ажиллагаа явуулж байгаа алба хаагчдын мэдлэг, ур чадварын түвшинээс хамаарч мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулахад алдаа дутагдал гаргах, ажиллагааг дутуу бэлтгэх, төлөвлөлт хангалтгүйгээс болж ажиллагааны зорилгодоо хүрэхгүй байх, алба хаагч болон нэгжлүүлэгч иргэний амь нас, эрүүл мэндэд хохирол учирч болзошгүй нөхцөл байдал үүсэх цаашлаад дахин ажиллагааг явуулах зэрэг эрсдэл үүсдэг.

Иймд авлигын гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэх явцад мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн орчин, түүний удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, шинэ шатанд гаргах, олон улсын туршлагыг нэвтрүүлэх, шинээр томилогдсон алба хаагч нарт чиглэсэн сургалт зохион байгуулах зэрэг цогц бодлого, арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлага бий болсон байна.

Ашигласан материал:

Монгол Улсын хууль

1. Авлигын эсрэг хууль
2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
3. Эрүүгийн хууль
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Ном бүтээл, гарын авлага

5. Гэрэлтуяа.Г нар. Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудлууд. УБ. 2022
6. Бумнанжил.Д, Мягмарцэрэн.Ш, Авлига, албан тушаалын гэмт хэрэг мөрдөх аргачлал. УБ., 2011
7. Өнөрмаа.Б. Галдаа.Б нарын Авлигын гэмт хэрэг ба прокурорын хяналт.УБ., 2022

Сонин сэтгүүл:

8. Төрийн мэдээлэл. УБ., 2006
9. Төрийн мэдээлэл. УБ., 2012
10. Төрийн мэдээлэл. УБ., 2015
11. Төрийн мэдээлэл. УБ., 2017

Статистик тоо мэдээ:

12. Авлигатай тэмцэх газрын 5 жилийн гэмт хэргийн тоон мэдээ. УБ., 2023.

НУУЦ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ
/ОХУ, Украин, Казахстан, Киргизстан улсын жишээ дээр/
SOME OF THE LEGAL ISSUES OF SECRET INVESTIGATIONS
/on the example of the Russian federation, Ukraine, Kazakhstan and Kyrgyzstan/

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх
Ажлын Тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D),
цагдаагийн хурандаа Ү.Хосбаяр

University of Internal Affairs, Head of the Criminal
intelligence Department of the Police school,
Doctor (Ph.D), police colonel U. Hosbayar

Товч агуулга: XXI зуун гарснаар гэмт явдал нууц далд аргаар, техник технологийн дэвшил ашиглан үйлдэгдэх болсон нь ЭХХШТХ, Гүйцэтгэх ажлын тухай хуулиудын зарим ойлголтыг нэгтгэх өөрөөр хэлбэл мөрдөгч */мөрдөн байцаагч/* зарим төрлийн мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах эрх зүйн үндэслэлийг 2017 оны 9-р сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгасан.

ОХУ болон Казахстан, Украин, Киргизстан зэрэг Тусаар улсын хамтын нөхөрлөлийн орнуудын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид энэ төрлийн зохицуулалт Украин 2012 он, Казахстан 2015 он, Киргизстан улс 2017 оноос тус тус орсон ба энэхүү илтгэлд дээрх орнуудын хууль тогтоомжийн онцлог давуу, сул талуудыг судлахыг зорисон болно.

Abstract.: With the advent of the 21st century, the fact that crimes are committed through covert methods and technological advancements is reflected in the ECHR, which began to enforce on September 1, 2017, the legal basis for the consolidation of some concepts of the laws on the Enforcement and Enforcement Activities, i.e., for the conduct of certain types of detective/interrogatory/ secret investigative operations.

This type of regulation has been included in the Criminal Justice Legislation of the GCC and the Commonwealth countries such as Kazakhstan, Ukraine and Kyrgyzstan since Ukraine 2012, Kazakhstan in 2015 and Kyrgyzstan in 2017, and this report aims to explore the strengths and weaknesses of the legislation of these countries

Түлхүүр үг. Нууцлал, Гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа, нэр томьёо, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шат, прокурор, прокурорын хяналт.

Key words. Confidentiality, Executive work, secret investigation, terminology, investigation, investigative stage, prosecutor, prosecutorial control.

Үндсэн хэсэг. Орчин үед хууль сахиулах байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны явцад Гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээлэл, баримт сэлтийг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд ашиглах, ил болгох хэрэгцээ шаардлага гарсаар ирсэн.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны энэ үе шатанд гэмт хэргийн дийлэнх нотлох баримт, ач холбогдол бүхий нөхцөл байдлууд тогтоогддог тул тухайн нотлох баримт ямар аргаар хэрхэн хавтаст хэрэгт авагдах нь чухал ач холбогдолтой. Иймд эрүүгийн хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулах ерөнхий номлол, явуулах үндэслэл, журам, зарчим тодорхой хэмжээгээр төстэй байх боловч зарим ялгаатай байдаг.

Бидний үзэж байгаагаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь нэг талаас хэт хүндрүүлсэн үндэслэл журам хэт олон үе шат, зөвшөөрлийн механизм зэрэг нь хэрэг бүртгэлт мөрдөн байцаах ажиллагаанд саад учруулах тодорхой нөхцөл байдал, үйл баримтыг тогтоох боломжгүй байх⁹ зэрэг сул талуудтай байдаг.

Мөн түүнчилэн эрх зүйн алдаа, хийдэл, өрсөлдөөн бүхий эрх зүйн хэм хэмжээ, оновчгүй зохицуулалт, хэрэг бүртгэх мөрдөн байцаах, гүйцэтгэх албадын хамтын ажиллагаа уялдаа холбоо муу, нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах үндэслэл журам хангалтгүй зохицуулалттай, хамтын ажиллагааг журамаар зохицуулсан зэрэг нь гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээ баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах, нотлох баримтаар үнэлэх зэрэг ажиллагаанд хүндрэл учруулж байсан.

Дээр дурдсан сул тал, эрх зүйн хийдэлтэй холбогдуулан ОХУ-ын Эрүүгийн процессийн хуульд 199 удаа, ОХУ-ын Гүйцэтгэх ажлын тухай хуульд 25 удаа тус тус нэмэлт өөрчлөлт¹⁰ орж байсан байна.

Монгол улсын ЭХХШТХ-ийн шинэчилсэн найруулга 2017 оны 9-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэн тус хуулийн 26-р бүлэгт “Бусад мөрдөн шалгах ажиллагаа” гэж хуульчилсан.

2012 оноос мөрдөгдөж эхэлсэн Украин улсын эрүүгийн процессийн хуульд дараах зохицуулалтууд хуульчилагдсан.

Үүнд: 246-р зүйлийн 1 дэх хэсэг “Мөрдөн шалгах нууц ажиллагааг гэмт этгээд, гэмт хэргийн талаар баримт сэлтийг бусад аргаар тогтоох боломжгүй тохиолдолд явуулна. Мөрдөн шалгах нууц ажиллагааны арга, тактик, баримт сэлтийг задруулж үл болно”¹¹ гэж заасан байна.

Дээрх хуулиар мөрдөгч явуулах эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагааг 2 бүлэгт хувааж үзсэн байна.

Украин улсын эрүүгийн процессийн хуулийн 20-р бүлэгт ердийн хянан шийдвэрлэх ажиллагаа буюу мэдүүлэг авах /224-р зүйл/, таниж олуулах /228-р зүйл/, үзлэг /237-р зүйл/, мөрдөн шалгах ажиллагааны туршилт /240-р зүйл/, шинжилгээ хийлгэх /242-244-р зүйл/, харьцуулсан шинжилгээнд дээж авах /245-р зүйл/.

Дараагийн бүлэг буюу 21-р бүлэгт 2 дэд нууц мөрдөн шалгах ажиллагаануудыг хуульчилсан байна. Үүнд: 1-р дэд бүлэгт хүний хувийн харилцаанд хяналт тогтоох бусад мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж тодорхойлсон. Хувийн харилцаанд хяналт тогтоох гэсэн дэд бүлэгт аудио-видео хяналт /260-р зүйл/, шуудан харилцаанд хяналт тогтоох /261-р зүйл/, холбоо харилцаа, тээврийн сувагаас мэдээлэл, баримт /263-р зүйл/, мэдээллийн цахим сүлжээнд хяналт тогтоох /264-р зүйл/-ыг тус тус ойлгоно. Бусад мөрдөн шалгах нууц ажиллагаанд орон байр, олон нийтийн газарт нууц үзлэг хийх, /267-р зүйл/, радиоэлектрон хэрэгслийн байршлийг тогтоох /269-р зүйл/, объектод аудио-видео хяналт тогтоох, хяналттай хүргэлт, шалгалтын худалдан авалт, мөрдөн шалгах ажиллагааны тусгай туршилт буюу гэмт хэргийг үйлдэгдэх нөхцөл боломжийг үүсгэх гэж тус тус тодорхойлсон байна.

Казахстан улсын Эрүүгийн процессийн хууль 2015 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд уг хуульд мөрдөн байцаагч нь эрүүгийн хэрэг хянан

⁹Юридическая наука и правоохранительная практика Колосевич.М.С 144-р тал 2015 он №3 Москва

¹⁰ Павличенко Н.В, Самоделкин.А.С Негласность в ОРД Вестник Волгоградской академии МВД РФ 2012 г. №3 Волгоград

¹¹ Уголовно-процессуальный кодекс Украина 2012. г Киев

шийдвэрлэх тодорхой ажиллагаа болон нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй гэж хуульчилжээ.

Нэгдүгээр дэд хэсэгт уламжлалт гэж хэлж болох байцаалт /208-217-р зүйл/, нүүрэлдүүлэн байцаах /218-р зүйл/, үзлэг /218-222-р зүйл/ зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой арга хэмжээг тусгажээ.

Хоёрдугаар дэд бүлэгт аудио-видео хяналт тогтоох /242-р зүйл/, харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох /243-р зүйл/, үүрэн телефоны сүлжээнд хяналт тогтоох /244-р зүйл/, компьютер, серверийн мэдээллийн урсгалд хяналт тогтоох, мэдээлэл авах /245-р зүйл/, шуудан харилцааг хянах /246-р зүйл/, нууц үзлэг хийх /247-р зүйл/, нууц ажиглалт /248-р зүйл/, хяналттай хүргэлт /249-р зүйл/, шалгалтын худалдан авалт /250-р зүйл/, нууц нэвтрэлт-гэмт үйлдэл үйлдэгдэх хиймэл үйлдэл үйлдэх¹² зэрэг тодорхой ажиллагааг хуульчилжээ.

Тус хуульд “Нууц мөрдөн шалгах ажиллагаа гэдэг нь урьдчилсан мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн яллагдагчид мэдээлэхгүйгээр энэ хуулийн 7-р зүйлд заасан зорилтонд хүрэхийн ойлгоно”¹³ гэжээ.

Киргизстан улсын Эрүүгийн процессийн хуулийн гол үзэл санаа нь Европын орнуудын эрх зүйн уламжлалыг дагаж хийгдсэн бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой арга хэмжээнүүдийг дараах байдлаар хуульчилсан байна.

Уг хуулийн 31-р бүлэгт тусгай мөрдөн шалгах тодорхой ажиллагаа буюу анхны төслөөр нууц мөрдөн шалгах ажиллагаа гэж нэрлэсэн байсан бөгөөд шуудан харилцаа хянах, утсан харилцаа хянах, мэдээллийн сүлжээний урсгалыг хянах, нууц ажиглалт, аудио-видео хяналт, нууц үзлэг, нууцаар харьцуулсан шинжилгээнд дээж авах, нууц нэвтрэлт, тусгай мөрдөн шалгах ажиллагааны туршилт, хяналттай хүргэлт, шалгалтын худалдан авалт гэх тодорхой ажиллагааг хуульчилсан байна.

Мөн хуулийн 45-р зүйлд “Тусгай мөрдөн шалгах ажиллагаа гэдэг нь мөрдөн шалгах ажиллагааны нэг төрөл бөгөөд энэ ажиллагааг зохион явуулах хүч арга, арга зүй, технологи нь албаны эсхүл төрийн нууц байх бөгөөд задруулахыг хориглоно. Энэ ажиллагаа явуулах үндэслэл журамыг эрх бүхий байгууллагын дотоод дүрэм, журамаар зохицуулж зөвхөн мөрдөн байцаагчийн үндэслэл бүхий саналыг үндэслэн шүүхийн зөвшөөрлөөр явуулна”¹⁴ гэж заасан.

Дээрх дурдсан улсуудын Эрүүгийн процессийн хуульд мөрдөн шалгах тодорхой ажиллагаа, нууц мөрдөн шалгах ажиллагааны төрлүүд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид, сэжигтэн яллагдагчид мэдээлэхгүйгээр гүйцэтгэж байгаа зэрэг адил төстэй байна.

ОХУ-ын Эрүүгийн процессийн хуульд тусгайлан нууц мөрдөн шалгах эсхүл тусгай мөрдөн шалгах ажиллагаа гэж заагаагүй боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид мэдэгдэхгүй гүйцэтгэдэг ажиллагааг хуульчилсан. Жишээлбэл: шуудан харилцаа хянах, үзлэг хийх /185-р зүйл/, харилцааг хянах /186-р зүйл/, утсан харилцааг хянах /186.1-р зүйл/¹⁵.

Нууцаар буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа оролцогчид мэдээлэхгүйгээр гүйцэтгэдэг тодорхой ажиллагааны үндсэн шинж чанар нь нууцлалыг хангах бөгөөд тухайн ажиллагаанд оролцогчид, нууцалбал зохих нэгж, арга, тактикийг задруулж үл болоход оршино.

¹² Уголовно-процессуальный кодекс Казахстана 2014.г Астана

¹³ Уголовно-процессуальный кодекс Казахстана статья 7. 2014.г Астана

¹⁴ Уголовно-процессуальный кодекс Киргизстана статья 45. 2017.г Бишкек

¹⁵ Уголовно-процессуальный кодекс РФ 2002 г. Москва

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 9-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэн тус хуулийн 26-р бүлэгт “Бусад мөрдөн шалгах ажиллагаа”¹⁶ гэж хуульчилсан нууц мөрдөн шалгах ажиллагааны талаар зохицуулалт оруулсан боловч практикт хэрэгжүүлэхэд тодорхой хүндрэл учирч байна. Тухайлбал:

1. ЭХХШТХ-ийн 26.6-д заасан “Хяналтын худалдан авалт”-ыг явуулахад “Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, эд зүйл, мөнгөн тэмдэгт, зэвсэг хэрэгсэл, бодис бэлдмэл, баримт бичгийг худалдан авах, эсхүл худалдан авахаар хэлцэл хийх ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулна” гэж заасан. Практикт дээрх ажиллагааг явуулахад хуульд заасан бараа бүтээгдэхүүн эд зүйл нь иргэний эргэлтэд хориглогдсон байдаг тул дээрх ажиллагаанд оролцогчдийн аюулгүй байдал, нууцлалыг хангахад хүндрэлтэй байдаг.

2. ЭХХШТХ-ийн 1.4.1.26-д “хойшлуулшгүй тохиолдол” гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг хэлнэ гэж заасан боловч 26.7-д “Энэ хуулийн 26.2, 26.3-т заасан мөрдөн шалгах хойшлуулашгүй тохиолдолд явуулахыг хориглоно” гэж заасан байна. Өөрөөр хэлбэл харилцаа, холбооны сүлжээнд хяналт тогтоох, хяналт тогтоох арга хэмжээг хойшлуулашгүйгээр явуулах боломжгүй гэж ойлгогдож байгаа нь зөрчилдөж байна.

3. ЭХХШТХ-ийн 16.8-р зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж **нууц** байна” гэж заасан. Дээрх заалт нь 26.8-р зүйлд нууц мөрдөн шалгах ажиллагааны магадлагаа бичигдэж хавтаст хэрэгт авагдаж байгаа зөрчилдөж байна. Мөн ЭХХШТХ-ийн 16.8-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан “нууц” гэх ойлголт нь Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан ямар зэрэглэлийн нууц болох нь тодорхойгүй.

4. Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах, хавтаст хэрэгт хэрхэн нотлох баримт болгохыг тодорхойлсон журам, эрх зүйн акт батлагдаагүй.

Дүгнэлт. Шинээр батлагдан хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагаа нь: хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллагын мөрдөгч нараас тухайн хэргийн оролцогч нарт мэдэгдэхгүйгээр прокурорын зөвшөөрлөөр тухайн мөрдөгчөөс бие даан хэрэгжүүлж буй ажиллагаа юм. Тухайн хэргийн оролцогч нар буюу хэргийн сэжигтэн, хохирогч, гэрч, шинжээч, өмгөөлөгч нарт мэдэгдэхгүйгээр прокурорын зөвшөөрлөөр мөрдөгч өөрөө биечлэн гүйцэтгэж байгаа нь нууц гэсэн ойлголтыг илэрхийлж байна

Мөрдөн шалгах нууц ажиллагааг хэрэгжүүлэгч субъектын хувьд тухайн хэргийг шалгаж байгаа мөрдөгч нь өөрөө байх ба энэ ажиллагаанд Гүйцэтгэх ажлын эрх бүхий байгууллагын тусгай албад болон нууц гүйцэтгэх ажилтан, гүйцэтгэх ажлын туслах хүчийг татан оролцуулахгүй байх явдал нь төрийн нууцыг хамгаалах нэг хэлбэр юм.

Санал. Дээрх дүгнэлийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Тухайлбал:

1. Зарим улсын Эрүүгийн процессийн хуульд нууц мөрдөн шалгах ажиллагаа, тусгай мөрдөн шалгах ажиллагаа гэх нэрлэгдэж байгаа бөгөөд ЭХХШТХ-д заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг 1.10, 4.3, 5.4, 6.2, 16.8, 22.3, 26.7, 26.8, 26.9-р зүйлүүдэд “Мөрдөн шалгах

¹⁶ Төрийн мэдээлэл. 2017., №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

нууц ажиллагаа” гэж тодорхойлсон 26-р бүлгийг “Мөрдөн шалгах бусад ажиллагаа” гэж хуульчилсан нь нэр томъёоны хувьд зөрчилдсөн байх тул нэг мөр болгох

2. Нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулах, түүний үр дүнг магадлагаа болгож баримтжуулж байгаа нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн зарим хэсэг, зарчимтай зөрчилдөж байгааг шийдвэрлэх

3. ЭХХШТХ-д заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг Гүйцэтгэх ажлын хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа гүйцэтгэх ажлын арга, хүч хэрэгслээс ялгаж ойлгох. Өөрөөр хэлбэл ЭХХШТХ-д заасан үндэслэл журамаар явагдаж байгаа зарим нууц мөрдөн шалгах ажиллагаанд Гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийг ашиглаж явуулж байгаа ойлголтыг салгаж хуульд заасан мөрдөгч буюу мөрдөн байцаагч ердийн арга хэрэгслээр явуулах

4. Казахстан улсын Эрүүгийн процессийн хуулийн “Нууц мөрдөн шалгах ажиллагаа гэдэг нь урьдчилсан мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн яллагдагчид мэдээлэхгүйгээр энэ хуулийн 7-р зүйлд заасан зорилтонд хүрэхийн ойлгоно”¹⁷ гэж заасан байгааг туршлагыг хэрэгжүүлж ЭХХШТХ-д тодорой өөрчлөлт оруулах санал боловсруулах зэрэг саналтай байна.

Ашигласан материал

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль// Төрийн мэдээлэл, 2017. №23;
2. Уголовно-процессуальный кодекс **Республики Армения** [1998 года](#);
3. Уголовно-процессуальный кодекс Украина 2012;
4. Уголовно-процессуальный кодекс Казахстана 2014;
5. Уголовно-процессуальный кодекс Киргизстан 2017;
6. Уголовно-процессуальный кодекс РФ 2002;
7. И.А.Климов. Оперативно-розыскная деятельности М., 2018;

¹⁷ Уголовно-процессуальный кодекс Казахстана статья 7. 2014.г Астана

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА КИБЕР ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ
CYBERSECURITY AND THE PREVENTION OF CYBERCRIME

Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн дэд
профессор, хууль зүйн доктор, цагдаагийн дэд
хурандаа Н.Бадраа

Associate Professor of Criminal Procedure Law
Department, Doctor of Law, Police Lieutenant Colonel
N.Badraa

Товч агуулга: Өнөө үед кибер аюулгүй байдал нь өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй кибер гэмт хэрэгтэй тэмцэхэд нэн чухал сэдэв болоод байна. Фишинг, рансомвэр, хувийн мэдээлэл зөвшөөрөлгүй ашиглах болон мэдээллийн өгөгдөл алдагдах зэрэг кибер халдлагууд нь хувь хүн, байгууллагад эдийн засгийн хохирол учруулж нууцлал алдагдах, бусдын нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх гэх мэт олон талын эрсдэлтэй байдаг. Энэ нийтлэлд кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратеги, тэр дундаа найдвартай нууц үг ашиглах, программ хангамжийг тогтмол шинэчлэх, кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох, өгөгдөл нөөцлөх, сүлжээний аюулгүй байдал, хариу арга хэмжээ авах зэрэг үндсэн стратегиудыг авч үзнэ. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр хувь хүн болон байгууллага аль аль нь эмзэг мэдээллээ хамгаалж, эрсдэлийг бууруулан, цахим орчин дахь аюулгүй байдлаа хангаж чадах юм.

Abstract: In today's world, cyber security has emerged as a crucial issue in the battle against the rising tide of cybercrime. Cyber attacks, including phishing, ransomware, unauthorized access to personal information, and data breaches, pose several dangers, such as financial loss for individuals and businesses, invasion of privacy, and damage to reputations. This article outlines essential strategies for preventing cybercrime, such as employing strong passwords, keeping software up to date, raising cybersecurity awareness, backing up data, ensuring network security, and having an incident response plan. By adopting these practices, both individuals and organizations can safeguard their sensitive data, minimize risks, and maintain their security in the digital landscape.

Үндсэн хэсэг


Бидний амьдралд цахим хэрэглээ нэмэгдсэнээр кибер аюулгүй байдлын асуудал хувь хүн болон байгууллагуудын үйл ажиллагаанд анхаарал татах сэдэв болсон. Хувь хүний мэдээллийг хулгайлах, кибер орчинд хортой программ ашиглан халдлага үйлдэх зэрэг гэмт хэргүүдээс хамаарч кибер орчны аюулгүй байдал зайлшгүй хөндөгдөх тулгамдсан асуудал болж байна. Бид энэ төрлийн кибер халдлагуудын талаар мэдлэг мэдээлэлтэй байж аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлснээр кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах боломжтой. Иймээс кибер гэмт хэргийн төрөл, кибер аюулгүй байдлын ач холбогдол, онлайн орчинд хэрхэн урьдчилан сэргийлэх кибер халдлагын төрөл, олон улсын ба Монгол Улсын нөхцөл байдал, тэдгээрийн харьцуулалт, цаашид авах арга хэмжээний талаар судлах нь хууль сахиулах байгууллагын энэ чиглэлээр хийх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход зохих хэмжээний хувь нэмэр болно гэж үзэж байна.

Монгол Улсын нөхцөл байдал

Монгол Улсад кибер аюулгүй байдлын салбар нь хөгжлийн эхэн шатандаа явж байгаа ч кибер гэмт хэргийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Статистик мэдээллээс үзэхэд, 2023 онд кибер гэмт хэргийн тоо өмнөх онтой харьцуулахад 25%-иар өссөн. Үүний гол

шалтгаан нь техникийн хамгаалалт сул, ажилтнуудын аюулгүй байдлын талаарх мэдлэг дутмаг байгаатай холбоотой гэж судлаачид тодорхойлсон байдаг.

Монгол Улсад кибер гэмт хэргээс хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх хэд хэдэн чухал алхам хийгдсэн. Тухайлбал, 2017 онд батлагдсан "Кибер аюулгүй байдлын тухай" хууль нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад кибер аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх эрх зүйн үндэсийг тавьсан. Гэвч бодит байдал дээр эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.



Хүснэгт:1 Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн статистик үзүүлэлт Олон улсын нөхцөл байдал

Олон улсын түвшинд кибер аюулгүй байдлын чиглэлээр АНУ, Европын холбоо, Япон зэрэг улс орнууд кибер халдлагатай тэмцэх хүчирхэг тогтолцоог бий болгосон. Тухайлбал, АНУ-ын Кибер аюулгүй байдлын ба Дэд бүтцийн аюулгүй байдлын агентлаг (CISA)¹⁸ нь кибер халдлагын эсрэг хариу арга хэмжээг хурдан авах, тэдгээрийг урьдчилан мэдээлэх системийг хөгжүүлсэн. АНУ-д кибер аюулгүй байдалд зориулсан улсын төсөв жил бүр 12%-иар өсөж, 2023 онд 18 тэрбум ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна.

Европын холбоо "Европын кибер аюулгүй байдлын хүрээлэн" байгуулж, гишүүн орнуудын хамтын ажиллагааг дэмжиж, кибер аюулгүй байдлын стандарт, сургалт, судалгааг идэвхжүүлж байна. Мөн Япон улс хиймэл оюун ухаан, блокчейн зэрэг дэвшилтэт технологийг кибер хамгаалалтад ашиглах хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.

Олон улсын түвшинд кибер аюулгүй байдлын чиглэлээр хөгжиж буй туршлагууд онцгой үр дүнтэй байгаа нь статистик болон судалгааны өгөгдлүүдээс харагддаг. Тухайлбал:

АНУ: CISA-ийн 2022 оны тайланд¹⁹ дурдсанаар, кибер халдлагын 75%-ийг фишинг болон рансомвэрийн халдлагууд эзэлж байна (CISA, 2022). АНУ нь хиймэл оюун ухаан ашиглан халдлагыг урьдчилан таамаглах, автоматаар хариу үйлдэл хийх технологийг амжилттай хөгжүүлсэн.

- Европын холбоо: ENISA²⁰-ийн тайланд дурдсанаар, 2023 онд Европт DDoS халдлага 30%-иар нэмэгдсэн боловч мэдээлэл алдагдсан тохиолдол 15%-иар буурсан байна. Европын холбоо гишүүн орнуудын хамтын ажиллагааны хүрээнд кибер халдлагын улмаас үүсэх эдийн

¹⁸ Cybersecurity and Infrastructure Security Agency

¹⁹ CISA - Cyber Incident Reporting for Critical Infrastructure Act of 2022

²⁰ European Union Agency for Cybersecurity

засгийн хохирлыг 20%-иар бууруулахад чиглэсэн төсөлд 1.5 тэрбум евро зарцуулсан (ENISA, 2023)²¹.

- Японы NISC²² нь рансомвэрийн халдлагыг 40%-иар бууруулах хиймэл оюун ухааны шийдлийг амжилттай хэрэгжүүлсэн. Мөн блокчейн технологийг төрийн болон санхүүгийн өгөгдлийг хамгаалахад ашигласан туршилтууд нь 85%-ийн илрүүлэлттэй гарсан нь дэлхийн дундаж үзүүлэлтээс 20%-иар өндөр байна (NISC)²³.

Эдгээр жишээнүүдээс харахад олон улсын туршлагууд нь технологи, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа зэргээс хамаарч бодит үр дүнд хүрч байгаа бөгөөд Монгол Улс эдгээрийг нутагшуулах асуудалд онцгой анхаарах, хэрэгжүүлэх шаардлага үүссэн.

Монгол Улс болон Олон улсын нөхцөлийг харьцуулах нь

Монгол Улсын кибер аюулгүй байдлын орчин олон улсын жишигтэй харьцуулахад сул хэвээр байна. Тухайлбал, АНУ болон Европын холбоо кибер халдлагатай тэмцэх өндөр технологи, санхүүгийн хүчтэй дэмжлэгтэй байгаа бол Монгол Улсад технологийн хязгаарлагдмал байдал, хөрөнгө оруулалтын дутагдалтай байдалд байна.

Олон улсын туршлагыг харвал төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, кибер аюулгүй байдлын боловсрол олгох хөтөлбөрүүд илүү үр дүнтэй хэрэгжиж байгааг анхаарах хэрэгтэй. Монгол Улс эдгээр туршлагыг нутагшуулах, дотоодын хууль эрх зүйн орчныг сайжруулах тал дээр илүү их анхаарах нь зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Кибер орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд нь хувь хүнд чиглэсэн энгийн фишингийн залилангаас эхлээд томоохон корпорациуд, төрийн байгууллага, чухал дэд бүтцэд чиглэсэн нарийн түвэгтэй халдлагуудаас бүрдэж байна. Тухайлбал нэр томьёоны хувьд:

Фишинг ба Спир-Фишинг

Энэ нь хэрэглэгчдийг хуурч, нууц үг, санхүүгийн мэдээлэл зэрэг эмзэг мэдээллийг залилах аргаар олж авдаг кибер гэмт хэргийн нэг хэлбэр юм. Спир-фишинг нь тодорхой хувь хүн эсвэл байгууллагад чиглэсэн халдлага бөгөөд халдагч этгээд сошиал медиа болон урьд өмнөх харилцааг ашиглан хуурч мэхлэхийг оролддог. Халдагч этгээд банк, хамт ажиллагсад, үйлчилгээ үзүүлэгчээс мэйл ирж буй мэт төстэй зурвас илгээж, хохирогчийг веб холбоос дээр даруулах эсвэл хавсарган явуулсан файлыг татаж авахыг уриалдаг. Ингэснээр хувь хүн, байгууллага эмзэг нууц мэдээллээ алдах, санхүүгийн хохирол амсах, өгөгдөл алдагдах аюултай.

Рансомвэр: Энэ нь тусгайлан бэлтгэсэн программ хангамжаар хохирогчийн файлыг нууцлан эсвэл системийг түгжиж эргээд хэвийн ажиллагаатай болохын тулд төлбөр төлөхийг (ихэвчлэн крипто вальютаар) шаарддаг гэмт хэрэг юм. Халдагч фишинг мэйл, сүлжээний сул тал эсвэл програмын алдааг ашиглан системд нэвтэрнэ. Үүний дараагаар файлыг шифрлэн, системийг түгжин тодорхой хэмжээний төлбөр өгөхийг шаардана.

Шаардлагын мэдэгдэлд ихэвчлэн төлбөр төлөхгүй бол мэдээллийг устгах аль эсвэл задруулна гэж сүрдүүлэх замаар хэрэгжүүлдэг. Ингэснээр байгууллагын үйл ажиллагааг тасалдуулж, санхүүгийн хохирол учруулан, нэр хүндэд нь халдах бүрэн боломжтой. Эрүүл мэнд, эрчим хүч, боловсролын салбарууд энэ төрлийн халдлагад өртөх нь хамгийн их аюултай бөгөөд үүнээс болж чухал мэдээлэл алдагдан цаашлаад олон хүний амь нас эрсдэлд орж болзошгүй.

Хувь хүний мэдээлэл хулгайлах

²¹ Enisa Threat Landscape 2023

²² National Center of Incident Readiness and Strategy for Cybersecurity

²³ NISC Report 2023

Хувь хүний мэдээлэл хулгайлах гэмт хэрэг нь хэн нэгний хувийн мэдээллийг ашиглан санхүүгийн ашиг хонжоо олохын тулд тухайн хүнийг дуурайхад оршино. Хувийн мэдээллийн алдагдал гэдэг нь нууцалсан өгөгдөл (регистрийн дугаар, банкны картын мэдээлэл, өвчиний түүх г.м) зөвшөөрөлгүйгээр задрахыг хэлнэ.

Гэмт хэрэгтнүүд хохирогчийг хакердан, фишинг хийх, эсвэл нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах замаар хувийн мэдээллийг нь хулгайлна. Хулгайлсан мэдээллээ банкны данс нээх, худалдан авалт хийх, залилангийн гэмт хэрэг үйлдэх зэрэгт ашигладаг. Үүний улмаас хохирогч санхүүгийн хохирол амсаж, зээлийн эрхээ бууруулах, сэтгэл санааны хохирол амсах аюултай. Байгууллагууд нэр хүндээ алдах, хэрэглэгчдийн итгэлийг алдах цаашлаад хуулийн хариуцлага хүлээх эрсдэлтэй байдаг.

Хортой программ (Malware)

Хортой программ гэдэг нь системийг эвдэх, нууцаар хандах зорилгоор бүтээгдсэн программ юм. Үүнд вирус, өт, троян, тандах, зар сурталчилгааны зэрэг программууд багтдаг.

Хортой программ нь ихэвчлэн и-мэйл, халдварлагдсан файл, вэбсайтаар дамжин төхөөрөмжинд нэвтэрдэг. Нэвтэрснийхээ дараа мэдээлэл хулгайлах, хэрэглэгчийн үйлдэлийг хянах аль эсвэл арын хаалга үүсгэх замаар халдагч этгээдийг төхөөрөмжинд нэвтрэх боломжийг олгодог. Хортой программ нь системд алдаа үүсгэх, мэдээллийг алдагдуулан задруулах, санхүүгийн алдагдал учруулах эрсдэлтэй бөгөөд бусад төрлийн халдлага үйлдэх нөхцөлийг бий болгох, эмзэг мэдээллийг хулгайлах, хэрэглэгчийг бүх талаар хянах тандах боломж үүсгэж байдаг.

DDoS халдлага

DDoS халдлага нь сервер эсвэл сүлжээг хэт ачаалуулж, хэрэглэгчдийг үйлчилгээнд нэвтрэхэд нь саад хийхэд оршино. Хэрэглэгчийг дуурайсан хийсвэр төхөөрөмжүүд болох ботнетийг ашиглан энэ төрлийн халдлагыг үйлддэг.

Халдагчид ботнет ашиглан зорилтот сервер рүү их хэмжээний хандалт үүсгэнэ. Энэ хандалт нь ачааллыг ихэсгэн улмаар тухайн веб сайт, серверийг ажиллагаагүй болгоход хүргэнэ. DDoS халдлага нь байгууллагын үйл ажиллагааг зогсоож, орлого олох боломжийг хаах, хэрэглэгчийн сэтгэл ханамж бууруулах, нэр хүндээ алдах эрсдэлийг үүсгэдэг. Ихэвчлэн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, сүрдүүлэх, аль эсвэл бусад кибер халдлагыг нуун дарагдуулахад ашиглагддаг.

Бизнесийн цахим шуудангийн залилан (BEC)²⁴

BEC гэдэг нь байгууллагын удирдах ажилтан эсвэл итгэмжлэгдсэн хүн болон байгууллагын нэрийн өмнөөс и-мэйл ашиглан мөнгө нэхэх, тодорхой мэдээллийг ил болохыг хүсэх гэх мэт аргаар залилан үйлдэхийг хэлнэ.

Халдагчид маш үнэмшилтэйгээр дуурайлгасан хуурамч цахим хаягийг ашиглан, халдлагад өртөгч рүү хэт шавдуулсан, яаруулсан шинжтэй хуурамч и-мэйл илгээдэг. Ихэвчлэн ямар нэгэн мөнгөн шилжүүлэг төлбөр төлөхийг шаардах, эсвэл ямар нэгэн эмзэг мэдээллийг ил болгохыг хүссэн хүсэлтүүд байдаг. Энэхүү халдлага нь компаниудад олон тэрбумын хохирол учруулдаг. Нэн түрүүнд санхүүгийн албыг бай болгон, байгууллагын бүтцийн зохион байгуулалт, итгэлцлийг ашиглан үйлддэг.

Крипто олборлолтын нууц халдлага (Cryptojacking)

Крипто олборлолтын халдлага гэдэг нь хэн нэгний компьютер эсвэл төхөөрөмжийг зөвшөөрөлгүйгээр криптовалют олборлоход ашиглахыг хэлнэ.

²⁴ Business Email Compromise

Халдагчид төхөөрөмжид халдвартай холбоос ашиглан нэвтрэн, төхөөрөмжийг зөвшөөрөлгүй ашиглан крипто олборлох программ ажиллуулдаг. Энэ нь төхөөрөмжийн ажиллагааг удаашруулж, цахилгааны хэрэглээг огцом нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийн насжилтыг багасгадаг.

Хуурмаг байдал үүсгэх (Pretexting)

Хуурмаг байдал үүсгэх гэдэг нь хэрэглэгчийг хуурч тодорхой хуурмаг нөхцөл байдлыг үүсгэж, мэдээлэл гаргуулдаг арга.

Халдагчид үйлчилгээний ажилтан, лавлах мэт итгэл даах хүмүүсийн дүр үзүүлж, хохирогчоос нууц үг, дансны мэдээлэл, эсвэл бусад нууц мэдээллийг олж авдаг.

Энэ төрлийн халдлага нь хүний итгэлцлийг ашигладаг тул техникийн хамгаалалтаар сэргийлэх боломжгүй. Халдлага нь халдагч этгээдэд систем рүү нэвтрэх эрхийг олгоод зогсохгүй эмзэг мэдээллийг олж аван, цаашдын халдлага үүсэх нөхцөл байдлыг бий болгох эрсдэлтэй байдаг.

Кибер хорлон сүйтгэх ажиллагаа ба оюуны өмчийн хулгай

Кибер үйл ажиллагаа гэдэг нь оюуны өмч, бизнесийн нууц зэрэг өндөр үнэ цэнэтэй мэдээллийг зөвшөөрөлгүйгээр олж авах үйл ажиллагаа юм. Ихэвчлэн оюуны өмч, худалдааны нууц, бусад төрлийн өндөр үнэ цэнэ бүхий мэдээллүүдийг байгууллага, засгийн газар, худалдааны байгууллагуудыг өөрсдийн бай болгодог.

Халдагчид фишинг, хортой программ эсвэл зэргэлдээ халдлага зэрэг олон төрлийн арга ашиглан системд нэвтэрч, өгөгдлийг хуулбарлаж авдаг.

Кибер хорлон сүйтгэх дээрх ажиллагаанууд нь санхүүгийн хохирол учруулж, байгууллагын өрсөлдөх давуу талыг бууруулах төдийгүй үндэсний аюулгүй байдалд заналхийлэх эрсдэлтэй. Ихэвчлэн иргэд, байгууллагыг хорлон сүйтгэх ажиллагаа, эдийн засгийн дайн зэргээр илэрдэг.

Эдгээр кибер гэмт хэргийн төрөл бүр нь цахим систем болон хүний зан үйлийн тодорхой эмзэг байдлыг онилдог бөгөөд ажилтнуудыг сургах, аюулгүй байдлын нягт нямбай тогтолцоо бий болгох, системийг тогтмол хянах зэрэг цогц аюулгүй байдлын арга хэмжээ шаардлагатайг харуулж байна. Энэ төрлийн гэмт хэргүүдийн механизмыг ойлгосноор хувь хүн, байгууллагууд боломжит аюулаас илүү үр дүнтэй хамгаалах боломж бүрдэх юм.

Кибер аюулгүй байдал нь систем, сүлжээ, өгөгдлийг кибер халдлагаас хамгаалах үйл ажиллагаа бөгөөд байгууллагын хувьд кибер аюулгүй байдал нь оюуны өмч, харилцагчийн мэдээлэл, системийг хамгаалах үүрэгтэй.

Төр захиргааны байгууллагын хувьд олон нийтийн мэдээллийн аюулгүй байдал, төрийн нууц, байгууллагын нууцыг хамгаалах, хууль эрх зүйн тогтвортой ажиллагааг хангахад чухал ач холбогдолтой. Хувь хүний хувьд кибер аюулгүй байдлыг сахих нь нууцлал хамгаалах, санхүүгийн хохирол амсахаас сэргийлэх, өөрийн мэдээллийг хулгайлагдхаас урьдчилан сэргийлэх боломжтой.

Кибер гэмт хэргээс үр дүнтэй хамгаалахын тулд төр захиргааны байгууллага, хувийн хэвшилд техник хэрэгсэл, кибер аюулгүй байдлын шилдэг дадлуудыг суулгаж, хэрэглэгчдэд энэ талын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг олгох шаардлагатай. Гэмт хэргийн эрсдэлийг бууруулж, кибер халдлагаас хамгаалах дараах үр дүнтэй аргууд байдаг. Тухайлбал

Нууц үгийн аюулгүй байдлыг сайжруулах

Хүчтэй ба өвөрмөц нууц үг: Аливаа хаягийн нэвтрэх нууц үгэнд 12-16 тэмдэгтийн урттай, үсэг, тоо, тэмдгийг хослуулсан өвөрмөц, нарийн төвөгтэй нууц үг ашиглах хэрэгтэй.

Хоёр түвшний буюу олон түвшний баталгаажуулалт (2FA/MFA): Энэхүү хоёрдогч баталгаажуулалтын аргыг ашигласнаар аюулгүй байдлыг нэмэгдүүлнэ. Хурууны хээ эсвэл нэг удаагийн код ашиглах зэрэг байж болно.

Нууц үг хадгалагч ашиглах нь хэцүү, нарийн нууц үгсийг найдвартай хадгалан, шинэчлэхэд тусалдаг бөгөөд өвөрмөц нууц үгнүүдийг амархан зохиох, түүнийгээ найдвартай хадгалах боломжийг бий болгож байдаг.

Системийг шинэчлэх: Үйлдлийн систем, программ хангамж, төхөөрөмжийн микропрограммыг тогтмол шинэчлэн шинэ хувилбарыг суулгаснаар кибер гэмт хэрэгтнүүдийн ашиглаж болзошгүй сул орон зайг хаах боломжтой.

Автомат шинэчлэлтийн тохиргоо: Вирусын эсрэг программ хангамжын автомат шинэчлэлтийг идэвхжүүлснээр хамгаалалтыг цаг тухай бүрт нь шууд идэвхижүүлэх бөгөөд төхөөрөмжийн халдлагад өртөх боломжтой эмзэг байдлыг бууруулна.

Кибер халдлагын аюул өсөн нэмэгдэхийн хэрээр кибер аюулгүй байдлын технологи, арга барилууд ч сайжирсаар байгаа бөгөөд зөв тохиромжтой аргуудыг сонгосноор энэ төрлийн халдлагаас бүрэн сэргийлэх боломжтой. Дээрх аргуудаас гадна хиймэл оюун ухаан, машин тооцоолол (Machine learning) зэргийг халдлагыг илрүүлж, хариу хамгаалалтын арга хэмжээ авах шинэ төрлийн хамгаалалтын аргыг ч ашиглаж болно. Мөн блокчейн технологи ашиглан цахим гүйлгээнд илүү аюулгүй байдал авчирч буй дэлхийн туршлагууд ч байдаг.

Дүгнэлт. Кибер гэмт хэрэгтэй тэмцэх нь зөвхөн нэг салбарын бус, олон талын оролцоог шаардаж байдаг онцлогтой. Энэ төрлийн гэмт хэрэг өсөн нэмэгдэж буй энэ үед кибер аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх идэвхтэй арга хэмжээ авах нь нэн чухал юм. Шинээр гарч буй аюул заналыг судлан, аюулгүйн дадлуудыг хэрэгжүүлснээр хувь хүн болон байгууллагууд энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлээ бууруулах бүрэн боломжтой. Кибер аюул занал байнга өөрчлөгдөж байгаа энэ үед кибер аюулгүй байдалд сэрэмжтэй байж, урьдчилан сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлаа хангах нь чухал ач холбогдолтой юм.

Цахим хэрэглэгчид байнгын мэдээлэлтэй байж, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэгтнүүдэд боломж бага олгож өөрсдийн сул талыг бууруулах, улмаар кибер гэмт хэргийн байнгын заналаас хамгаалагдах боломжтой юм.

Монгол Улсад кибер аюулгүй байдлыг хангах тал дээр тодорхой ахиц дэвшил гарсан ч бодит эрсдэлүүд байсаар байна. Хувь хүн болон байгууллагууд өөрсдийн систем, өгөгдлийн аюулгүй байдлыг хангах үүрэг хариуцлагаа ухамсарлах нь чухал юм. Энэ хүрээнд кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, технологийн шинэчлэлийг дагаж мөрдөх, олон улсын сайн туршлагыг судлах, хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Санал

1. Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх.

2. Кибер аюулгүй байдлын чиглэлээр мэргэжилтэн сургах, давтан сургалт явуулах, чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд анхаарах.

3. Төр болон хувийн хэвшил мэдээллийн технологийн дэд бүтэцийг сайжруулах, хамгаалалтын дэвшилтэт шийдлүүдийг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

4. Кибер аюулгүй байдлын чиглэлээр олон улсын түвшинд хамтран ажиллах, шилдэг туршлагыг судлах. Бусад улс орны энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшил, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох.

5. Олон нийтийн кибер аюулгүй байдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, соён гэгээрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг саналуудтай.

Ашигласан материал:

1. Монгол Улсын цагдаагийн ерөнхий газрын кибер гэмт хэргийн статистик 2023.
2. ENISA-ENISA THREAT LANDSCAPE 2023
(https://securitydelta.nl/media/com_hsd/report/644/document/ENISA-Threat-Landscape-2023.pdf)
3. CISA - Cyber Incident Reporting for Critical Infrastructure Act of 2022
4. Статистик мэдээлэл: Монгол Улсын цагдаагийн ерөнхий газрын кибер гэмт хэргийн статистик.
5. Олон улсын тайлангууд: АНУ-ын CISA, Европын ENISA, Японы NISC-ийн тайлангууд.
6. Эрдэм шинжилгээний өгүүллүүд: Олон улсын кибер аюулгүй байдлын судалгаанууд.

**ХУУЛЬ БУСААР АН АГНАХ ГЭМТ ХЭРГИЙН
ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**
CRIMES COMMITTED BY JUVENILE PERSONS IN
CONDUCT OF TRACKING SOME ISSUES TO CONSIDER

Д.Бат-Эрдэнэ

*Дотоод хэргийн Их Сургуулийн Цагдаагийн
сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн ахмад*

Bat-Erdene.D

*Teacher of the Department of Criminal Procedure
Law of the University of Internal Affairs of Mongolia,
Police Captain*

Товч агуулга: Дэлхий нийтийн хурдацтай хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, хүн амын өсөлт зэрэг нь байгаль орчин, ан амьтан, уул ус, бэлчээр ургамал, зэрэгт сөрөг нөлөө үзүүлсээр байна. Хүний ухамсаргүй үйлдэл, шунайхан сэдэл, экологийн тэнцвэргүй байдал, хууль бус үйлдлийн улмаас ан амьтан ховордох, ан амьтны эд өлгийн зүйлийг хил дамнан худалдаалах замаар ашиг орлого олох, эрх зүйн орчин сул, иргэдийн хууль эрх зүйн орчин дутмаг байдал, олон шалтгааны улмаас гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөл бий болсоор байгаа тул судлаачийн зүгээс үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорилоо.

Abstract: Rapid global development, climate change, and population growth continue to have negative impacts on the environment, animals, mountains, and pastures. The researcher's aim is to assess and analyze the reasons for the commission of crimes due to unconscious human actions, greedy motives, ecological imbalances, the scarcity of animals due to illegal actions, the profit of animals through cross-border trade in animal products, the weak legal environment, the lack of a legal environment for citizens, and the reasons for committing crimes for a variety of reasons.

Түлхүүр үгс: Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, амьтан, ховор амьтан, нэн ховор амьтан, ангийн гаралтай түүхий эд,

Keywords: Specially protected areas of the state, animals, rare animals, very rare animals, raw materials of class origin,

Хууль бус ан агнах гэмт хэргийн ойлголт

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн”²⁵ гэж заажээ.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэг гэдэг нь байгаль орчин, байгаль хамгаалах болон амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцаанд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм.²⁶

²⁵ Төрийн мэдээлэл. 1993. №1. Монгол Улсын Үндсэн хууль

²⁶ Гантулга.С “Эрүүгийн эрх зүйн тусгай анги” / сурах бичиг/ -УБ.,2018. 443 дэх тал

Монгол хэлний товч тайлбарт: “ан” гэдэг нь алж ашиглах зэрлэг амьтад, “амьтан” гэдэг нь хөдөлж мэдэрч чадах бүгд юм гэж тайлбарласан.²⁷

Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл, ховор амьтанг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжтэй нэгжээс хорин долоо мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.²⁸

Амьтан: Монгол улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан, хөхтөн шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна.

Нэн ховор амьтан: Тархац нутагтаа бүхэлдээ эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах, нөөцгүй, устах аюулд орсон амьтныг ойлгоно.

Ховор амьтан: Тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг ойлгоно.

Ангийн гаралтай түүхий эд: Амьтны арьс, шир, үс, өд, эвэр, толгой, цус, өөх, тос зэрэг эд эрхтнийг ойлгоно.

Улсын тусгай хамгаалалттай газар нутаг: Дархан цаазат газар, Байгалийн цогцолбор газар, Байгалийн нөөц газар, Дурсгалт газар гэж ангилна.

Тусгай зөвшөөрөлгүй гэдэгт: Нэн ховор амьтныг төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болно. Энэ зориулалтаар агнаснаас бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно.

Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр ховор амьтныг дараах тохиолдолд агнаж барьж болно.

- Судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар,
- Монгол улсын болон гадаадын иргэн тусга төлбөр төлсөн,
- Тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор²⁹

Цагдаагийн байгууллагад 2013-2023 оны хооронд Хууль бусаар ан агнах нийт 706 гэмт хэрэг бүртгэгджээ. Энэ гэмт хэрэг нь Эрүүгийн хуульд заасан хүрээлэн буй орчны эсрэг нийт гэмт хэргийн 15.8 хувийг эзэлж Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн дараа хоёрдугаарт эрэмбэлэгдэж байгаа нь тоон мэдээнээс харагддаг. Энэ гэмт хэргийн 81.3 хувь нь орон нутагт үйлдэгдсэн байна. Гэмт хэргийн халдлагад өртөж, агнагдсан нийт 40 зүйлийн амьдтын 15.2 хувь нь буга, 7.6 хувь нь цагаан зээр (хар сүүлт), 7.4 хувь нь баавгай 8.5 хувь

²⁷ Оюунчимэг.Т “Криминалистикийн арга зүй”. -Уб.,2024. 287 дэх тал

²⁸ Төрийн мэдээлэл. 2016., №07. Монгол Улсын Эрүүгийн хууль

²⁹ Эрдэнэбаяр.М. “Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал” / сургалтын гарын авлага/ 2020. -Уб., 31 дэх тал

хойлог шувуу, 6.4 хувь нь янгир, 5.2 хувь нь хулан 4.2 хувь нь хотон шувуу 4.0 хувь нь цоохор ирвэс зэрэг нэн ховор, ховор амьтад байна.

Гэмт хэрэг гарсан газар нутгийн хувьд баруун бүсийн 5 аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн 17 буюу 7.9 хувь нь Завхан, 91 буюу 42.5 хувь нь Ховд 23 буюу 10.7 хувь нь Увс 44 буюу 20.6 хувь нь Баян-Өлгий, 39 буюу 18.2 хувь нь Говь-алтай тус тус бүртгэгдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэрэг нь хүний нүднээс далд эзгүй газарт үйлдэгддэг, гэрчлэх нотлох зүйлээр бага тул нуугдмал гэмт хэрэгт тооцогддог. Иргэдийн дунд аливаа өвчнийг эдгээдэг, намдаадаг, гэх мухар сүсэг, ам дамжсан цуу ярианаас үүдэн, түүнчлэн гоёл чимэглэл, чихмэл хийх болон гадаад улс руу гаргаж өндөр ашиг олох зорилгоор амьтны үс, яс, эвэр, чив засаа, сүүл, хошуу, толгой зэрэг эд эрхтнийг худалдахын тулд гэмт этгээдүүд агнах, түүхий эдийг хадгалдаг талаар албаны хүмүүс анхааруулж сэрэмжлүүлж байна.

Хууль бусаар ан агнах гэмт хэрэгт 10 жилийн хугацаанд 381 хүнийг гэм буруутайд тооцсоны 13.9 хувьд нь урьд гэмт хэрэг үйлдсэн этгээд дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн бол 25.7 хувь нь бүлэглэж үйлджээ.³⁰

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг үр дүнтэй хамгаалах, ажилчдын ажлын үнэлэмжийг бодит болгон үнэлэх, ажлын үр бүтээмжийг нэмэгдүүлэх үүднээс хуулийн хэрэгжилт, хяналт шалгалтыг SMART программаар зохион байгуулах арга зүйг нэвтрүүлэхээр боллоо. Уг SMART хяналт, шалгалтыг нэвтрүүлэх программ нь өдгөө дэлхийн 80 гаруй улсад, 1000 гаруй газар нутагт ашиглагдан технологийн дэвшлийг байгаль хамгаалах үйлсэд ашиглаж буй программ болно.

Тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлогын хэрэгжилтийг хангахын тулд үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлсний дүнд 2020 оны байдлаар Монгол улс нийт нутаг дэвсгэрийн 21 хувь буюу 32.7 сая га газар нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулаад байна. SMART/SMART (Spatial Monitoring and Reporting Tool)/ гэдэг нь Тусгай хамгаалалттай газар (ТХГ) нутгийн байгаль хамгаалагч хяналт шалгалтыг тодорхой орон зайд хийх, мэдээ /дата/ цуглуулах, түүнийгээ программд оруулж, нэгтгэж, дүн шинжилгээ хийх, дараагийн хяналт шалгалтын зорилтыг тодорхойлох, эргэн түүнийгээ тайлагнах, байгаль хамгаалах практикт өргөн хүрээний хэрэглээ бүхий гар утас, суурин компьютер, онлайн платформд суулгасан тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын цогц систем юм. (SMART, 2023).

Мөн биологийн олон янз байдлыг үр дүнтэй хамгаалахын тулд Байгаль хамгаалагч, ТХГ нутгийн захиргаа, олон нийт, эрх баригчид зэрэг бүх оролцогч талуудын оролцоог эрх тэгш олгодог хэрэглээний программ гэдгээрээ давуу талтай.³¹

2024 онд Монгол улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Хууль бусаар ан агнах 30, Нийслэлийн давж заалдах шатны шүүхээр 9, Хяналтын шатны шүүхээр гэмт хэрэг шийдвэрлэгдээгүй байна.³²

Шүүхийн шийтгэх тогтоолуудаас түүвэрлэн хэсэгчилэн авч үзвэл:

Холбогдсон хэргийн товч агуулга: Ховд аймгийн прокурорын газрын хяналтын прокурор Б.Хосбаяр “шүүгдэгч ***, *** нарыг бүлэглэн 2024 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Ховд аймгийн сумын *** багийн нутаг дэвсгэрт байх 48.037767, 93.236065 gps-ийн байрлал бүхий Хар-Ус нуурын улсын тусгай хамгаалалттай газар нутгаас 32 тооны “алтайн сугас” загасыг хууль бусаар агнасан нь нотлогдсон” гэж дүгнэн, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн

³⁰ Ergelt.mn/news/ Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, дэд профессор М.Эрдэнэбаярын ярилцлага хэсгээс 2024.05 сар

³¹ Нарангуа.Б. “Улсын тусгай хамгаалалттай газар нутагт хуулийн хэрэгжилт, хяналт 2 шалгалтыг SMART программаар зохион байгуулах арга зүй” -УБ., 2023. 6 дахь тал

³² contact@judcouncil.mn “Монгол улсын цахим шүүхийн сан”

3.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан тэдгээрийн үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зүйлчлэн, яллах дүгнэлт үйлдэж ирүүлжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 260 дугаартай тогтоолын 1 дүгээр хавсралтаар алтайн сугас загасны үнэлгээг 15'000 төгрөгөөр тогтоосон байна. Тодруулбал шүүгдэгч ***, *** нар бүлэглэн 32 тооны алтайн сугас загас агнаж нийт 480'000 (=15'000₮*32) төгрөгийн хохирол байгаль орчинд учруулжээ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалтад зааснаар амьтны аймагт учирсан хохирлыг тухайн амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр нөхөн төлүүлэхээр, мөн Амьтны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт зааснаар амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтоосон амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг хоёр дахин өсгөж тогтоохоор тус тус хуульчилсан. Иймд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг 2 дахин нэмэгдүүлж шүүгдэгч нараас 960'000 төгрөгийг гаргуулах үндэслэлтэй.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан Байгаль орчин, уур амьсгалын санд оруулахаар, мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3-т зааснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэхээр тус тус журамласан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигт шүүгдэгч ***-аас 480'000 төгрөгийг, шүүгдэгч ***-аас 480'000 төгрөгийг гаргуулж Байгаль орчин, уур амьсгалын санд шилжүүлэхээр шийдвэрлэснийг шүүгдэгч нар эрүүгийн хариуцлагын шүүх хуралдаанаас завсарлага авч төлсөн болно.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан шүүгдэгч ургийн овогт, ургийн овогт нарыг бүлэглэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсугай.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч ***-ыг 1 (нэг) жил 6 (зургаа) сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялаар, шүүгдэгч ***-ыг 1 (нэг) жилийн хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялаар тус тус шийтгэсүгэй.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч ***, *** нарт оногдуулсан зорчих эрхийг хязгаарлах ялыг Ховд аймгийн сумын нутаг дэвсгэрээс гарахыг хориглохоор тогтоосугай.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1, 3, 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч нарын гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан ХОЕ улсын дугаартай Toyota prius-20 загварын автомашины үнэлгээ болох 9'658'125 төгрөгийг тэнцүү хэмжээгээр буюу шүүгдэгч ***-аас 4'829'062.5 (дөрвөн сая найман зуун хорин есөн мянга жаран хоёр арваны таван) төгрөгийг, шүүгдэгч ***-аас 4'829'062.5 (дөрвөн сая найман зуун хорин есөн мянга жаран хоёр арваны таван) төгрөгийг тус тус албадан гаргуулж Байгаль орчин, уур амьсгалын санд шилжүүлсүгэй.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч нарын гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан болон гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох хэрэгт эд мөрийн баримтаар тооцогдож ирсэн 110 см урттай, 36 см төмөр хүрз нэг ширхэг, 130 см

урттай төмөр лоом нэг ширхэг, цагаан өнгийн даавуун ууттай шороо мэт зүйл хоёр ширхэг, ногоон өнгийн тааран ууттай 32 (гучин хоёр) ширхэг алтайн сугас загасыг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц устгахыг тус шүүхийн эд мөрийн баримт шийдвэрлэх комисст даалгасугай.

Шүүгдэгч нар нь зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож солихыг мэдэгдсүгэй.

Шүүгдэгч ***, *** нар энэ хэрэгт цагдан хоригдоогүй болохыг дурдаж, шүүгдэгч нарт авсан хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл үргэлжлүүлсүгэй.

Шүүгдэгч нараар нөхөн төлүүлэх хохирол, хор уршиггүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалгүй, хэрэгт битүүмжилсэн эд хөрөнгөгүй болохыг дурдсугай.

Шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болмогц хэрэгт эд мөрийн баримтаар тооцож ирүүлсэн хар өнгийн түрийтэй, цагаан өнгийн ноосон дотортой, размер тодорхойгүй, хуучин нэг хос гутлыг шүүгдэгч ***-д, саарал өнгийн үстэй, саарал өнгийн оруулгатай, размер тодорхойгүй хуучин нэг хос гутлыг шүүгдэгч ***-ад тус тус буцаан олгож, олон тооны цагаан өнгийн хөөсөнцөр жижиг зүйлтэй ногоон өнгийн дөрвөлжин нүхтэй, нарийн сатуркан загасны (хоёр хэсэг болсон) торыг холбогдох байгууллагад хүргүүлэхээр Ховд аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсүгэй.

Шийтгэх тогтоолыг эс зөвшөөрвөл гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор Ховд аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны шүүхээр дамжуулан оролцогчид давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, түүний дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй болохыг дурдсугай.³³

Экологийн цагдаагийн алба нь Монгол улсын засгийн 2020 оны 03 дугаар тогтоол, Хууль зүй дотоод хэргийн сайдын мөн оны А/09 дүгээр тушаалаар төв байгууллагын бүтцэд хүрээлэн байгаа орчны хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр байгуулагдсан

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/17 дугаар тушаалаар Захиргааны удирдлагын, Эрүүгийн цагдаагийн, Зөрчил шалган шийдвэрлэх, Урьдчилсан сэргийлэх, хамтын ажиллагааны гэсэн 4 хэлтэс, 21 аймаг, 64 суманд экологийн асуудал хариуцсан алба хаагчтайгаар бүтэц, зохион байгуулалтыг баталсан. Мөн даргын 2020 оны Б/173 дугаар тушаалаар Мөрдөн байцаах албаны Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийг тус албанд шилжүүлсэн байна.³⁴

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1985 оны 12-р сарын 23-ны 340 дүгээр тогтоолоор 23 зүйлийн хөхтөн, 19 зүйлийн шувуу, 6 зүйлийн хоёр нутагтан ба хэвлээр явагчид, 2 зүйлийн загас, 86 зүйлийн ургамлыг багтаасан "БНМАУ-ын улаан ном"-ыг буй болгохоор шийдвэрлэсэн нь 1987 онд биелэлээ олсон юм.

Харин шинэчилсэн хувилбар 1997 онд олны хүртээл болсон байна. Монгол Улсын Улаан номыг хамгийн сүүлд 2013 онд шинэчилжээ. Уг "Улаан ном"-нд 110 зүйлийн амьтан, 192 зүйлийн ургамал бүртгэгджээ. Шинээр бүртгэгдсэн 25 зүйлийн амьтдын дотор шинээр шилүүс, суусар булга, ойн булга, хүрэн баавгай зэрэг зургаан хөхтөн, цагаан тогоруу одой галуу, ооч ёл зэрэг 18 зүйл шувуу, эгэл загалмайт могой гэсэн 1 зүйлийн мөлхөгч багтсан

³³ https://shuukh.mn/single_case "шийтгэх тогтоол"

³⁴ <https://police.gov.mn/> Экологийн цагдаагийн албаны түүхэн замнал

байна. Харин 192 зүйлийн ургамалд 95 зүйлийн дээд ургамал, 5 зүйл хаг, 11 зүйл хөвд, 6 зүйл мөөг, 13 зүйл замаг бүртгэгджээ.³⁵

Нэн ховор амьтдын жагсаалт: Цөөвөр чоно /Cuon Alpinus Pallas/ Умардын халиу /Lutra lutra Linnaeus/ Монгол бөхөн /Saiga tatarica mongolica/ - Соргор бөхөн /Saiga tatarica tatarica/ Хавтгай /Camelus ferus, Przewalskii/ Зэгсний гахай /Sus Scorfa nigripes blanford/ - Уссурийн Хандгай /Alces alces cameloides milne-Edwards/ Цоохор ирвэс /Uncia uncial/- Хар сүүлт зээр /Gazella subgutturosa guldenstead/ Мазаалай /Ursus pruinosis Blyth/ Тахь /Equus przewalskii Poliakov/ Азийн минж /Castor fiber birulai Serebrennicov/ Монгол хулан /Equus Hemionus Hemionus pallas/ - Шивэр хандгай /Alcesalces pfizenmayeri/ - Мөрний хандгай /Alces cameloides/ - Цаа буга /Pangifer tarandus valentinae/³⁶

Ховор амьтдын жагсаалт: Монгол Улсын улаан номд зааснаар ховор амьтанд

- Дорнын сармаахай, говийн еврази шилүүс, суусар булга, ойн булга, эрээн хүрнэ, хүрэн баавгай, Монгол хулан адуу, зэгсний зэрлэг гахай, Алтайн аргаль, янгир ямаа, хар сүүлтий, элсний тажигдаахай, соотон алагдай, сухайн чичүүл, зэрэг **хөхтөн**,

- Одой галуу, байгалийн нугас, ундар шумбуур, хан бүргэд, ооч ёл, Азийн цууцил, Монгол Хуланжороо, хонин тоодог, усны бух шувуу, бичил одой бух, зээрд дэглий, манхин галуу, гэзэгт нугас, хуруут хун, Хархираа тогоруу, цагаансүүл, Нөмрөгбүргэд, Алтайн хойлог, Зэрлэг гургуул, загийн бор шувуу, ойн шийнүүхэй, шагшуурын шарсүүлт, өгөөлэй, шулганаа, наран хөмрөг, шарэлэгт хөмрөг зэрэг **шувуу**,

- Говийн махир хуруут гүрвэл, тойрмын хонин гүрвэл, толбот могой гүрвэл, тэмээн сүүл могой, нарийн могой, эгэл загалмайт могой зэрэг **мөлхөгч**,

- Шивэр гүлмэр, ногоон бах, модны мэлхий, дорнодын мэлхий зэрэг хоёр нутагтан, шивэр хилэм, тул Монгол омуль, зантахай загас-зэрэг загас, Номхон далайн могой-дугуй амьтан, Хар мөрний хавч, голын хавч-зэрэг хавч хэлбэртэн, дамнуурга цэнхэр соно, шүтээн цох, Дорнын заарт эвэрт цох, аполлон, эверсманнны дэвүүр, штурббендорфын дэвүүр, фэб дэвүүр, Зүүн Сибирийн дэвүүр, махан дэвүүр, бага тогосон одот, эгэл хошуулаг шумбуур, инжирийн шумбуур, бэр цэцэгч шумбуур, голт борын шумбуур, хөвдний үхэр хэдгэнэ, модестус үхэр хэдгэнэ, спорадикус үхэр хэдгэнэ, байгалийн үхэр хэдгэнэ, их эрлэг ялаа- зэрэг шавьж, дагуурын судван хясаа, Сэлэнгийн татан хясаа, Монгол танан хясаа- зэрэг зөөлөн биетэн хамаарна.³⁷

Хууль бусаар амьтан агнах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа. Хууль бусаар ан агнах гэмт хэрэг ихэвчлэн ой тайга, хээр тал зэрэг хүний нүднээс далд газар оронд нуугдмал үйлдэгдэх учраас энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээллийг олж авах идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь зүйтэй.

Мэдээллийг янз бүрийн эх сурвалжаас авч болох бөгөөд мэдээллийн эх сурвалж нь хууль бусаар ан агнах гэмт хэргийг илрүүлэх боломжийн нэгээхэн хэсэг юм. Эдгээрт нутгийн иргэд, цэргийн алба хаагчид, хууль хэрэгжүүлэгч байгууллагын албан тушаалтнууд (Мэргэжлийн хяналт, гаалийн байцаагч, байгаль хамгаалагч) зар сурталчилгааны мэдээлэл ч орно.

Гэмт үйлдлийн болон нуун далдлах арга: Амьтны тухай хуулинд амьтан агнахад хориглосон тодорхой аргуудыг заасан. Тухайлбал агаарын болон авто тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх, ус хужир, мараанд ирдэг буцдаг зам дээр нүх ухах, буу сойх, сааль тавих, ахуйн зориулалтаар загас барихад тор, хаалт хашлага, гувчуур, буу, бамбар хэрэглэх, гол

³⁵ <https://mn.wikipedia.org/wiki> /Монгол улсын улаан ном

³⁶ <http://touristinfocenter.mn/news> “Нэн ховор амьтдын жагсаалт”

³⁷ Энхболд. Б “Эрүүгийн эрх зүй тусгай анги /сурах бичиг/. УБ.2018.444 дэх тал

мөрөнд завь ашиглах, химийн болон тэсэлгээний бодис хэрэглэх, анд сургасан нохойгоор ан хийх, туурайтан амьтдыг цасанд умбуулах, мөсөнд халтируулах, хясаа эрэг ганга уруу нисгэх, унагах зэрэг аргыг нэрлэж болно.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал: (газар орон, цаг хугацаа, ул мөр) Монголчууд он удаан жил ан хийж ирсэн уламжлал нь эр хүн бүрийн цусанд нь шингэж, амьтан авлах, сонирхол монгол эр хүнд байдаг. Жишээ нь хөдөө орон нутагт нутгийн иргэд малд явахдаа хээрийн амьтан бэлчээрийн малаас үргэдэггүй онцлогийг ашиглан байнга буу авч явж ан тааралдвал агнадаг.

Манай орны ойн бүсийн анчид нохойгоор гахай, баавгай, буга, тураг зэргийг хоргоох, хаших, үргэх, ээрэх, барих зэрэгт ашигладаг бол, тал хээрийн анчид тарвага, үнэг зэрэг амьтдыг нохойгоор бариулдаг, казак иргэд бүргэдээр ан хийх уламжлалтай.

Амьтан агнах гэмт хэрэг нь эзгүй ой хээр тал газарт ихэвчлэн шөнийн цагаар, бусдад мэдэгдэлгүй үйлддэг, амьтны эд эрхтнийг худалдаалах үйлдлийг мөн л нүднээс далд хийдэг тул ихэнхдээ нуугдмал шинжийг агуулж байдаг.

Ан амьтанг хууль бусаар агнахдаа тээврийн хэрэгсэл ашиглахаас гадна ашигладаг зэвсэг, хэрэгслийг зориулалтаар нь:

1. Галт зэвсэг
2. Ан амьтан өөрөө баригч хэрэгсэл
3. Амьдаар баригч, багаж хэрэгсэл
4. Амьтнаар бариулах
5. Туслах чанарын хэрэглэл гэсэн төрлөөр хуваан авч үзэж болно.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал зорилго: Хууль бусаар ан агнах гэмт хэргийг эрэгтэйчүүд үйлддэг бол амьтны эд эрхтэн худалдаалах гэмт үйлдэлд эмэгтэйчүүд оролцдог байна.

Насны хувьд 35-40 орчим насныхан голчлон үйлдэж байгаа бол, хүний нас ахих тусам гэмт хэрэг үйлдэх идэвхи нь буурдаг тул 45-аас дээш насныхан энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх нь харьцангуй бага ажээ. Гэмт хэрэг үйлдэгчийн 60 орчим хувь нь бүлэглэн үйлдсэн ба гүйцэтгэсэн, 1.7 хувь нь урьд нь ял шийтгэгдсэн хүмүүс, 1.0 хувь нь согтуугаар үйлдсэн байна.

Гэмт хэргийн хохирогчийн хувийн байдал, хор уршиг: Хууль бусаар ан агнах, амьтны эд эрхтэн худалдаалах гэмт хэргийн хувьд хохирогчийн асуудал онцлог бөгөөд уг гэмт хэргийн хохирогч нь төр буюу төрийг төлөөлсөн байгууллага, байгууллагыг төлөөлсөн иргэний нэхэмжлэгч хувь хүн байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл: Хүн өөрөө байгалийн бүтээгдэхүүн төдийгүй байгалийн баялгийг ашиглан оршин тогтнох, амьдрах хэрэгцээгээ хангадаг. Хүн амын тоо өсөхийн хирээр хүний хэрэгцээ урьд байгаагүй ихээр нэмэгдэж, амьжиргааны түвшин доройтсон, ажилгүйдэл, ядуурал газар авсан нь байгальруу хууль бусаар халдах гол шалтгаан болж байна. Хууль бусаар ан агнах, амьтны эд эрхтэн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцлийн нэг нь амьтны эд, эрхтэн борлуулах худалдааны сүлжээ, захууд юм.³⁸

Байгалиа энэрэн хүндэтгэх ёс заншлын хүрээнд ан амьтан, ой модыг хайрлан хамгаалах, зан үйл нэн чухал байр суурьтай байсаар иржээ. Монголчууд ан ав хийж аж төрсөөр ирсэн уламжлал нь тэдний амьдралын нэгэн хэв шинж, нүүдэлчин ардын амьдрал ахуйн нэг онцлог юм.

³⁸ Оюунчимэг.Т “Криминалистикийн арга зүй” УБ. 2024. 261 дахь тал

Ан амьтныг авлаж аж төрөх ёсон энэрэн хүндэтгэх, танин мэдэхүйн ухааралд хатуу тулгуурлаж байжээ. Ан амьтныг авлах, ан гөрөөнд мордохдоо хоослон үгүйрүүлэх, сувдаглан, шунахайрах, олз ашиг эрэлхийлэх, ямар нэгэн бодол санаа огтхон ч байгаагүй, харин хангайн хишгийг зөв хүртэж амьдрал ахуйгаа байгалийнхаа баялгаар тэтгэх, энэ үзэл санаа үеийн үед уламжлагдан дамжих бодол ухааралд хөтлөгддөг байжээ.

Ан амьтны үржих төлжих, үс арьс, тарга хүч гүйцэх цаг хугацааг нарийн танин мэдэж, зөв сонгон авч, ан ав хийдэг, ангийн мах, арьс зэрэг олзвороо туйлаас хүндлэн ариглан хэрэглэдэг хатуу тогтсон уламжлалтай, олноороо ан гөрөөнд мордохдоо хүндэтгэлийн ёслол үйлддэг дэг жаягтай, зөрчих ахул зан заншлын төдийгүй хууль цаазын цээрлэл хүлээлдэг байсан нь дээр дурдсаныг нотлох жишээ болно.

Ахмад анчдын яриа, тэмдэглэлээс үзэхэд, өвөг дээдэс ан ав хийхээр мордохдоо товлосон өдрөө урьдаас нийтэд зарлан мэдээлдэггүй, зөвхөн өөр хоорондоо ойлголцох дохио тэмдэг болгож адууны хомоол солилцдог, анд явж байхдаа хараалын үг хэлдэггүй, хэрүүл маргаан хийдэггүй, тэр ч байтугай авлах амьтнаа ч шууд нэрлэдэггүй, жишээ нь бугыг “тураг”, чоныг “хээрийн нохой”, үнэгийг “малгай”, хандгайг “хавтгай эвэрт” гэх мэтээр хүндэтгэн нэрлэдэг, ангийн олзворыг “хангайн хишиг” хэмээн нэрийдэж, түүндээ мэрэг төлөг тавиулдаг байжээ. Энэ бол амьтныг хүний оюун ухааны хүчээр эзэрхэн түрэмгийлэх гээгүй, байгаль дэлхийдээ, түүнд оршин амьдардаг ан амьтнаа хайрлан хүндэлсээр байсныг илчлэх зан үйлийн тогтсон хэв шинж болж байжээ.³⁹

Дүгнэлт. Хууль бусаар ан агнах гэмт хэрэг нь ихэвчлэн нууц далд аргаар үйлдэгддэг, мөн уг хэрэгт хохирогч байхгүй, хууль хүчний байгууллагад мэдээлэл өгөх иргэд ховор, байгаль хамгаалагч, орон тоо бага, байгаль орчинд хүрч ажиллах нь хомс учраас гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөл бий болж байна.

Улсын тусгай хамгаалалттай газар болон Монгол улсын нутаг дэвсгэрт тархан суурьшдаг амьтдыг хамгаалах ажлыг цахимжуулж, смарт технологи ашиглаж, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулах, оршин суугч иргэд, байгаль хамгаалагч, сум орон нутагт байгаа төрийн алба хаагчдын хамтын ажиллагааг дээшлүүлж цогц арга хэмжээ авах шаардлагатай.

Сүүлийн 1 жилийн хугацаанд шүүхээр Хууль бусаар ан агнасан гэмт хэргийн шалтгаан нөхцөл нь иргэд өөрсдийн ашиг сонирхлын дагуу ховор, нэн ховор амьтанг алах, ангийн махыг ямар нэгэн өвчнийг анагаах ид шидтэй, амьтны эд өлгийн зүйлийг худалдаалж ашиг орлого олох, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, төрийн эрх бүхий байгууллагаас ямар нэгэн зөвшөөрөл авахгүйгээр гэмт хэрэгтэн тухайн үйлдлийг урьдаас төлөвлөж бэлдсэн, бүлэг этгээдүүд оролцсон, оролцогч нь нарын үйлдэл оролцоо, ажлын хувиарилалт, зэрэг нөхцлийг урьдаас тооцоолон судалгаа хийж, гэмт хэргийг хэзээ хэдийд, ямар орчин нөхцөлд юу ашиглаж үйлдэх, маш нарийн зохион байгуулалтын нэгдлийн дор олон хүн оролцож, уг гэмт хэргийг үйлдэж болзошгүй байгаа учир нь байгаль хамгаалагч, нутгийн иргэд, хууль хүчний байгууллагууд хамтын ажиллагаагаа сайжруулах, энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ял, хариуцлагыг асуудлыг хүндрүүлэх хэрэгцээ шаардлагатай байна.

Ашигласан материал:

Ном, сурах бичиг, гарын авлага

³⁹ Амархүү.О. “Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз” УБ.2022. 32 дахь тал

1. Гантулга.С “Эрүүгийн эрх зүйн тусгай анги” / сурах бичиг/ УБ.2018
2. Оюунчимэг.Т “Криминалистикийн арга зүй” УБ.2024.
3. Эрдэнэбаяр.М. “Хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал” / сургалтын гарын авлага/ 2020.
4. Энхболд. Б “Эрүүгийн эрх зүй тусгай анги /сурах бичиг/. УБ.2018.
5. Амархүү.О. “Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз” УБ.2022.

Цахим эх сурвалж:

6. <https://mn.wikipedia.org>
7. <http://touristinfocenter.mn>
8. www.legalinfo.mn
9. <https://information.police.gov.mn>
10. <https://judcouncil.mn>
11. <https://shuukh.mn>
12. <https://Ergelt.news.mn>

ГАДААДЫН ЗАРИМ ОРОНД МӨРИЙТЭЙ ТОГЛООМ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ,
ТҮҮНД ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ
DESIGN GAMES WITH HORSES IN SOME FOREIGN
COUNTRIES THE LEGAL STATUS OF ORGANIZED
CRIMES, A COMPARATIVE STUDY OF IT

Т.Саруултөгс
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга: Мөрийтэй тоглоом зохион байгуулах явдлыг дэлхийн улс орнуудад хууль эрх зүйн хүрээнд хуульчилсан байдлыг харьцуулан судалж, өөрийн улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход шаардлагатай шинэлэг санал, санаачилга гаргахыг зорьсон.

Abstract: The purpose of the study is to compare the legalization of gambling in countries around the world, and to make innovative proposals and initiatives necessary to improve the legal regulation of your country.

Түлхүүр үгс: Мөрийтэй тоглоом, лоттерей, казино, морин уралдаан, эрүүгийн хууль, эрх зүйн зохицуулалт.

Keywords: Gambling, lottery, casino, horse racing, criminal law, legal regulation.

Үндсэн хэсэг. Мөрийтэй тоглоомын явдлыг гэмт хэрэгт тооцох эсэх нь тухайн улсын эрх зүйн орчин, нийгэм эдийн засгийн байдал, нийт гэмт хэргийн бүтцэд эзлэх хувь, нийгэмд үзүүлэх хор хөнөөл болон бусад нөхцөл байдлыг харгалзан дэлхийн улс орнуудад янз бүр байдаг байна. Дэлхийн улс орнуудад мөрийтэй тоглоомыг хэрхэн зохицуулдаг талаар авч үзье. Үүнд:

Америкийн нэгдсэн улсын эрх зүйн орчин:

Америкийн нэгдсэн улсын зарим муж улсууд нь мөрийтэй тоглоомыг гэмт хэрэгт тооцдог бол өөр бусад муж улсууд нь гэмт хэрэгт тооцдоггүй байна. Тухайлбал Нью-Йорк муж улсын Эрүүгийн хуулийн 225.05 дахь хэсэгт “...Мөрийтэй тоглоом зохион байгуулах нь хууль бус гэдгийг мэдсэн төдийгүй, уг үйлдлээс хууль бус ашиг олсон нь тогтоогдсон бол...”, 225.10 дахь хэсэгт “...Өдөрт нэгээс таван удаа 5000 доллар болон түүнээс дээш мөрий тавих нөхцөлтэйгөөр мөрийтэй тоглоом зохион байгуулах эсвэл тоглоомд оролцох, хүний мөнгөөр тоглох, бусдын нэрийн өмнөөс тоглох, өдөрт 1 тоглолтдоо 500 болон түүнээс дээш доллароор тоглох нь хууль бус гэдгийг мэдсэн төдийгүй уг хууль бус үйл ажиллагаанаас ашиг олсон нь тогтоогдсон бол...” эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна. Мөн түүнчлэн мөрийтэй тоглоомыг анх удаа зохион байгуулсан бол хөнгөн, давтан зохион байгуулсан бол хүнд гэмт хэрэгт тооцдог байна.⁴⁰

Мөрийтэй тоглоомын төхөөрөмжийг зарсан, шилжүүлсэн, байраар хангасан, гэрээ хэлцэл байгуулсан, хамтран болон удирдаж ажилласан этгээд зэрэгт хөнгөн гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг нарийвчлан тодорхойлж өгчээ.

⁴⁰ Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Т.Золбоо, Б.Батбаяр, Б.Тамир, “Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль”, Уб., 2021

Оросын Холбооны Улсын Эрүүгийн хууль:

1996 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн 171.2 дугаар зүйлд “Мөрийтэй тоглоом хууль бусаар зохион байгуулах, тоглуулах”⁴¹ гэх гэмт хэргийг хуульчилсан. Ингэж хуульчлахдаа энгийн бүрэлдэхүүн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн аль алиныг нь хуульчилжээ.

Энгийн бүрэлдэхүүн:

Мөрийтэй тоглоомын бүсээс гадна нутаг дэвсгэрт тоглоомын тоног төхөөрөмж ашиглах, мөрийтэй тоглоомын бүс зохион байгуулах, үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөлгүйгээр мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, түүний дотор интернэт, харилцаа холбоо, онлайн бооцоот bookmakers болон бооцооны бусад гар утас ашиглаж мөрийтэй тоглоомыг хууль бус зохион байгуулах, орон байраар тогтмол хангасан бол гурван зуун мянгаас таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл нэг зуун наyas хоёр зуун дөчин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэргийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг эсхүл их хэмжээний орлого олж үйлдсэн бол таван зуун мянгаас нэг сая хүртэл рубль эсхүл ялтны гурваас таван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны гурван жил хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох буюу торгохгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн: Энэ зүйлийн нэг болон хоёр дахь хэсэгт заасан үйлдлийг зохион байгуулалттай гэмт бүлэг эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж эсхүл онц их хэмжээний орлого олж үйлдсэн бол нэг саяас нэг сая таван зуун мянга хүртэл рубль эсхүл ялтны дөрвөөс таван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр нэг сая хүртэл рубль эсхүл ялтны таван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох буюу торгохгүйгээр 6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.⁴²

Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн тус зохицуулалт нь мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн үйлдэл нь илүү нарийвчилсан зохицуулалттай байх ба энгийн бүрэлдэхүүнд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ ашиглан гэмт хэрэг үйлдэж болох аргыг, хүндрүүлэх бүрэлдэхүүнд урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн, мөн орон байраар тогтмол хангасан байхыг тус үйлдэлд хамааруулсан байна. Онц хүндрүүлэх бүрэлдэхүүнд албан тушаалтан үйлдсэн, онц их хэмжээний ашиг орлого олсон тохиолдлыг хамруулснаар бусад орны эрх зүйн зохицуулалтаас онцлог байна. Мөн түүнчлэн мөрийтэй тоглоомын бүс нутаг дэвсгэрээс гадна болон тусгай зөвшөөрөлгүй мөрийтэй тоглоом зохион байгуулсан зэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хууль:

⁴¹ Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Т.Золбоо, Б.Батбаяр, Б.Тамир, “Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль”, УБ., 2021

⁴² О.Энххүслэн. Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлд заасан Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн зүйлчлэл, нөхцөл байдал, түүнд хамаарах асуудал. УБ., 2022

1998 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуулийн 284, 285 дугаар зүйлд “Хууль бус мөрийтэй тоглоом тоглох”, “Хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийг хуульчилсан.

284 дүгээр зүйл зүйл буюу “Хууль бус мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан.

1. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр олон нийтийг хамарсан мөрийтэй тоглоом зохион байгуулсан буюу ажиллуулсан эсвэл мөрийтэй тоглоом тоглох арга хэрэгслээр хангасан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ.

2. Холбоо нэгдлийн эсвэл хаалттай нийгэмлэгийн хүрээнд мөрийтэй тоглоомыг байнга зохион байгуулсан бол олон нийтийг хамарсан мөрийтэй тоглоом гэдэгт хамаарна.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдлын хувьд гэмт хэрэгтэн:

- Бизнесийн зорилгоор эсвэл

- Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхийн тулд бий болсон зохион байгуулалттай бүлгийн гишүүний хувьд уг гэмт хэргийг үйлдсэн бол гурван сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Олон нийтийн өмнө мөрийтэй тоглоомыг (энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэг) сурталчилсан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих эсвэл торгох ял шийтгэнэ.

285 дугаар зүйл буюу “Хууль бус мөрийтэй тоглоом тоглох” гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан.

Олон нийтийг хамарсан хууль бус мөрийтэй тоглоом тоглосон бол зургаан сар хүртэл хугацаагаар хорих эсвэл зуун ная хүртэл өдрийн ханштай тэнцэх хэмжээгээр торгох ял шийтгэнэ.⁴³

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуульд мөрийтэй тоглоом тоглох болон зохион байгуулахыг гэмт хэрэг болгон хуульчилсан байна. Мөн үүнээс гадна олон нийтийн мөрийтэй тоглоом гэдгийг илүү нарийн зохицуулж тодорхойлсон байна. Тус улсад мөрийтэй тоглоомыг эрхлэхдээ төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд эрх авахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол эрүүгийн хуульд зааснаар хариуцлага хүлээдэг байна. Мөн тусгай эрхийг олгохдоо тухайн мөрийтэй тоглоомыг хүн донтуулах шинжийг нь тусгайлан судалж тэр нь тодорхой түвшнээс хэтрэхгүй байсан тохиолдолд зөвшөөрөл олгодог ажээ.⁴⁴

Япон улсын эрх зүйн зохицуулалт:

Япон улсын эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэгт мөрийтэй тоглох гэмт хэргийг хуульчилжээ. Тус хуулийн 185 дугаар зүйлд “...Мөрийтэй тоглосон этгээдэд 500.000 иен хүртэл торгууль оногдуулах...”, 186 дугаар зүйлд “...мөрийтэй тоглох гэмт хэргийг байнга үйлдсэн этгээдэд 3 жил хүртэл хорих ял оногдуулна...”, “...ашиг хонжоо олох зорилгоор мөрийтэй тоглох газраар хангасан, байнгын тоглогч бүлэг этгээдүүдийг зохион байгуулсан бол 3 сараас 5 жил хүртэл хорих ял шийтгэнэ” гэж заасан байна.

Мөн эрүүгийн хуулийн 187 дугаар зүйлд хууль бус лоттерей /төлбөрт таавар/-ын талаар эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж өгсөнөөрөө онцлог байна. Тухайлбал “...хууль бус лоттерейн тасалбар зарсан бол...”, “...хууль бус лоттерейн тасалбар худалдан зуучилсан бол...”, “бусад байдлаар хууль бус лоттерейн тасалбар шилжүүлсэн ба хүлээн авсан...”⁴⁵ зэрэгт торгох

⁴³ Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Т.Золбоо, Б.Батбаяр, Б.Тамир, “Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль”, Уб., 2021. 167 дахь тал.

⁴⁴ С.Санчиржав, “Мөрийтэй тоглох гэмт хэргийн эрүүгийн хариуцлагын зарим асуудал”, Уб., 2015

⁴⁵ Японы ял шийтгэлийн тухай хууль

болон хорих ялаар тус тус шийтгэхээр хуульчилжээ. Харин Япон улсад слот машин бүхий мөрийтэй тоглоомыг хүлээн зөвшөөрдөг ажээ.

Бүгд Найрамдах Солонгос улсын эрх зүйн зохицуулалт:

БНСУ-ын гэмт хэргийн тухай хуулийн 246 дугаар зүйлд “...ашиг олох зорилгоор мөрийтэй тоглосон бол...”, 247 дугаар зүйлд “...мөрийтэй тоглоомын газрыг ашиг олох зорилгоор нээн ажиллуулсан бол...”⁴⁶ эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Гэхдээ БНСУ нь тусгайлсан мөрийтэй тоглоомын хуулиар зарим төрлийн мөрийтэй тоглоомыг хүлээн зөвшөөрдөг байна. Үүнд:

Казино тоглоомыг энэ улсад зөвшөөрдөг ба ингэхдээ гадаадын иргэн болон солонгосын иргэн гэсэн ялгамжтай хуулиудаар зохицуулдаг байна. Солонгос улсын иргэд нь Ганвон мужид зөвшөөрөгдсөн казинод ганцхан орох боломжтой⁴⁷ байдаг байна.

Харин жуулчдыг дэмжих тухай хуулиар жуулчдад зориулсан зочид буудлыг казино болгон ажиллуулахыг зөвшөөрдөг байна. Энэ хүрээнд Сөүл, Инчеон, Чезү арал зэрэг хот, газруудад гадаад жуулчдад зориулсан казино үйл ажиллагаа явуулдаг байна. Мөн түүнчлэн зарим төрлийн лоттерейн үйл ажиллагаа, морин уралдаан зэргийг тусгайлсан хуулиар зохицуулж үйл ажиллагаа явуулдаг байна.

Бүгд Найрамдах Хятад Ард улсын Эрүүгийн хууль:

1979 оны 07 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хуулийн 303 дугаар зүйлд мөрийтэй тоглоом тоглох, зохион байгуулахтай холбоотой гэмт хэргийн зохицуулалтыг хуульчилсан байна. Тодорхойлбол ашиг хонжвор олох зорилгоор олуулаа нийлж зоос мөрийцсөн буюу зоос мөрийцөх явдлаар тухайлсан ажлаа болгосон байвал гурван жилээс доош хугацаатай хорих, хорьж хөдөлмөрлүүлэх буюу захиран хамаарах шийтгэж, зоосоор торгохоор нийлүүлэн шийтгэнэ. Зоос мөрийцөх газар гаргасан байвал гурван жилээс доош хугацаатай хорих, хорьж хөдөлмөрлүүлэх буюу захиран хамаарах шийтгэж, зоосоор торгохоор нийцүүлэн шийтгэнэ. Үйл байдал нь хүнд ноцтой байвал гурван жилээс дээш арван жилээс доош хугацаатай хорихоор шийтгэж, зоосоор торгохоор нийцүүлэн шийтгэнэ гэж тухайн гэмт хэргийг хуульчилсан байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хууль дахь зохицуулалт нь мөрийтэй тоглоом тоглох, зохион байгуулах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, ял шийтгэлийн хувьд хорих, болон торгох ялын сонголттойгоор хуульчилсан байна. Мөн түүнчлэн эрүүгийн хуульдаа мэдээллийн технологи ашиглан мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн үйлдлийн аргыг оруулаагүй байгаа нь интернэт, цахим орчны хязгаарлалттайгаар цахим мөрийтэй тоглоомын гэмт хэрэг тус улсад үйлдэгддэггүй байх боломжтой гэж үзэж болох талтай юм.

Дүгнэлт. Мөрийтэй тоглоомыг дэлхийн улс орнуудад эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн байдлаараа хүлээн зөвшөөрдөг, хориглодог, хагас зөвшөөрдөг гэсэн 3 төрөлд хувааж үздэг байна. Мөрийтэй тоглоомыг хүлээн зөвшөөрдөг улс орнууд нь тусгайлсан хуулиар мөрийтэй тоглоомыг зохицуулж өгдгөөрөө онцлогтой.

Харин мөрийтэй тоглоомыг хуулиар хориглодог улс орны нэг бол манай улс юм. Монгол улсын их хурлаас 1999 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт казино байгуулах, ажиллуулахыг хориглоно”⁴⁸ гэж заасан байдаг. Мөн Монгол Улсын эрүүгийн хуульд хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулах,

⁴⁶ БНСУ-ын гэмт хэргийн тухай хууль

⁴⁷ С.Санчиржав, “Мөрийтэй тоглох гэмт хэргийн эрүүгийн хариуцлагын зарим асуудал”, УБ.,2015. 44 дэх тал.

⁴⁸ Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийн 1 дүгээр зүйл.

ажиллуулахыг хориглодог. Харин хуулиар хориглодог зарим улс орнуудад казино, лоттерей, төлбөрт тааврын үйл ажиллагааг ялгаж зохицуулж өгдөг байна.

Мөн зарим улс орнуудад тусгай зөвшөөрлөөр мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэхийг хүлээн зөвшөөрч, хэрэв зөвшөөрөлгүй эрхэлсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэж зохицуулдаг байна.

Санал

1. Албан тушаалын байдлаа ашиглан мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг үйлдсэн, хамтран оролцсон тохиолдолд хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг эрүүгийн хуульд тусгах.

2. Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт давтан үйлдсэн бол хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг эрүүгийн хуульд тусгах.

3. Төлбөрт таавар бооцоот тоглоомын үйл ажиллагаатай холбоотой хууль батлагдсан тохиолдолд эрүүгийн хуульд тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар зохицуулалт хийх.

Ашигласан материал

1. Монгол Улсын Эрүүгийн хууль. 2017
2. Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хууль. 1999
3. Б.Галдаа, “Эрүүгийн эрх зүй” /ерөнхий тусгай анги/. УБ., 2021
4. Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Т.Золбоо, Б.Батбаяр, Б.Тамир, “Монгол, Орос, Хятад, Герман улсын Эрүүгийн хууль”, УБ., 2021
5. О.Энххүслэн. Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлд заасан Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн зүйлчлэл, нөхцөл байдал, түүнд хамаарах асуудал. УБ., 2022
6. С.Санчиржав, “Мөрийтэй тоглох гэмт хэргийн эрүүгийн хариуцлагын зарим асуудал”, УБ., 2015

**ГЭМТ ХЭРГИЙН СОЦИОЛОГИ: ҮНДСЭН АСУУДАЛ,
ЧИГ ХАНДЛАГА**
SOCIOLOGY OF CRIME: MAIN PROBLEMS, ATTENDANCE

Цагдаагийн ахмад Б.Даваадорж
Гэмт явдал судлалын магистрант
Shonhoos12@gmail.com
Police captain B. Davaadorj
graduate student

Товч агуулга. Эрх зүйн социологи нь төр, эрх зүйн хөгжил, хөдөлгөөн, мөн чанарыг статистикийн тоо баримтанд үндэслэн социологийн судалгааны аргуудын тусламжтайгаар судалдаг хууль зүйн шинжлэх ухааны салбар юм.

Энэхүү өгүүлэлд гэмт хэргийн социологийн тухай ойлголт, түүний дүн шинжилгээний онцлог, гэмт хэргийн статистикийн чиг үүрэг, статистикийн аргын талаар товч авч үзсэн болно.

Abstract: Legal sociology is a branch of legal science that studies the development, movement, and nature of the state and law with the help of sociological research methods based on statistical data.

This article briefly discusses the concept of the sociology of crime, its analytical features, the functions of crime statistics, and statistical methods.

Түлхүүр үг. Гэмт хэргийн социологи, дүн шинжилгээ, гэмт хэргийн статистик, арга
Keyword. sociology of crime, analysis, crime statistics, methods

Үндсэн хэсэг. Эрх зүйн социологи нь хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх шаардлагатай нийгмийн харилцааг судалдаг бөгөөд нийгмийн социал хүрээний янз бүрийн хэсэг дэх эрх зүйн хэм хэмжээний бодит үүрэг, зохицуулах механизм, түүнийг хүлээн авч ойлгох байдал, эрхийн баримжаа, зан үйл, нийгмийн институтыг судална. Өөрөөр хэлбэл эрх зүйн социологи бол эрх зүйн үзэгдлийг социологи хандлагаар судлаж тодорхой дүгнэлт гаргадаг эрх зүйн тухай тодорхой мэдлэгийн тогтолцоо гэж ойлгож болох юм.

Эрх зүйн шинжлэх ухааны үүднээс эрх зүйн социологийн судалгааны объектыг тодорхойлбол:

1. Эрх зүй нийгмийн институт болох талаас нь судлах судалгаа
2. Эрх зүйн үйлчлэлийн хүрээн дэхь хүмүүсийн зан үйл, үйл ажиллагаа юм.

Эрх зүйн социологийн судалгааны объектыг судлах зүйлийн онцлогоос нь хамааран дараах байдлаар ангилдаг. Үүнд:

1. Хууль тогтоомжийн социологи
2. Шүүхийн социологи
3. Гэмт явдлын социологи
4. Хууль сахиулах байгууллагын социологи
5. Ялын социологи

Эдгээр социологийн судалгаанууд нь бүгд тухайн чиглэлийн статистик тоо баримтад тулгуурлан хийгдэх бөгөөд үр дүнд нь нийгмийн харилцааг боловсронгуй болгох, гэмт хэрэг зөрчилийг арилгах, түүний шалтгаан нөхцөлийг тодруулах талаар санал зөвлөмж

боловсрогдон гардаг. Тухайлбал, шүүхийн статистик тоо баримтад үндэслэн хийх судалгааг шүүхийн социологи, тухайн жилд ял эдэлж байгаа ялтануудын засрал, хүмүүжил, тэдний эдэлж буй ялын талаархи талаархи статистик мэдээнд үндэслэн судалгаа хийхийг ялын социологи гэнэ.

Эрх зүйн социологийн бие даасан томоохон салбаруудын нэг нь гэмт хэргийн социологи юм. Гэмт хэргийн социологи нь нийгэм, нийгмийн хэсэг, бүлэг, хувь хүний дунд гарч буй гэмт хэргийг нийгмийн хэм хэмжээнээс гажсан сөрөг үзэгдэл болох талаас судалдаг. Түүнчлэн гэмт хэргийн зэрэгцээ гэмт хэрэгт шууд хүргэдэг нийгмийн аюултай үйлдлүүдийг өөрөөр хэлбэл, нийгмийн ёс суртахууныг зөрчсөн, түүнд хохирол учруулдаг гажууд зан үйл, тухайн гэмт явдлын нийгмийн шалтгаан, нөхцөл урьдчилан сэргийлэх арга зам, гэмт хэргийн төрлийг судалж, гэмт явдлын хөгжил хөдөлгөөнийг урьдчилсан тодорхойлдог. Эдгээр шинжилгээнүүдээ гэмт статистикийн тоо баримтад тулгуурлан хийнэ.

Гэмт хэргийн социологийн дүн шинжилгээ дараах онцлогтой.

1. *Гэмт хэргийн судалгаанд олон хэмжүүрээр хандах хандлага.* Хохирогчийн байр суурьнаас гэмт хэргийг судлах бөгөөд хохирогч тухайн гэмт хэргийг хэрхэн хүлээн авч буй байдал, гэмт хэрэг үйлдэхэд хохирогчийн оролцоо байсан эсэхийг судладаг. Энэхүү судалгааны үндсэн дээр “Хохирогч судлал” үүссэн байна.

2. *Гэмт хэргийн социологи нь гэмт хэргийн зөвхөн нийгмийн аюулыг судлаад зогсохгүй нийгмийн амьдралд гэмт хэргийн гүйцэтгэх үүргийг судлана.* Өөрөөр хэлбэл гэмт хэргийг эерэг талаас нь судлана./2/ Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн, нийгэм аюултай үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэг бөгөөд энэ нь нийгэм дэхь сөрөг үзэгдэл боловч хууль тогтоомжийн хөгжил, цаашлаад хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн хөшүүрэг болж байдаг. Жишээ нь, Эрүүгийн хууль тусгагдаагүй гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд түүнийг эрүүгийн хуульд шинэ хуульчилдаг. Нөгөө талаасаа гэмт хэрэг нь нийгмийн сөрөг үзэгдэл боловч түүнийг үйлдсэн хүмүүсийн хувьд “хүчтэй бие хүн”-ийг бий болгож түүнд эд баялгийн хуримтлал, гэмт хэргийн сөрөг соёл дахь нэр төрийг авчирдаг.

3. *Эрүүгийн гэмт хэргээс ялгагдах “Бодит гэмт хэрэг”-ийг судалдаг.* Бодит гэмт хэрэг гэдэг нь хуулиар зохицуулагдаагүй гэмт хэргийг хэлэх бөгөөд хүмүүсийг ядуурал, сэтгэл зүйн хямралд хүргэж буй тодорхой хувь хүний зүгээс хүч хэрэглэсэн үйлдэл юм. Тухайлбал, нэргүй хүчирхийлэл, сүүдрийн эдийн засгийн дарамт, гол төлөв эдийн засгийн гэмт хэргүүд хамаарна/ хэлмэгдүүлэлт, цэргийн дэглэлт, хүмүүсийг хүчээр нүүлгэн шилжүүлэлт, ажлын байран дахь бэлгийн дарамт зэрэг багтана. Жишээ нь шүүгч өөрийн таньдаг хэрэгтэндээ хөнгөн ял оногдуулах, тэр бүү хэл хариуцлагаас чөлөөлөх, хорих байгууллага ялтанаа болон цэргийн анги байгууллага цэргүүдийг сэтгэл зүйн болон бие бялдрын хүчирхийлэлд оруулж дэглэх гэх мэт үйлдлийг бодит гэмт хэрэгт хамааруулна.

4. Гэмт ертөнцийн “Сөрөг соёл”-ыг судлана. Гэмт ертөнцийн сөрөг соёл нь нийгмийн соёлын эсрэг соёл юм. Түүнд өөрийн гэсэн хэл, соёл, үнэт зүйлс, хэм хэмжээ, ёс суртахуун, уламжлал, бэлгэдэл, гэмт зан үйлд сургах өөрийн онцлог тогтолцоо байна. Гэмт хэргийн сөрөг соёл нь гэмт хэргийг зөвтгөж байдгаараа маш аюултай юм.

Дээрхи судалгааны үндсэн дээр гэмт хэргийн социологи нь урьд өмнө судлагдаагүй нийгмийн үзэгдлийг шинээр илрүүлж, хүчирхийллийн шинэ төрөл, хэлбэрийг олж харах, судлах боломжийг олгодог.

Энэхүү боломж нь огэмт хэргийн статистик тоо баримтад үндэслэн судалгаа, шинжилгээ хийж санал, зөвлөмжийг боловсруулдаг.

Гэмт хэргийн статистик бол шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулсан иж бүрэн программаар, гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой тоо мэдээллийг цуглуулан боловсруулж,

дүн шинжилгээ хийх буюу өөрөөр хэлбэл гэмт хэргийн тооны талыг чанартай нь нягт холбон тодорхой орон зай, цаг хугацаагаар нь судалдаг статистикийн нэг салбар юм./3/

Гэмт хэргийн статистик нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

1. Гэмт хэргийн гаралт, тархалт, бүтэц, хөдөлгөөний талаар мэдээлэл боловсруулах.
2. Криминологи болон эрх зүйн социологийн шинжлэх ухаантай холбогдож гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, гэмт хэрэгтэн бие хүн, гэмт хэрэгт өртсөн хохирогч иргэн, байгууллага, нийгэм, эрх зүйн хор хохирол, үр дагавар, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл боловсруулах.
3. Хуулийн байгууллага болон бусад төрийн ба төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, тодорхой санал дүгнэлт боловсруулах.
4. Гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсүүдийг судалсанаар гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийг бууруулах ажлын чиглэлийг тодорхойлох.
5. Улсын хэмжээнд болон тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдсэн бүх эрх зүйн зөрчил, гэмт хэрэг нэг бүрийг тоо бүртгэлд оруулж нэгтгэн судлах. Энэ нь тухайн нутаг дэвсгэрийн болон улсын хэмжээний гэмт хэргийн байдлыг бүрэн тодорхойлох үндэс болно. Ингэснээр гэмт хэргийн социологийн дүн шинжилгээг бүрэн дүүрэн хийх, түүнийг цааш нь хөгжүүлэх гол механизм болох юм.

Эдгээр чиг үүргийнхээ хүрээнд гэмт хэргийн статистик нь гэмт хэрэг үйлдэгчид, хохирогч иргэн, байгууллага, түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болгосон, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн, нөхөн илрүүлсэн хэрэг, прокурорын байгууллагын гэмт хэргийн талаарх статистик мэдээ, тайлан зэргийг боловсруулна. Улсын дээд шүүхээс гаргадаг статистик мэдээ, тайлан нь шүүхийн статистикт хамаарна.

Дээрхи боловсруулсан статистикт тулгуурлан эрх зүйн социологи нь нийгмийн үзэгдэлийн хөгжил хөдөлгөөн, гэмт хэргийн гаралт, түүний шалтгаан нөхцөл, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох арга зам, мөн ард иргэдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлэх сэтгэл зүйн байдал гэх мэтийг судалж заавар зөвлөмж гаргадаг. Тухайлбал, Цагдаагийн Ерөнхий Газраас улсын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаар сар тутамд мэдээлэл хийдэг. Энэхүү мэдээллийг дээрхи үзүүлэлт тус бүрээр гаргах бөгөөд жишээ нь долоо хоногийн аль гарагт ямар төрлийн гэмт хэргийн гаралт өндөр байгааг мэдэж болно.

Хэрвээ долоо хоногийн даваа гарагт бусдын бие махбодод халдах гэмт хэргийн гаралт их байвал түүний шалтгаан нөхцөл, хэргийн байдал, хохирогчоос түүнд хандаж буй хандлага, түүнээс урьдчилан сэргийлэх арга замуудыг эрх зүйн социологийн судалгааны аргууд болон криминологийн шинжлэх ухааны хавсарсан судалгаагаар тогтоож холбогдох санал, зөвлөмжийг боловсруулна.

Гэмт хэргийн социологид статистикийн аргыг дараах байдлаар хэрэглэнэ. Тухайлбал:

1. Гэмт хэргийн гаралтын тухай тоон үзүүлэлтийг цуглуулах. Энэ үзүүлэлтийг хууль сахиулах байгууллагууд, шүүх прокурорын байгууллагын тоо бүртгэлээс нэгтгэнэ.
2. Гэмт хэргийн тоо бүртгэлийн анхны материалуудад тулгуурлан статистикийн судалгааны маягт боловсруулна.
3. Статистикийн бүлэглэл хийнэ. Ингэснээр судалгааны хүрээг тодорхой болгож социологийн анкетийг зөв боловсруулах нөхцөл бүрднэ. Энэхүү бүлэглэлийг гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг, орон зай, сэдэлт, гэмт хэрэгт ашигласан зэвсэг хэрэгсэл, хохирогчийн үйлдэл гэх мэтээр ангилж болно.
4. Гэмт хэргийн статистикт социологийн судалгааны аргуудаас сонгон социологийн судалгаа явуулна. Эдгээр судалгаанууд тулгуурлан гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнээс

урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга замуудыг тодорхойлж заавар зөвлөмж боловсруулна.

Дүгнэлт. Гэмт хэргийн социологи нь гэмт хэргийн статистикийн мэдээ баримтанд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд статистик судалгаа нь хэдий чинээ үнэн, зөв байх тусам төдий чинээ социологийн судалгаа үнэн зөв хийгдэж, хэрэгжих боломжтой заавар, зөвлөгөө боловсрогдоно. Цаашлаад улс орны хэмжээнд үйлдэгдсэн бүх эрх зүйн зөрчил, гэмт хэргийн тоо бүртгэлд зөв дүн шинжилгээ хийх нь эрх зүйн тогтолцоонд гэмт хэргийн бүрэлдэхүүн, гэм буруу, нийгмийн хор уршгийн талаархи үзэл, төсөөлөлийг нэгтгэх ач холбогдолтой юм.

Үүнээс үзвэл гэмт хэргийн социологи нь гэмт хэргийн статистик мэдээнд тулгуурлан урьд өмнө судлагдаагүй гэмт хэрэг, зөрчлийн шинэ шинэ төрлийг олж харах, судлах боломжийг олгож байна. Иймд төрийн албан хаагч, эрх бүхий этгээдүүдийг гэмт хэргийн статистикийн мэдээллийг уншиж боловсруулах чадвар эзэмшүүлэх, ДХИС-ийн сургалтын хөтөлбөрт “Эрх зүйн социологи” хичээлийг тодорхой цагаар оруулах, гэмт хэргийн статистикийг боловсруулах арга зүйн талаар эрх бүхий албан тушаалтан, албан хаагчдад тодорхой мэдлэг олгох, энэ чиглэлээр эрдэм шинжилгээний ажлын чиглэлийг бий болгох шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Э.Шинэгэрэл “Эрх зүйн социологи” УБ.,2010 он 125-р тал
2. Э.Дюркгейм “Норма и паталогия” Социология преступности.М.1966.,с-98
3. С.Жанцан “Гэмт хэргийн статистик” УБ.,2007 он.,110-р тал

Ашигласан материал:

1. Э.Шинэгэрэл “Эрх зүйн социологи” УБ.,2010 он
2. Э.Дюркгейм “Норма и паталогия” Социология преступности.М.
3. С.Жанцан “Гэмт хэргийн статистик” УБ.,2007 он.,

**ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХ ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ
ХУГАЦААНЫ УЧИР ХОЛБОГДОЛ
RELATIONSHIP DUE TO STATUTE OF LIMITATIONS
IN CRIMINAL PROCEDURE**

Н.Сайнбаяр

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн
процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш,
хууль зүйн доктор, цагдаагийн хошууч*

sainbayar.n@uia.gov.mn

Sainbayar, N.

*Senior Lecturer of Department of Criminal
Procedure Law, Police School, Doctor of Law,
Police Major,*

Товч агуулга: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино гэж хуульчлан тодорхойлсон. Иймээс гэмт хэрэг шалгаж тогтоох, илрүүлэх ажиллагаа бүр зорилтод заагдсан шинжийг хангаж байх учиртай. Ерөнхий агуулгаар нь авч үзвэл, “гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, зөрчигдсөн эрхийг сэргээх”-д л Эрүүгийн процесс хуулийн мөн чанар оршин буй юм.

Шуурхай байх ёстой боловч одоогийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагаанууд “шуурхай бус” шинжтэй болж, нийгэмд бухимдал үүсгэдэг нь нууц биш юм. Шүүх эрх мэдлийн байгууллагыг шуурхай ажиллуулах нэгэн чухал хөшүүрэг нь хөөн хэлэлцэх хугацааны ухагдахуун байдаг. Энэхүү өгүүллэгээр хөөн хэлэлцэх хугацааны мөн чанар, түүний эрүүгийн процесст үзүүлж буй нөлөөллийг тодорхойлохыг зорьсон.

Abstract: The goal of criminal proceedings is to quickly and fully detect the crime, to identify the person and legal entity who committed the crime and punish it fairly, not to consider anyone who is innocent guilty of a crime, to protect human rights and legal interests, and to protect the rights that have been violated. legally defined as recovery.

Therefore, every crime investigation and detection should meet the objectives. In general terms, the essence of the Criminal Procedure Law is to "promptly and completely detect the crime and restore the violated rights".

It's no secret that the proceedings under the current Criminal Procedure Code, which should be prompt, are becoming "non-prompt" in nature, causing frustration in the community. One of the important incentives for prompt functioning of the judiciary is the concept of statute of limitations.

This article seeks to define the nature of the statute of limitations and its impact on the criminal process.

Түлхүүр үгс: Хөөн хэлэлцэх хугацаа, шуурхай байх зарчим, эрүүгийн процесс, мөрдөн шалгах ажиллагаа.

Keywords: Limitation period, principle of promptness, criminal process and investigation.

Үндсэн хэсэг. Аливаа улс орны зүгээс иргэдийнхээ эрүүл аюулгүй байдлыг хангах нь нэн тэргүүний хэрэгжүүлэх үүрэг бөгөөд энэ талаар Монгол Улсын Үндсэн хуульд: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна⁴⁹” гэж тунхаглан заажээ.

Хүний эрх, эрх чөлөөг хангахуйц шинж нь төрийн үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүртээмжтэй, оновчтой, үр ашигтай байхаас гадна эдгээр нь ямагт шуурхай байдлаар илэрхийлэгдэнэ. Хүний эрхийг шуурхай хангахгүйгээр түүнийг хамгаалж буй асуудал утга учиргүй болж хувирна. Хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах зорилтын хүрээнд мөрдөн шалгах ажиллагаа нь дараах шинжийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

1. Эрүүгийн процесс хуульд үндэслэл, журмыг тодорхой зааж өгсөн байх. Мөрдөн шалгах ажиллагааны онцлог нь зарим тохиолдолд бусдын халдашгүй байдалд халдах шаардлага үүсдэг тул хүний эрх эрх чөлөөг хуульд заасны дагуу л хязгаарлах /Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно⁵⁰, халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно⁵¹/ Үндсэн хуулийн заалттай уялдуулан гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу л хүний эрхийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх боломжтой юм.

2. Шуурхай хэрэгжих боломжтой байх. Гэмт хэрэг илрүүлэх боломж түүнийг илрүүлэх цаг хугацаатай эсрэг хамааралтай. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг илрүүлэх ажиллагаа хэдий чинээ удаан байна төдий чинээ гэмт хэрэг илрэхгүй байх магадлал ихэсдэг.

Мөрдөн шалгах ажиллагааг түргэн, шуурхай явуулах нь эрүүгийн процессын зорилт хангагдах урьдач нөхцөл болох учиртай. Мөрдөн шалгах ажиллагааны шуурхай шинж нь үндсэн хоёр түвшинд хангагдах учиртай. Нэгд тухайн мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрөл авах, оролцогчдын оролцуулах ажиллагаа шуурхай байх, хоёрт тухайн мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах гэсэн агуулгаар илэрхийлэгдэнэ.

Шуурхай хэрэгжих байдал нь ард иргэдийн төрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэг чухал ач холбогдолтой.

3. Императив. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны зайлшгүй нэгэн чухал шинж бөгөөд түүний хэрэгжилт нь заавал биелэгдэх шинжтэй байх ёстой. Мөрдөн шалгах ажиллагаа нь төрийн чиг үүргийн хэрэгжилт болохынхоо хувьд төрийн үйл ажиллагааны зарим шинжийг өөртөө агуулдаг нь түүний зөрчигдөх явдлаас төрийн албадлагаар хамгаалагдаж буйг хэлж болно.

Гэмт хэрэг шалгах явцад нотлох баримтыг илрүүлэхийн тулд тодорхой мөрдөн шалгах ажиллагааг заавал явуулах шаардлага үүссэн л бол түүнийг заавал хэрэгжүүлэх нь ЭХХША-ны зорилтыг хангаж буй чухал арга хэрэгсэл юм. Императив шинж нь мөрдөн шалгах ажиллагааг гарцаагүй явуулах үндэслэл дээр тулгуурлаж бий болно. Тодорхой үндэслэл тогтоогдоогүй байхад мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь императив шинжийг үгүйсгэх бөгөөд үр ашигтай байх шинжийг үгүйсгэж буй юм.

⁴⁹ Төрийн мэдээлэл. 1993. №1. Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

⁵⁰ Мөн бүтээл. 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

⁵¹ Мөн бүтээл. 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэг.

4. Үр ашигтай байх. Мөрдөн шалгах ажиллагааны үр дүн нотлох баримт болох шинжээр илэрхийлэгдэнэ. Нотлох баримт гэдэг нь хуульд заасан үндэслэл журмын дагуу, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой баримт мэдээллийг хэлдэг.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүн хэрэгт хамааралгүй, ач холбогдолгүй байвал энэ хэрээрээ мөрдөн шалгах ажиллагааны шинжээ алдаж, төрийн үргүй зардал гарсаар байх болно. Мөн үр ашигтай байх шинж нь гэмт хэргийн хохирлоос давсан зардал гаргахгүй гэсэн агуулгаар давхар илэрхийлэгдэнэ. Өөрөөр хэлбэл, 1000 төгрөгийн хохиролтой гэмт хэрэгт 1 сая гаруй төгрөгийн зардал гаргах нь гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого оновчтой бус байгаагийн илрэл юм.

Мөрдөн шалгах ажиллагааны үндсэн шинжид болоод эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод ч ялгаагүй шуурхай байх талаар дэлгэрэнгүй тусгаж өгсөн нь тохиолдлын шинжтэй зүйл биш юм. Эрүүгийн процессын бүхий л үйл явц шуурхай байх зүй тогтолтой болох нь тодорхой харагдаж байна. Өмнө дурдсанчлан гэмт хэрэг шалгах ажиллагааг шуурхай байх гол хөшүүрэг нь Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт юм.

Хөөн хэлэлцэх хугацаа нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж арилах хугацааг тодорхойлохоос гадна, төрийн гэмт хэрэг шалгаж, шийдвэрлэх чадамжийг давхар илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, тодорхой төрлийн гэмт хэргийг төр энэ хугацаанд шалгаж шийдвэрлэх боломжтой гэсэн үг юм.

Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж тодорхой хугацааны дараа арилна гэж үзэж, хөнгөн, хүнд хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааны ялгамжтай байдлыг тусгаж өгчээ. Иймд хөөн хэлэлцэл хугацаа дууссан тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй, эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй зохицуулалттай.

Хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн процесст шууд хэрэглэх тохиолдлууд цөөнгүй байдаг. Тухайлбал, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацааг тодорхойлохдоо Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааг ашигладаг.

Хэрэг бүртгэлтийн хугацаа нь хөөн хэлэлцэх хугацаагаар хязгаарлагддаг бол мөрдөн байцаалтын хугацаа⁵² нь хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацаанаас илүү хугацаагаар сунгахыг хориглодог.

Хөөн хэлэлцэх хугацааг өмнө нь анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолж байсныг, 2020.01.10-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах хүртэл хугацаанд тооцдог зохицуулалт оруулсан. Энэ нь зарим талаараа хүний эрхийн зөрчлийг үүсгэж болох юм. Тухайлбал, хөөн хэлэлцэх хугацааг зогсоохыг тулд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах г.м.

Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг тоолдог болсон нь мөрдөгч, прокурорыг тайвнаар хэргээ шалгах боломжийг олгосон. Өмнөх хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтаар мөрдөгч, прокурор нь хэргээ түргэн шуурхай шүүхээр шийдвэрлүүлэхээр эрмэлздэг байсан бол одоо тийм биш болсон. Магадгүй практикт хэргийн шалгалтын ажиллагаа удааширч байна гэх агуулга бүхий гомдол гарах нь үүнтэй ч холбоотой байж мэдэх. Түүнчлэн, өөр нэгэн тулгамдаж буй асуудал бол жишээлбэл, 1 жилийн хөөн хэлэлцэх хугацаатай гэмт хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.12 дугаар зүйлийн 2 дах хэсэг, мөн хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 3 хүртэл жилийн хугацаанд шалгах боломжтой бүрдсэн. Одоогоор ийм хугацаанд шалгагдсан

⁵² Төрийн мэдээлэл. 2016., №07. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.12 дугаар зүйлийн 2, мөн хуулийн 31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

асуудал практикт байхгүй байгаа ч хууль зүйн боломж нь нээлттэй байна. 1 жилийн дараа тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, өөрөөр хэлбэл, нийгмийн аюулын шинжгүй болсон гэж үзэж хуульчилсан байхад түүнийг нь 3 хүртэл жилийн хугацаанд үргэлжлүүлэн шалгах нь хүний эрхийн зөрчил юм.

Хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болж буй нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж нь арилсан гэж үзэж болох бөгөөд гэмт хэрэг биш болсон асуудлыг 1 жилээс дээш хугацаанд шалгаж, эцэст нь ял шийтгэх нь хүний эрхийн зөрчил мөн.

Дүгнэлт. Судалгааны ажлын явцад дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Хөөн хэлэлцэх хугацаа нь эрүүгийн эрх зүйгээс гадна эрүүгийн процессын эрх зүйд чухал байр суурь эзэлдэг аж.

2. Хөөн хэлэлцэх хугацаатай хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацааг уялдуулсан нь хүний түргэн шуурхай, шударгаар шүүлгэх эрхийн зөрчлийг бий болгожээ.

3. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах хүртэл хөөн хэлэлцэх хугацааг тоолж буй нь зарим талаараа мөрдөгч, прокурорыг хэргээ шуурхай шийдвэрлэх гэсэн эрмэлзэлгүй болгожээ. Энэ нь зарим талаараа ашиг сонирхлын зөрчлийг бий болгохоос гадна эрүүгийн процессын мөн чанар болох “шуурхай байх” зүй тогтлыг гажуудуулжээ.

4. Хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан аливаа хэргийг илүү хугацаанд шалгаж болох зохицуулалт нь хүний эрхийг зөрчих эрсдлийг бий болгосоор байна.

Санал. Судалгааны дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хөөн хэлэлцэх хугацааг шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл тоолж байсан өмнөх хуулийн зохицуулалтыг сэргээх.

2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нийт хугацаа нь хөөн хэлэлцэх хугацаанд явагдах гэсэн агуулга бүхий зохицуулалтыг хуульд нэмэлтээр оруулах зэрэг болно.

3. Цаашдаа хөөн хэлэлцэх хугацааг тоолж буй гадаад улсын туршлагыг харьцуулан судлах шаардлагатай гэж үзэж байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он;
2. Эрүүгийн хууль 2015 он;
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он;
4. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны тогтоол. 2022.03.09-ний өдөр 111 дугаар. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар;
5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/192 дугаар тушаал;
6. Сайнбаяр, Н. Мөрдөн шалгах ажиллагаа. Нэг сэдэвт бүтээл. УБ.,2024;
7. Конституция Российской Федерации /принята всенародным голосованием 12.12.1993 с изменениями, одобренными в ходе общероссийского голосования 01.07.2020/;
8. "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ (ред. от 02.10.2024);
9. Цахим эх сурвалж: <https://legalinfo.mn/>;
10. Цахим эх сурвалж: <https://star.worldbank.org/>.

**ХУШ МОДНЫ ҮР ИДЭЭГ ТҮҮЖ БЭЛТГЭСЭН ҮЙЛДЭЛД МӨРДӨН ШАЛГАХ
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ БАЙДАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛИЙГ
ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**
**WAYS TO SOLVE DIFFICULTIES AND DIFFICULTIES IN SENDING TRACK
CHECKS TO CEDAR TREES COLLECTING AND PREPARING PLANTS**

*Дотоод хэргийн их сургуулийн, Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн хошууч Б.Баярсайхан*
bayarsaikhanb48@gmail.com

*University of Internal Affairs, School of Police
Criminal Procedure law department of the teacher
police colonel Bayarsaikhan B*

Товчлол. Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, гэмт хэргийн нөлөөлөл, эрх зүйн орчин, мөрдөн шалгах ажиллагаанд учирч буй хүндрэл бэрхшээл, цаашид шийдвэрлэх арга замын талаар саналаа дэвшүүлэв.

Abstract: Presented suggestions on the current situation of the crime of illegal harvesting of natural plants, the impact of the crime, the legal framework, the difficulties encountered in the investigation process, and the ways to solve it the future.

Түлхүүр үг. Байгалийн ховор ургамал, ховор ургамлын үр, идээ, экологи эдийн засгийн хохирол тогтоох, шинжээч, шинжээчийн дүгнэлт, мөрдөгч, ховор ургамлын жагсаалт, түүж бэлтгэх зөвшөөрөл.

Keywords. Rare natural plants, rare plant seeds, seeds, ecological and economic damage assessment, expert and expert opinion, tracer, list of rare plants, permission to collect⁶

НЭГ. УДИРТГАЛ

Улсын Их Хурлын 1997 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар анх удаа Төрөөс экологийн талаар баримтлах бодлогыг батлан хэрэгжүүлж байсан ба “*Байгаль орчны бодлого нь байгалийн төрх байдлыг хадгалах, байгалийн болон түүх соёлын үнэт зүйлсийг хамгаалах экологийн даацад нийцүүлэн нөөц баялгийг иж бүрэн, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үр өгөөжийг нь ард иргэдэд адил тэнцүү хүртээх нөхцөлийг бүрдүүлэх замаар улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг тэтгэн, амьдрах орчныг сайжруулахад чиглэгдэнэ*” гэж тодорхойлсон байна. Уг баримтлалд байгалийн ургамлын талаар “*Дэлхийн байгалийн бүс, бүслүүрийн үндсэн хэв шинж, өвөрмөц бүрдэл хэсгийг төлөөлж чадах ховор, ховордсон төрөл зүйлээс бүрдсэн Монгол орны ургамал, амьтны аймаг нь экологийн тэнцлийг хангах, биологийн төрөл зүйлийн тэнцвэрийг хадгалах, хүн амын хүнсний нөөцийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтойг харгалзан байгалийн ургамал, зэрлэг амьтдын удмын санг хамгаалж, боломжтойг нь нөхөн сэргээх замаар үр өгөөжийг нь хүн ам, аж ахуйн хэрэгцээнд зохистой ашиглах боломжийг бүрдүүлнэ*”⁵³ гэж зааж өгчээ.

Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж заасан байна.

⁵³ Улсын Их Хурлын 1997 оны 106 дугаар тогтоолын хавсралт /одоо хүчингүй/ цахим холбоос:
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=203165>

Олон улсын хэмжээнд хууль бусаар байгалийн ургамал бэлтгэх гэмт хэрэг багагүй гардаг бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх туршлага тодорхой хэмжээнд хуримтлагдсан байна. Манай улсын хувьд тодорхой зүйлийн ургамлуудыг Бүгд Найрамдах Хятад ард улсуу хууль бусаар гаргах үйлдэл хил гааль, хууль хяналтын байгууллагын шалгалтаар илэрдэг. Эдгээр хууль бус худалдаанд өртөж буй ургамлууд нь голдуу манай улсын нэн ховор, ховор ургамлууд байна.

Байгалийн амьтан, ургамал ховордох нэг үндсэн шалтгаан нь тэдгээрийн эд, эрхтэн, түүгээр хийсэн хүнс, эм бэлдмэл, эд хэрэглэл, гоёл чимэглэлийн зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалж, ашиг олз олох зорилгоор агнаж, олборлосноор олон зүйлийн амьтан, ургамлын нөөц багасаж, устах аюулд хүрээд байгаа бөгөөд зэрлэг амьтан, ургамлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн гол олон улсын эрх зүйн баримт бичиг бол “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)⁵⁴ юм. Тус конвенцыг 1973 оны 3 дугаар сарын 03-ны өдөр байгуулан үзэглэсэн байдаг бөгөөд “CONVENTION ON INTERNATIONAL TRADE IN ENDANGERED SPECIES OF WILD FAUNA AND FLORA” хэмээх Англи нэршлийн товчлол болох “CITES” буюу анх гарын үсэг зурсан хотын нэрээр “Вашингтоны конвенц” хэмээн дэлхий нийтэд түгэн мөрдөж буй энэ акт нь амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах үйл явцыг хянан зохицуулдаг олон улсын эрх зүйн үндсэн баримт бичиг юм. Одоогийн байдлаар тус конвенцыг 183 улс орон (талууд) хүлээн зөвшөөрч, нэгдэн ороод байна. Монгол Улсын хувьд УИХ уг конвенцод нэгдэн орох тухай хуулийг 1995 оны 5 дугаар сарын 04-ний өдөр баталж, улмаар 1996 оны 4 дүгээр сарын 04-ний өдрөөс энэхүү конвенц (CITES)-ын 133 дахь гишүүн орон болжээ.

Монгол орны ургамлын аймаг, түүний олон янз байдалд 5 бүлэгт хамаарах 19 хүрээний 37 ангийн 141 багийн 420 овогт багтах 1607 төрлийн 7702 зүйл гуурст /дээд/ болон гуурсгүй /доод/ ургамал бүртгэгдээд байна. Үүнд 88 овгийн 237 төрлийн 630 зүйл дээд мөөг, 87 овгийн 268 төрлийн 2234 зүйл замаг, 63 овгийн 208 төрлийн 1067 зүйл хаг, 74 овгийн 210 төрлийн 580 зүйл хөвд /Гуурсгүй ургамлын улаан данс, 2020/ 108 овгийн 684 төрлийн 3191 зүйл гуурст ургамал багтана⁵⁵.

Монгол орны ургамлын аймаг эм, хүнс, тэжээл, чимэглэл, техникийн зэрэг ашигт ургамлаар нэн баялаг юм. Манай оронд сүүлийн жилүүдэд байгалийн ургамлыг их хэмжээгээр түүж бэлтгэн, улмаар гадаадад экспортлох болжээ. Гэвч түүхий эд бэлтгэж буй ургамалд нөхөн сэргээлт хийдэггүй нь тухайн ургамлын нөөц багасаж, улмаар ховордон устах шалтгааны нэг болж байна. Иймээс ургамлын түүхий эдийг үйлдвэрлэлд тасралтгүй ашиглах, нөгөөтэйгөөр амьд байгалийн тэнцвэрийг алдагдуулахгүй байх үүднээс байгалийн ургамлын тархац байршил, нөөц баялгийн судалгааг тогтмол явуулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага тулгарсаар байна.

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

А. Байгалийн ховор ургамал хуш модны үр идээ /самар/-г түүж бэлтгэх гэмт хэргийн гаралт

2020 оноос 2024 оны 01 сарын байдлаар хуш модны үр идээ самрыг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан үйлдэлтэй холбоотой нийт

⁵⁴ Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц

⁵⁵ Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, Хууль бусаар мод, байгалийн ургамал бэлтгэх гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудал. УБ., 2021. 24 дэх тал.

227 гомдол, мэдээлэл бүртгэгдсэний 123 буюу 54.2 хувийг гэмт хэргийн шинжтэй, 104 буюу 45.8 хувийг зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл эзэлж байна.

Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх /самар/-тай холбоотой гэмт хэргийн шинжтэй нийт 123 гомдол, мэдээлэл хүлээн авч бүртгэгдсэнээс 36 буюу 29.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, 81 буюу 65.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 6 буюу 4.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорын байгууллагад шилжүүлсэн.

Зөрчлийн шинжтэй нийт 104 гомдол, мэдээлэл хүлээн авч бүртгэгдсэнээс 4 буюу 3.8 хувийг хялбаршуулсан журмаар шалгаж, 35 буюу 33.7 хувийг зөрчлийн нээхээс татгалзах, 65 буюу 62.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх санал гарган прокурорын байгууллагад шилжүүлсэн байна.

Мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр: Улсын хэмжээнд байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх /самар/ хэрэг 2020 оноос 2024 оны 01 сарын байдлаар нийт 53 бүртгэгдсэний 34 буюу 64.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, 11 буюу 20.7 хувийг шүүхэд шилжүүлэх санал гарган прокурорын байгууллагад шилжүүлж, хэргийн шийдвэрлэлт 84.9 хувьтай, ажиллагаанд 8 буюу 15.1 хувь нь шалгагдаж байна.

№	ХБ,МБТ-ын хэрэг нээсэн огноо	Самар хууль бусаар түүж бэлтгэсэн хэргийн тоо			
		Нийт хэрэг	Үүнээс		
			Ажиллагаанд	Хэрэг бүртгэлт хаасан	Шүүхэд шилжүүлсэн
1	2020 он	1	-	1	
2	2021 он	11	-	8	3
3	2022 он	31		21	3
4	2023 он	10	8	4	5
Нийт		53	8	34	11

Дээрх тоон үзүүлэлтээс харахад гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг бүртгэхдээ зөрчлийн эсхүл гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн бүртгэлд харилцан адилгүй бүртгэдэг буюу тухайн мөрдөгч, зөрчлийн байцаагч, тоо бүртгэлийн ажилтны үзэмжээргэлийн й бүртгэдэг буюу тухайн мэдээллийг бүртгэхдээ зөрчлийн эсхүл гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн бүртгэлд нд 7 хувийг зөрчлийн нээхээс татгалзах, 65 буюу 62.5 хувийг хар

Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх буюу хуш модны үр идээг түүсэн, бэлтгэсэн, хадгалсан гэмт хэрэг нь Архангай, Хэнтий, Төв, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудад зонхилон үйлдэгдэж байгаа нь тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн суурь үзүүлэлт, газарзүйн байршил, эко системийн онцлог байдал, ургамлын төрөл зүйл зэргээс шалтгаалан дээрх аймгуудад иргэд байгалийн ургамлыг зохих зөвшөөрөлгүйгээр ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан үйлдэлургамал, бүртгэгджээ.

Б. Хууль тогтоомжийн чиглэлээр

Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэг гэдэг нь ой болон таримал ургамлаас бусад ургамлыг хамгаалах, зохистой ашиглахад гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан Эрүүгийн хуулийн 24.8 дугаар зүйлд заасан нийгэмд аюултай үйлдэл юм.

Зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх

хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Энэ гэмт хэргийн объект нь ой болон таримал ургамлаас бусад байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглахтай холбогдсон харилцаа юм. Халдлагын зүйл нь нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр эрхтэн байдаг. Энэ гэмт хэргийн халдлагын зүйлд ойн дагалт нөөцийн тодорхойлолтод дурдсан самар нь хамаардаг. Учир нь Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор баталсан ховор ургамлын жагсаалтын 355 дугаарт заасан нарсны төрлийн модны үр /ойн нарс, одой нарс, Сибирь хушны үр идээ/ зэргийг ховор ургамлын ангилалд хамааруулж үздэг.

Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэргийн объектив тал нь “зохих зөвшөөрөлгүйгээр”, “хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтнийг түүсэн”, “бэлтгэсэн”, “худалдсан”, “худалдан авсан”, “хадгалсан”, “тээвэрлэсэн”, “боловсруулсан” үйлдэл байна. Эрүүгийн хуульд заасан эдгээр үйлдлийг онолын хувьд дараах байдлаар тайлбарлаж ойлгоно.

Зохих зөвшөөрөлгүй гэдэг нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нэн ховор, ховор ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байхыг ойлгодог.

Хуульд зааснаас өөр зорилгоор гэдэг нь байгалийн ургамлын тухай хуульд зааснаас өөр зорилгоор ашиглахыг хориглож байгаа ойлголт юм. Тус хууль нэн ховор ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар, ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний, элбэг ургамлыг судалгаа, шинжилгээний ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус ашиглаж болохыг заасан.

Ийм учраас нэн ховор, ховор ургамлыг хуульд зааснаас өөр зорилгоор ашиглах нь Эрүүгийн хуулийн 24.8-д заасан гэмт хэргийн шинжийг илэрхийлж байна. Иргэн аж ахуй нэгж байгууллага нь нэн ховор, ховор ургамал тэдгээрийн үр эрхтэнг түүж ашиглах зохих зөвшөөрөлтэй хэдий ч хуульд зааснаас өөр зорилгоор ашиглавал гэмт хэрэгт тооцогдох болохыг хуульчилсан. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, замаг, хаг, мөөг болон бичил биетнээс ургамлын сан бүрдэнэ ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан нэн ховор, ховор, элбэг гэж тус тус ангилдаг.

Нэн ховор ургамал гэж Байгалийн ургамлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон ургамал хамаарна гэж тодорхойлсон бөгөөд тус хуулийн хавсралтад нэн ховор 133 ургамлыг шинжлэх ухааны нэршлээр зааж хуульчилсан.

Ховор ургамал гэдэг нь байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй ургамал хамаарна гэж зааж, ховор ургамлын жагсаалтыг Засгийн газар батлахаар хуульчилсан. Дээрхээс бусад ургамлыг “элбэг ургамал”-д тооцдог. Ургамлын эрхтэн нь навч, иш, үндэс, цэцэг, жимс үрээс тогтдог. Ургамлын эрхтнийг үржлийн, ургал эрхтний тогтолцоо гэж хуваан үздэг. Ургал эрхтний тогтолцоонд навч иш үндэс хамаарах бол үржлийн эрхтний тогтолцоонд цэцэг, жимс үр гэсэн эрхтэн ордог байна. Хууль зүйн ургамал судлалын хувьд эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.8-д заасан гэмт хэргийн “үр эрхтэн” гэдэг нь ургамлын үржлийн эрхтэний цэцэг, жимс, үр гэдгийг ойлгодог.

Түүсэн гэдэг нь байгальд ургаж буй нэн ховор, ховор ургамал, түүний үр эрхтнийг түүн авч байгаа үйлдэл юм.

Бэлтгэсэн гэдэг нь байгалийн ургамлыг түүсэн, ямар нэгэн зорилгод ашиглахаар цуглуулж буй үйлдэл. Нэн ховор, ховор ургамал нь тархац нэн хязгаарлагдмал, ашиглах

нөөцгүй, устах аюулд орсон, байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал учраас элбэгээр тэр бүр олдохгүй гэдэг тул тэдгээрийг бага бага хэмжээгээр түүх эсвэл бусдаас авч цуглуулж авч бэлтгэх.

Худалдсан, худалдан авсан гэдэг нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр түүж бэлтгэсэн ургамлыг худалдах, худалдан авах үйлдэл. Энэ үйлдэл заавал мөнгө болон бусад зүйлээр зарахаас гадна бартер, зээл гэх мэт арилжааны төрлүүдээр үйлдэгдэж болдог.

Хадгалсан гэдэгт орон байр, агуулах сав болон өөрийн ба бусдын эзэмшил газарт байлгах. Хадгалах үйлдлийг гэмт хэрэгт тооцоход нэн ховор, ховор ургамал ургамал, тэдгээрийн үр эрхтнийг зохих зөвшөөрөлгүйгээр бэлтгэгдсэн гэдгийг мэдсээр байж хийж байгаа үйлдэл юм.

Тээвэрлэсэн гэдэг нь нэг объектоос нөгөө объектод зөөж тээвэрлэж буй үйлдэл бөгөөд авто, төмөр зам, агаарын тээврийн хэрэгслээс гадна мотоцикл, мопед, унадаг дугуй, ердийн хөсөг, морь мал зэрэг уналгын хэрэгсэл ашиглаж буй үйлдлийг ойлгодог.

Боловсруулсан гэдэг нь байгалийн ургамлыг эм, гоо сайхан, хүнсний бүтээгдэхүүн, ахуйн хэрэглээ гэх мэт өөр янз бүрийн зорилгоор физик, химийн шинж чанарыг өөрчлөх. Үүнд, хатаах, даршлах, дэвтээх зэрэг янз бүрийн арга ашиглаж болно.

Хууль бус үйлдлийн улмаас ургамлын аймагт учирсан хохирлыг ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээгээр тогтоож, гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлдэг.

Эрүүгийн хуулийн 24.8 дугаар зүйл “*Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх*” гэмт хэрэгт “...Зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтэнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан...” үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан бол Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйл “*Байгалийн ургамлын тухай хууль зөрчих*” зөрчилд “...Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд түүсэн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлийн түүхий эд болгон ашигласан...” үйлдлийг мөн зөрчлийн тухай хуулиар шийтгэхээр **төсөөтэй байдлаар хуульчилж** өгснөөр самар түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан холбогдогч нарт ялгамжтай байдлаар шийтгэл оногдуулах эрх зүйн үр дагавар үүссэн.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйл “*Ойн тухай хууль зөрчих*” “...Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн...” буюу самрыг түүж бэлтгэсэн үйлдлийг мөн зөрчлийн хуулиар шийтгэхээр хуульчилж өгсөн.

Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулинд “**Зохих зөвшөөрөлгүйгээр**” гэж адилхан зааж өгснөөс үүдэн самар түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан тохиолдолд ямар хуулиар шийдвэрлэх нь эргэлзээтэй нөхцөл байдал үүсч байна.

В.Мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах асуудал.

Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэгт дэрвэгэр жиргэрүү, цагаан гоёо, Сибирь хушны үр идээ буюу бидний нэрлэж заншсанаар самар зэрэг ургамал ихэвчлэн хууль бус бэлтгэлд өртөж байна. Ургамлыг ашиглах зөвшөөрлийг эрхийн бичгээр олгодог. Эрхийн бичигт ургамлыг түүж бэлтгэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, ургамлын зүйлийн нэр, эрхтэн, түүж бэлтгэх хэмжээ, хугацаа, газрыг заасан байна. Эрхийн бичгийг бусдад шилжүүлэн ашиглуулахыг хориглодог.

Ургамал түүж бэлтгэж байгаа иргэдтэй таарсан үед тэднээс ямар ургамал, хаанаас түүж, бэлтгэж буй талаар тухайн иргэдээс эхлээд асууж тодруулах нь нэн чухал юм. Эхний асуултуудаас шалгах ажиллагааны чиглэл гарч ирнэ гэдгийг анхаарч асуултаа зөв тавих нь

зүйтэй. Хэрвээ таримал ургамал түүсэн гэж байгаа бол хаана ямар газарт тарьсан аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнийг тодруулж, тухайн газарт шалгагдаж буй иргэний авч яваа ургамал тарьдаг эсэхийг тодруулах боломжтой бол асууж тогтооно.

Ургамал ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг түүж бэлтгэх газраа тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагчаар заалгуулсан эсэхийг тодруулна. Хэрвээ үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал бэлтгэж байгаа бол хот, тосгон, бусад суурины ногоон бүс, гол, горхины эх болон нуур, цөөрмийн эргээс 2 километрийн доторх газар, нэн ховор амьтны байршил газар, баян бүрд, ургамлын бүрхэвч нь талхлагдсан газар, элсний нүүлтээс хамгаалах ач холбогдол бүхий газар, хөрсний элэгдлээс хамгаалах зурвас зэрэг хуулиар хориглосон газруудаас ургамал түүж, бэлтгэж байгаа эсэхийг шалгана. Шаардлагатай бол төлбөр төлсөн баримтыг шалгана.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны а/166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-д заасан нөөцийг нэг удаа ашиглах дээд хэмжээг мэдэж байх, хууль тогтоомжийн эмхэтгэлийг авч явж байх хэрэгтэй. Байгалийн ургамлын хууль бус худалдаанд ихэвчлэн өртөж байгаа нэн ховор болон ховор ургамлын олон янз байдал, ургамлын анатоми (дотоод), морфологи (гадаад) онцгой шинж тэмдэг, өнгө, хэлбэр дүрс зэргийг мэддэг байх, ингэхдээ ургамал таних гарын авлага, лавлах ном, толь зэргийг ашиглах нь ажлыг ихээхэн хөнгөвчилнө. Ургамлын экологийн ач холбогдол, биологийн онцлог, тархац, нөөц баялгийн талаар ерөнхий мэдлэгээ баяжуулан, хууль зүйн-ургамал судлалын зохих төвшний мэдлэгийг эзэмшсэн байх шаардлагатай байдаг.

Байгалийн жамаараа ургадаг ургамлыг огт түүж бэлтгэж, ашиглаж болохгүй гэсэн ойлголт байхгүй учраас зохих зөвшөөрлөөр, хууль тогтоомжид заасан зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь түүж бэлтгэж ашиглаж байдаг. Ийм учраас аливаа ургамал түүж бэлтгэх, ашиглаж байгаа үйлдлийг шалгахын өмнө ургамал түүж бэлтгэх зөвшөөрлийг шалгах нь зүйтэй. Зөвшөөрлийг шалгахын өмнө хаанаас, ямар зөвшөөрлийг хэн, хэнд олгодог талаар зохих мэдлэгтэй байх хэрэгтэй.

Ургамлын түүхий эдийг түүж бэлтгэх, ашиглах зөвшөөрлийн эрхийн бичиг (гэрчилгээ)-тэй эсэхийг шалгаж, эрхийн бичигтэй бол түүнд дурдагдсан иргэний нэр хаяг, регистрийн дугаар таарч байгаа эсэх, эрхийн бичиг заасан газар орон, зөвшөөрсөн хугацаа, ургамлын зүйлийн нэр, түүний эрхтний түүхий эдийг түүж бэлтгэх хэмжээтэй тохирч байгаа эсэх зэргийг хянан шалгана. Байгалийн ургамлын тухай хуульд заасан журмын дагуу түүж, бэлтгэсэн байдал зэргийг давхар нягталж үзнэ. Ургамлын цэцэг, навч, иш мөчир, газрын дээрх хэсгийг түүх хугацаа нь дараах байдалтай байна. Үүнд:

- Ургамал ургалтын ид үе буюу 5 дугаар сарын эхний 10 хоногоос 8 дугаар сарын сүүл 10 хоногт;
- Үр жимс, самар мөөгийг бүрэн боловсорч гүйцсэний дараа; үндэс, үндэслэг ишийг тухайн ургамлын ургах хөгжлийн үе шат өнгөрч, хагдралтын үеэс өмнө буюу 8-10 дугаар сард;
- Хусны шүүсийг шүүс хөдлөх үе нь 5 дугаар сарын эхний ба дунд 10 хоногт;
- Модны давирхайг ургамлын вегетацийн хугацаа буюу 5-10 дугаар сард, хуш модны самрыг 9 дүгээр сарын 10-аас дараа оны 3 дугаар сарын 15-ны хооронд бэлтгэх хугацаатайг мэддэг байх хэрэгтэй.

Шаардлагатай бол энэ байгалийн дагалт баялгийн нөөцийн түүх хугацааг байгаль хамгаалагч эсхүл мэргэжилтнээр тодорхойлуулж болно. Иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор түүж бэлтгэх эрхтэй бөгөөд

ингэхдээ заавал тухайн орон нутгийн сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрөл авдаг учраас тухайн зөвшөөрлийг үзэж шалгана.

Самрыг хууль бусаар бэлтгэх, борлуулах, гадаад улсад гаргах үйлдэл практикт ихэвчлэн үйлдэгддэг. Хуш модны самар нь ховор ургамлын жагсаалтад орсон бөгөөд энэ гэмт хэргийн халдлагын зүйлийн нэг юм. Самрыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А\166 дугаар тушаалаар баталсан "Ойн дагалт баялгийг хамгаалах зохистой ашиглах журам"-аар түүж бэлтгэхийг зохицуулдаг.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд самрын нөөцийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болох тухай шийдвэрийг бүсчлэн гаргадаг. Тухайн жилд ашиглаж болох нөөцийн дээд хязгаарыг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож, тогтоосон хязгаарт багтаан иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн анги (байхгүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч) зөвшөөрөл олгоно. Тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн хэсэгт тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан байгаль хамгаалагч олгоно.

Эрхийн бичгийг 2 хувь үйлдэж, 1 дүгээр хувийг санхүүгийн тооцооны баримт болгож олгосон газар өөртөө үлдээж, 2 дугаар хувийг ойн дагалт баялаг ашиглагчид олгоно. Тийм учраас шаардлагатай бол эрхийн бичгийг харьцуулан үзэж болно. Тус эрхийн бичгийг иргэн нэг удаа 10 хүртэл хоног, аж ахуйн нэгжид 21 хоногоор олгодог. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас нөөцийг бэлтгэж амжаагүй бол тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч нэг удаа иргэнд 5 хүртэл хоног, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад 10 хүртэл хоногийн хугацаагаар сунгаж болдог. Эрхийн бичгийг түүний хүчинтэй байх хугацаанд дахин олгодоггүй.

Хуш модны самар "ховор" ургамал бөгөөд зарим зохицуулалтын талаар дурдвал, хуш модны самрыг жил бүрийн 10 дугаар сарын 15-аас дараа оны 3 дугаар сарын 15-ны хооронд ахуйн зориулалтаар иргэн 50 кг, үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх нөөцөөс 40% бэлтгэнэ. Самар түүх газар, хэмжээ зэргийг тус эрхийн бичигт тодорхой тусгаж өгсөн байдаг. Хуш модны самар тухайн жилийн ургацын байдлыг орон нутаг дахь ойн анги судлан тогтоож "Ойн судалгаа, хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газарт самрын ургацын байдлын мэдээ, дүгнэлтийг тухайн оны 8 дугаар сарын 01-ний дотор хүргүүлдэг. Улмаар "Ойн судалгаа, хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газар хуш модны самрын ургалтын мэдээг нэгтгэн дүгнэж, дүгнэлтийг тухайн оны 8 дугаар сарын 20-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэг.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага "Ойн судалгаа хөгжлийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын дүгнэлт, орон нутгаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн тухайн жилд самрын нөөцийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болох тухай шийдвэрийг тухайн оны 09 дүгээр сарын 01-ний дотор бүсчлэн гаргадаг.

ДҮГНЭЛТ

1. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн хор хохирол богино хугацаанд байгаль экологийг сүйтгэн их хэмжээний хохирол учруулдаг нийгэмд аюултай үйлдэл байдаг. Гэмт хэргийн шалтгаан нөхцөл, мөрдөн шалгах ажиллагаанд учирч буй эрх зүйн хүндрэл бэрхшээлийг арилгаснаар цаашид учирч болох эрсдэлээр урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй таслан зогсоох, эрх зүйн тодорхой шийдэлд хүрэх ач холбогдолтой байна.

2. Сибирь хуш модны самрыг зохих зөвшөөрөлгүйгээр бэлтгэх гэмт хэрэг, зөрчил ихээр бүртгэгдэж улмаар Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуульд заагдсан ял, шийтгэлийг оногдуулж байгаа үйлдэл нь иргэдийн амьжиргааны түвшинтэй шууд холбож ойлгож болно. Байгалиас зохих зөвшөөрөлгүйгээр хуш модны самрыг бэлтгэх үйлдэл нь зүйлчлэлийн хувьд

маргаантай сэдэв болж хуулийн байгууллагын ажилтнууд хуулийг нэг мөр хэрэглэж чадахгүй өөр өөрсдийн үзэмж дотоод итгэл үнэмшлээр хэргийг үнэлэн шийдвэрлэж байна.

3. Эрүүгийн хуулийн 24.8 дугаар зүйл “*Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх*” гэмт хэрэгт “...Зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтэнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан...” үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан бол Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйл “*Байгалийн ургамлын тухай хууль зөрчих*” зөрчилд “...Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд түүсэн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлийн түүхий эд болгон ашигласан...” үйлдлийг мөн зөрчлийн тухай хуулиар шийтгэхээр төсөөтэй байдлаар хуульчилж өгснөөр самар түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан холбогдогч нарт ялгамжтай байдлаар шийтгэл оногдуулах эрх зүйн үр дагавар үүссэн.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйл “*Ойн тухай хууль зөрчих*” “...Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн...” буюу самрыг түүж бэлтгэсэн үйлдлийг мөн зөрчлийн хуулиар шийтгэхээр хуульчилж өгсөн.

Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулинд “*Зохих зөвшөөрөлгүйгээр*” гэж адилхан зааж өгснөөс үүдэн самар түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан тохиолдолд ямар хуулиар шийдвэрлэх нь эргэлзээтэй нөхцөл байдал үүсч байна.

4. Сибирь хуш модны самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх одоогийн эрх зүйн орчин нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.05.02-ны А/166 дугаар тушаалаар батлагдсан “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах” журмын 2.6-д нөөцийг үйлдвэрийн зориулалтаар зөвхөн ойн дагалт баялаг ашиглах, хамгаалах мэргэжлийн эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага тухайн ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл байгууллага бэлтгэнэ. Байгалийн ургамлын тухай хуулийн 13.3-т “...ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно, 17.4 Нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг судалгаа шинжилгээнээс бусад зориулалтаар, эсхүл эцсийн бүтээгдэхүүн болгосноос бусад тохиолдолд гадаадад гаргахыг хориглоно гэсэн заалтуудыг зөрчиж зөвшөөрлийг олгож байна.

5. Байгалийн ургамлыг хууль бусаар түүж бэлтгэх гэмт хэргийн гаралт нийгэм эдийн засаг, хүн амын амьжиргааны түвшингээс хамаарч хэргийн гаралт ихсэх хандлагатай байна. Иргэд амьжиргааны түвшингээс шалтгаалан зүй зохисгүйгээр хуш модны самрыг дур мэдэн ойгоос бэлтгэж байгаа нь экологи эдийн засгийн хувьд болон бусад төрлийн амьтдад маш их хор нөлөө үзүүлээд байна. Энэ төрлийн хууль бус үйлдэлд мөрдөн шалгах ажиллагааг шуурхай тасралтгүй явуулснаар хуулийг нэг мөр хэрэглэх ял завшихаас урьдчилан сэргийлэх практик чухал ач холбогдолтой.

САНАЛ

1. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд зөвлөгөөн зохион байгуулж, самар бэлтгэсэн үйлдлийг Зөрчлийн болон Эрүүгийн хуулиар хэрхэн шийдвэрлэвэл зохих талаар нэгдсэн ойлголтод хүрч холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэх.

2. Олон улсын үнэлгээгээр анхааралд өртөхөөргүй /Least Concern/ ангилалд хамаардаг, Монгол орны ойн санц нөөц, тархалтын эзлэх хувиараа хоёрдугаарт ордог хуш модны самрыг

“Ховор ургамлын жагсаалт”-д байлгах шаардлагатай эсэх талаар Шинжлэх ухааны академийн Батоникийн цэцэрлэгт хүрээлэнгийн эрдэмтэн судлаачидтай уулзаж мэдээлэл солилцох.

3. “Ховор ургамлын жагсаалт”-д самар түүний үр идээг оруулах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 410 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах асуудлыг энэ чиглэлийг хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаар уламжлуулан шийдвэрлүүлэх.

4. Самар түүх эрх авах хүсэлтэй хүмүүсийг сургалтад хамруулж, зөвхөн тусгай зөвшөөрөлтэй хүмүүст самар түүх эрхийг олгох. Энэ нь ой модыг хамгаалахад эерэг нөлөөтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992
2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль УБ., 2006
3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль УБ., 2001
4. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль УБ., 2006
5. Эрүүгийн хууль УБ., 2015
6. Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном УБ., 2017 он
7. Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар УБ., 2013 он

Хоёр. Нэг сэдэвт зохиол, сурах бичиг, гарын авлага

1. Дэлхийн байгаль хамгаалах сан “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, Хууль бусаар мод, байгалийн ургамал бэлтгэх гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд”
2. С.Жанцан “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” 2013 он
3. Ц.Гансүх “Монгол Улсын эрүүгийн эрх зүй хичээлийн гарын авлага” 2006 он
4. Хууль зүй дотоод хэргийн яам “Монгол улсын хуулиуд 2017 он

Гурав: Интернетийн орчин”

1. www.wfdsa.org,
2. www.seldia.eu,
3. www.dsa.kz,
4. www.dissercat.com/skachat-besplatnye-dissertatsii-i-avtoreferaty-iz-rgb

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ,
ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ.

ANALYSIS OF POLICE STRATEGIC PLANNING
AND ITS IMPLEMENTATION

Б.Одбаатар

*Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн
Цагдаагийн удирдлага, стратегийн тэнхимийн профессор,
хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа.*

Odbaatar.B

*Professor, Department of Police Strategy Management,
Executive Management Academy, University of Internal Affairs,
Mongolia, doctor of law (Ph.D), Associate Professor, police colonel*

Хураангуй: Энэхүү илтгэлээр цагдаагийн байгууллагын стратеги төлөвлөлт, түүний хэрэгжилтэд шинжилгээ хийж үнэлэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар судлаачийн хувиар дүгнэлт, санал дэвшүүлэн гаргахыг зорилоо.

Abstract: In this report, we aim to analyze and evaluate the strategic planning of the police organization and its implementation, and then make conclusions and suggestions about the measures to be taken in the future.

Түлхүүр үгс: стратеги удирдлага, цагдаагийн байгууллагын стратеги, стратеги төлөвлөлт, хөгжлийн хөтөлбөр.

Keywords: strategic management, police strategy, strategic planning, development programs.

Аливаа улс орны эдийн засгийн өсөлт, бууралт, гэмт хэрэг, зөрчлийн гаралт, түүний шалтгаан нөхцөл, улс төрийн нөхцөл байдал, учирч болох бодит эрсдэлийн нөлөөлөл, давтамж зэрэгт үндэслэн тухай бүр дүн шинжилгээ хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, цаашлаад стратеги бодлого, төлөвлөлт боловсруулах зайлшгүй шаардлага урган гарч байдаг. Үүний нэг адил Монгол Улсын цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд үнэлэлт өгөх, хөгжлийн стратегийг тодорхойлох бодлого түүхийн хөгжлийн бүхий л цаг үед тавигдаж байжээ.

Түүхийн эх сурвалжаас дүгнэхэд цагдаагийн байгууллага хөгжлийнхөө түүхэн явцад 6 удаа хөгжлийн дунд хугацааны болон стратеги хөтөлбөрийг боловсруулж, ийнхүү боловсруулах бүрдээ гадаад, дотоод орчинд дүн шинжилгээ хийх, улмаар хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шаттай хэрэгжүүлж иржээ. Үүнд:

1. 1996 онд “Ойрын 4 жилд хийх ажлын төлөвлөгөө, дараагийн 4 жилд хийх ажлын бодомж”-ийг гаргаж, төв, орон нутгийн газар, хэлтсээр хэрэгжүүлсэн нь хөгжлийн бодлого, чиглэлээ дунд хугацаагаар төлөвлөх анхны алхам болжээ.

2. 1998 онд “Цагдаагийн байгууллагын хэтийн төлөвлөгөө” бодлогын баримт бичиг боловсруулсан нь хөгжлийн стратегия урт хугацаагаар төлөвлөн хэрэгжүүлэх анхны оролдлого болсон байна.

3. 2009 онд ЦЕГ-ын 156 дугаар тушаалаар 2009-2021 он хүртэл хэрэгжүүлэх “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийг баталсан.

4. 2012 онд “Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг баталсан.

5. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр⁵⁶”, түүнийг хэрэгжүүлэх талаар Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/223 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр⁵⁷”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;

6. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр⁵⁸”-ийг баталсан⁵⁹.

Мэдээж дээрхи хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулахдаа улс орны нийгэм эдийн засаг, гэмт хэрэг, зөрчлийн байдал, шалтгаан нөхцөл, чиг хандлага, хүн амын өсөлт, суурьшил, амжиргааны түвшин, цаашлаад улс төрийн нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлийг судалгаа шинжилгээний үндэслэлтэй авч үзэн стратеги зорилгын хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулж, улмаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шаттайгаар авч үзсэн байна.

Хүснэгт 1.

Стратеги хөтөлбөр боловсруулах үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоол. “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоол. “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”
Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага	
- Мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг хийх нь цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж, урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл хийх замаар цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэж, ард иргэдийн итгэлийг олж авах, орчин үеийн цагдаагийн загварт шилжихэд Засгийн газар, Цагдаагийн төв байгууллагын байнгын анхаарал, идэвхтэй оролцоо шаардлагатай. - Төсөв хомсдолтой, төсвийн зарцуулалт оновчтой биш зэрэг хүчин зүйл нь цагдаагийн байгууллагын бодлого, үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилтыг тодорхойлсон үндсэн баримт бичиг болох “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг батлан гаргах	- Хөтөлбөрийг цагдаагийн байгууллагын бодлого, төлөвлөлтийг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулах, удирдах ажилтны манлайлалыг дээшлүүлэх, технологийн шинэчлэл хийж үйл ажиллагааг шуурхай, хүртээмжтэй, дэлхийн өндөр хөгжилтэй орны жишигт хүргэхэд чиглэсэн хөгжлийн зорилго, зорилтыг тодорхойлсон бодлогын баримт бичиг болгох. Хөтөлбөр хэрэгжсэнээр хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадавх сайжирч, алба хаагчдын мэргэжлийн чадвар дээшилж, үйл ажиллагаанд техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэн гэмт хэрэг, зөрчлийг бууруулж, аюулгүйн бүсүүдийг бий болгох, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, иргэд аюулгүй

⁵⁶ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Цахим эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9842>

⁵⁷ Хөтөлбөрийг 2014-2019 онд хэрэгжихээр боловсруулсан.

⁵⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2020. №40.

⁵⁹ Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлд төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулахаар тусгасан. Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2018. №1.

үндэслэлийг бий болгосон.	орчинд амьдрах нөхцөл бүрдүүлэхэд бодит ахиц, үр дүн гарна.
---------------------------	---

Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратегийг тодорхойлсон дээрх хоёр хөтөлбөрийг харьцуулан дүгнэвэл цагдаагийн байгууллагад мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг цогц байдлаар хийх, цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, өргөн цар хүрээтэй, урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл хийх замаар цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэх, хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг олон улсын жишигт хүргэх, алба хаагчдын чадвар, удирдах ажилтны манлайлалыг сайжруулахад чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлэх, үүнд Засгийн газар, цагдаагийн төв байгууллагын идэвх оролцоо чухал гэдэгт үндэслэн боловсруулжээ гэж дүгнэж болно.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. 2014-2019 он”-ийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэвэл хөтөлбөрийг боловсруулахдаа цагдаагийн албаны Эрхэм зорилго, уриа, бахархалыг анх удаа дэвшүүлэн дараах байдлаар тодорхойлжээ.

Цагдаагийн албаны үнэт зүйл: Эх орон, ард иргэддээ өргөсөн тангараг.

Цагдаагийн албаны эрхэм зорилго: Найдвартай баталгаатай үйлчилгээ-иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг.

Цагдаагийн албаны бахархал: Түүхэн уламжлал, хуримтлуулсан туршлага, туг, бэлгэ тэмдэг, цагдаагийн цол, үнэмлэх, энгэрийн тэмдэг, дүрэмт хувцас.

Цагдаагийн албаны уриа: Амар амгалан амьдралын төлөө хамтдаа.

Хөгжлийн хөтөлбөр хэрэгжсэнээр цагдаагийн байгууллагад мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг хийгдэж, цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөл бүрдэн урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл хийгдэн цагдаагийн ажил мэргэжлийн түвшинд хүрч, орчин үеийн цагдаагийн загварт шилжинэ гэж үзэн дараах зорилго, зорилтыг дэвшүүлжээ.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн зорилго, зорилт.

- сайн удирдлага зохион байгуулалт;
- мэргэшсэн үйл ажиллагаа;
- эрүүл, чадварлаг хүний нөөц;
- үр ашигтай төсөв, санхүү, хөрөнгө оруулалт;
- олон нийттэй харилцах.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүн бий болно гэж үзсэн байна. Үүнд:

- байгууллагын дотоод, гадаад соёл төлөвшинө.
- байгууллагын үнэт зүйл бий болно.
- боловсон хүчнийг сонгон шалгаруулж авах тогтолцоо шинэчлэгдэнэ.
- менежерийн сонголт, удирдах ажилтан бэлтгэх тогтолцоо сайжирна.
- алба хаагчдын гадаад хэлний мэдлэг дээшилнэ.
- шинэ мэдээлэл олж авах, багаар ажиллах чадвар сайжирна гэж үзжээ.

Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг сайжруулах, үр дүнтэй тогтолцоог бий болгоход чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэвэл:

Стратеги хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, түүний үр дүн

№	Төсөл	Хэрэгжүүлсэн гол ажлууд, биелэлтийн үр дүн
1	“Цагдаагийн инноваци” төсөл.	“Гэмт хэргийн хяналтын цогц систем” хөтөлбөр хэрэгжүүлж “Удирдлагын төв”-ийг шинээр байгуулан хяналтын 125 телекамерын холболтыг хийж, ашиглалтад оруулсан.
2	“Боловсролтой цагдаа” төсөл.	Удирдах ажилтныг бэлтгэх, алба хаагчдыг мэргэшүүлэх, ажилласан жил, албан тушаал, үр дүнгийн гэрээний биелэлт, сахилга, ёс зүйн байдлаар ялгамжтай хэлбэрээр давтан, мэргэшүүлэх, ур чадварын сургалтад хамруулах тогтолцоог бүрдүүлсэн.
3	“Эрүүл мэнд-цагдаа” төсөл.	Цагдаагийн алба хаагчдын эрүүл мэндийг сайжруулах, эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулах, алба хаагчдын эрүүл мэнд, амь насыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж үр дүнг тооцсон. “Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн тушаалаар байгуулан ажилласан.
4	Автобаазын материаллаг баазыг бэхжүүлэн орчин үеийн оношилгоо, техник хэрэгслээр үе шаттай хангах төсөл.	Засварын орчин үеийн багаж тоног төхөөрөмж /5 ком/-ийг 1.797.500, автомашины тэнхлэг тохиргооны тоног төхөөрөмжийг 12 сая, холбооны багаж хэрэгсэл, кабел, тоног төхөөрөмжийг 907.000, хяналтын камер 9 ширхэг, 32 фортын хамт 1.787.500, гар станц 3 ширхэгийг 645.000, гар станцны батерей 10 ширхэгийг 230.000 төгрөгөөр худалдан авсан. 722.866.448 төгрөгөөр туулах чадвар сайтай тусгай тоноглолтой 4 автомашинаар парк шинэчлэлт хийсэн.
5	Цагдаагийн байгууллагын холбооны хүчин чадлыг сайжруулах “Police smart ‘phone” төсөл.	“Бэлэн бус торгуулийн систем”-ийг өргөжүүлэхэд үүрэн холбооны оператор компаниудтай “Хамтран ажиллах гэрээ” байгуулан, шилэн кабелийн сүлжээний холболтыг бий болгох, 3G, 4G/LTE үйлчилгээг ашиглах, нутаг дэвсгэр, бүс нутгийн онцлог, сүлжээний тархцаас хамааран сонгон хэрэглэх боломжийг бүрдүүлэх техникийн туршилт, тохируулга хийгдсэн. Системийг өргөжүүлэхэд 5.1 тэрбум төгрөгийн 3 багцтай тендер шалгаруулалтыг зарлаж бэлэн бус торгуулийн системийг өргөтгөхөд шаардлагатай сервер болон дагалдах тоног төхөөрөмж, техник хэрэгслийг авсан.
6	Цагдаагийн байгууллагыг хэт богино долгионы радио станцаар хангах төсөл.	“Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудад хуваарилсан тусгай зориулалтын давтамжийн UHF 350-400МГц-ийн зурваст ажиллах тоон технологид суурилагдсан хэт богино долгионы радио холбооны технологид шилжүүлэх” зөвлөмжийн дагуу “Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбоог шинэчлэх төсөл” эхлүүлж, шаардлагатай 28.4 сая.төг-ийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн судалгаа гарган хэт богино долгионы радио станцыг “Моторола” компанийн санхүүжилтээр шийдвэрлүүлэх, нийт төсвийг 4-5 жилийн хугацаанд хуваан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх төсөл хэрэгжүүлсэн.
7	Зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдыг “Police reader” төхөөрөмжөөр хангах төсөл.	Бэлэн бус торгуулийн системийг өргөтгөхөд шаардлагатай сервер, дагалдах тоног төхөөрөмж, техник хэрэгслийг авсан. Хөдөлгөөнт төхөөрөмж дээр ажиллаж байгаа алба хаагчдад “Эрэн сурвалжлалтын мэдээлэл”(ASAP) сангийн мэдээллийг харуулах боломж бүрдүүлэн, хураан авсан бичиг баримтын бүртгэл, торгуулийн бүртгэл харах, хэвлэх, гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэлтэй танилцах, алба хаагч нарт цохох, шалгуулах боломжтой програм хангамж, системээр өргөтгөсөн.
8	Албаны сургалтын төвийн бүс байгуулах төсөл.	Булган аймаг дахь цагдаагийн газар хээрийн сургалтын төв, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газар сургалтын 5 байр, Хэнтий аймаг дахь цагдаагийн газар сургалтын төв байгуулсан.

Стратеги хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөр, түүний үр дүн

№	Хэрэгжүүлсэн хөтөлбөр	Хэрэгжүүлсэн гол ажлууд, биелэлтийн үр дүн
1	“Байгууллагын соёл” төлөвшүүлэх хөтөлбөр.	2018 оны А/95 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан алба хаагчдын соёлын өнөөгийн түвшинг тодорхойлох судалгааг “ММСГ” ХХК-тай гэрээ байгуулан хийсэн.
2	“Цагдаагийн алба хаагчдын мэргэжил дээшлүүлэх, давтан сургах, мэргэшүүлэх” сургалтын хөтөлбөр.	Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад бүх иргэн, алба хаагчдыг хамруулахаар төлөвлөн сургалтыг тасралтгүй явуулсан.
3	“Цагдаагийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, гэр, орон сууц” дэд хөтөлбөр.	ЦЕГ-ын даргын 2016 оны Б/302 дугаар тушаалаар “Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр” батлуулж хэрэгжүүлсэн. Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо Хангалт, үйлчилгээний төвийн урд 37489 м ² талбайд цагдаагийн алба хаагчдын 15 орц бүхий 9 давхар 675 айлын орон сууцны барилгын ажил явагдаж байгаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 141 дүгээр тогтоолоор “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан байна. Хөтөлбөрийн зорилго цагдаагийн байгууллагын ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангах, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд орчин үеийн менежментийн хэлбэр, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэн, үр дүнг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, мэдлэг, ур чадвар, чадавхыг сайжруулах, иргэдийн аюулгүй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэн дараах зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- Монгол цагдааг өв тэгш хөгжүүлэн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, албаны чадамжийг дээшлүүлнэ.
- Цагдаагийн албаны бодлого, төлөвлөлт, зохицуулалтын чанарыг дээшлүүлж, байгууллагын чадавхыг сайжруулна.
- Үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангаж, үр дүнг нэмэгдүүлнэ.
- Өндөр технологийг нэвтрүүлэх, цагдаагийн инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар үйл ажиллагааны баталгаатай, найдвартай байдлыг хангана.
- Иргэдийн оролцоо, бүх талын хамтын ажиллагааг дэмжинэ.

Хөтөлбөрийг батлаад хэдийгээр хоёр жил өнгөрч байгаа ч өнгөрсөн хугацаанд нэлээд ажлыг төлөвлөн биелэлт, үр дүнг ханган ажилласан нь дараах судалгаагаар харагдаж байна. Үүнийг дэвшүүлсэн зорилт бүрийн хүрээнд авч үзвэл:

Зорилт 1. Монгол цагдааг өв тэгш хөгжүүлэн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, албаны чадамжийг дээшлүүлнэ. Цагдаагийн байгууллагад “Дижитал шилжилт”-ийг нэвтрүүлэн “Хүний нөөцийн программ хангамж”-ийг шинэчлэх системийн шинжилгээ хийж, цагдаагийн байгууллагад анх удаа болон дахин орох иргэнийг бүртгэх, цагдаагийн байгууллагын захиалгаар суралцсан төгсөгч албанд орох, төрийн бусад байгууллагаас цагдаагийн байгууллагад шилжин орох, бүртгүүлсэн иргэнийг судлах, томилох, цол олгох ажиллагааны процесс, Хүний нөөцийн шинэ системийн System backlog төлөвлөлтийг хийсэн.

Зорилт 2. Цагдаагийн албаны бодлого, төлөвлөлт, зохицуулалтын чанарыг дээшлүүлж, байгууллагын чадавхыг сайжруулна. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/250 дугаар тушаалаар “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлогын баримт бичиг⁶⁰”, “Баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г батлан, хэрэгжилтийг хангах ажлыг

⁶⁰ Бодлогын баримт бичгийг 8 бүлэг 32 зүйлтэй боловсруулж гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, тэргүүлэх чиглэл, зорилго зорилтыг тодорхойлон хэрэгжүүлэх арга хэлбэр, төрөл, хүрэх түвшин, санхүүжилтийн асуудлыг тусгасан.

зохион байгуулсан. Үйл ажиллагааны зохион байгуулалтын бүтцийг оновчтой болгон нэвтрүүлсэн.

Зорилт 3. Үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангаж, үр дүнг нэмэгдүүлнэ. Цагдаагийн алба хаагчдад мэдээ, мэдээллийг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор гар утасны аппликэйшн боловсруулж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг цахимаар оруулсан ба цаашид зарлан мэдээлэл, эрэн сурвалжлалт, зайлшгүй танилцах тушаал, шийдвэрийг оруулах боломжийг бүрдүүлэх “Police code” гар утасны аппликэйшнд сайжруулалт хийгдсэн.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлалтын “АСАП” санг төрийн мэдээлэл солилцооны “Хур” системтэй холбож, эрэн сурвалжлах санд бүртгэгдсэн этгээд “Хур” сангаас үйлчилгээ авсан тохиолдолд тухайн иргэний мэдээллийг шалгах сервисийг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэн нэгдсэн хайлт, лавлагаан дээр /eSearch.police.gov/ холбогдох мэдээллийг харуулж байна.

“Нэгдсэн хайлт” программ хангамжаас Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Албан журмын даатгагчдын холбоо, Интерпол, Мал эмнэлгийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Боловсрол, шинжлэх ухааны яам зэргээс шаардлагатай мэдээлэл, лавлагаа авах боломж бүрдсэн нь үйл ажиллагааны мэргэшсэн шуурхай байдлыг хангахад чухал ач холбогдолтой болжээ.

Зорилт 4. Өндөр технологийг нэвтрүүлэх, цагдаагийн инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх замаар үйл ажиллагааны баталгаатай, найдвартай байдлыг хангана. Нийслэлийн гудамж, зам талбайн 719 камерын засвар үйлчилгээг хийж, хэвийн ажиллагаанд оруулж, 2632 камер дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсүүдийн хяналтад хянагдаж байна. Цагдаагийн байгууллагын нэгдсэн мэдээллийн санг “Хур” системд холбон ашиглах “dell R740” загварын серверийг нийт 88 сая төгрөгийн худалдан авалт хийж ашиглалтад оруулсан.

Төрийн үйлчилгээний нэгдсэн портал систем /e-Mongolia.mn/-ийн “Жолоодох эрх, тээврийн хэрэгсэл” хэсгээс “Жолоодох эрхийн лавлагаа”, “Жолоочийн лавлагаа, мэдээлэл”, “Зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлт, акт” хэсгийн “Тусгай зөвшөөрөл”-өөс “Галт зэвсэг эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа”, “Хууль сахилт” хэсгээс иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон байсан эсэх, хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа болон байсан эсэх тухай тодорхойлолт зэргийг авах боломжтой болсон.

Зорилт 5. Иргэдийн оролцоо, бүх талын хамтын ажиллагааг дэмжинэ. Цагдаагийн байгууллагаас иргэд олон нийт, оюутан, залуучуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр давхардсан тоогоор 5562 төрийн, 4201 төрийн бус байгууллага, 24920 аж ахуй нэгж, байгууллага, 907 малчдын бүлэг, холбоо, нөхөрлөл, 2147 хөршийн хяналтын бүлэг, 190 оюутан цагдаа, 611 өсвөрийн сэргийлэгч бүлгэм, 1513 хамтарсан баг, 933 сургуулийн эргүүлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган хамтран ажиллан *давхардсан* тоогоор 112.991 иргэн, 18.829 аж ахуй нэгж, байгууллагын 53.329 ажилтан алба хаагчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулжээ.

Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги төлөвлөлт, түүний хэрэгжилтийг судлаачийн байр сууринаас үнэлэн дараах байдлаар дүгнэлээ.

Дүгнэлт:

1. Цагдаагийн байгууллагын стратегийг боловсруулах бүрдээ улс орны нийгэм эдийн засаг, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, шалтгаан, чиг хандлага, хүн амын өсөлт, суурьшил, амжиргааны түвшин зэрэг олон хүчин зүйлийг судалгаа, шинжилгээний үндэслэлтэй авч үзэн стратеги зорилгын хэрэгцээ шаардлагад үндэслэн тухай бүр

боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үе шаттайгаар авч үзсэн нь сайшаалтай.

2. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн стратеги мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг цогц байдлаар хийх, цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх, өргөн цар хүрээтэй, урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурлах, цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэх, хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг олон улсын жишигт хүргэх, алба хаагчдын чадвар, удирдах ажилтны манлайлалыг сайжруулах цогц бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн нь стратеги удирдлагын мөн чанарт нийцэж байна.

3. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрт зайлшгүй стратеги хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх гэхээсээ илүүтэй байнгын шинжтэй, жил бүр давтагдан явагддаг зарим төрлийн ажил, үйлчилгээ орсон байгаад дүгнэлт хийж, цаашид нөөц хөрөнгө, санхүүгийн томоохон эх үүсвэр шаардсан, зөвхөн стратеги хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх томоохон төсөвт ажил, үйлчилгээг тусгаж үе шаттай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй юм.

4. Цагдаагийн байгууллагын стратеги удирдлагын хэрэгжилтийг хангах, түүнийг бүтээлчээр үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Санал:

1. Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг⁶¹, 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл⁶²”-д тусгасан цагдаагийн байгууллагын талаар болон гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний биелэлт, үр дүнг хангах чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулан биелэлтийг тухай бүр тооцох. Тухайлбал, долоодугаар бүлэг: Амар, тайван аюулгүй байдал зорилгын хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан нь цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэгтэй холбогдож, энэ чиглэлээр стратегийн томоохон зорилго, зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага урган гарч байна. Жишээ нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлэх, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр стратеги зорилт дэвшүүлэн үр дүнтэй, үе шаттай бүтээлч ажлыг хэрэгжүүлэх.

2. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах.

3. Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх.

⁶¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2020. №25.

⁶² Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2020. №36.

4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон санхүүгийн системийг хөгжүүлэн бүтээлчээр ашиглах шаардлагатай байна.

5. Цагдаагийн байгууллагын стратеги хөтөлбөрийн хэрэгжилтийг анхан шатны нэгжээс төв байгууллага хүртэл тууштай хангах менежментийн удирдлагын тогтолцоог бий болгож, алба хаагч, удирдах ажилтан бүрийн идэвхтэй үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь чухал байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт.

1. Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2018. №1.

2. Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №8.

3. Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоол. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2020. №25.

4. Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоол. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2020. №36.

Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоол. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Цахим эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=9842>

5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 141 дүгээр тогтоол. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2020. №40.

6. Цагдаагийн ерөнхий газар. Дотоод хэргийн их сургууль. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны ур чадвар, сургалтын хэрэгцээ шаардлага. судалгааны ажлын тайлан. – УБ., 2024.

**ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ҮЕИЙН ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ
ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ТУЛГАРЧ БАЙГАА ЗАРИМ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ**
MAINTAIN PROCEDURES DURING DEMONSTRATION AND GATHERING
IN POLICE OPERATIONS DIFFICULTIES FACED

Б.Баянмөнх

Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн профессор,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа

Дотоод хэргийн их сургууль,

Монгол Улс Цахим шуудан:

b.bayadaa2007@gmail.com

B. Bayanmunkh

Professor of Police Law, University of Internal Affairs

Doctor of Law (Ph. D), Police Lieutenant Colonel

University of Internal Affairs

Хураангуй. Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх арга хэрэгсэл, иргэний, улс төрийн, эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ бүрэн эдлэх боломж олгодог бөгөөд энэ нь ардчилсан засаглалтай улс орон бүхэнд төлөвшсөн хандлага гэж үзэж болно.

Энэхүү өгүүлэлд Монгол Улсад зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааны сүүлийн 3 жилийн төлөв байдал, зохион байгуулах эрх зүйн зохицуулалтын хувьд тулгарч байгаа хүндрэл бэрхшээл болон хэв журам сахиулах, замын хөдөлгөөн зохицуулахад цагдаагийн алба хаагчийн хувьд ямар асуудал үүсдэг талаар авсан судалгааны үр дүнгийн талаар бичсэн болно.

Abstract. Article 4 of the Law on Procedures for Demonstrations and Gatherings of Mongolia / Right to Organize Demonstrations and Gatherings/ 4.1 states that "Citizens of Mongolia, political parties and non-governmental organizations registered in the state registry have the right to organize demonstrations and gatherings." the right to organize gatherings is provided, but demonstrations and gatherings are not organized in accordance with the procedure specified in Article 9 /Procedures for Holding Demonstrations and Gatherings, and violation of the law has become a common problem for the police.

This article describes the difficulties encountered in the legal regulation of organizing demonstrations and gatherings in Mongolia and the results of the research on the problems that arise for police officers in maintaining order and regulating traffic.

Түлхүүр үг. Жагсаал, цуглаан, Засаг дарга, мэдэгдэл, бүртгэл, цагдаа, тээврийн хэрэгсэл

Key word. Demonstrations, meetings, Governors, notices, registrations, police, vehicles

Үндсэн хэсэг. Монгол Улсын иргэн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16-д заасан “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй”⁶³ гэсэн зүйл, заалтыг үндэслэн жагсаал, цуглаанд оролцох, үгээ хэлэх, хэвлэн нийтлэх үндсэн эрхээ эдэлдэг.

Сүүлийн жилүүдэд дэлхийн олон улс оронд үргэлжилж буй өргөн хүрээтэй эсэргүүцлийн жагсаал, ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдал, ардчилсан, хүртээмжтэй

⁶³ Төрийн мэдээлэл. 1993. №1. Монгол Улсын Үндсэн хууль

засаглалыг хязгаарлаж, хууль ёсыг хөсөрдүүлж, үл тоомсорлох болсонд санаа нь зовнисон жагсагчид, улс төрчдийн авлига, иргэний болон улс төр, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн зөрчлөөс үүдэн ноцтой хохирол учруулах хандлага гарч байгаа нь анхаарах татаж байна.

Манай улсын хувьд ч гэсэн жагсаал, цуглаанд оролцогчид Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд заасан эрх зүйн хүрээнд жагсаал, цуглаанаа зохион байгуулахгүй, тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргад мэдэгдэл өгч бүртгүүлэхгүйгээр явуулж байгаа төдийгүй, жагсаал, цуглаанд оролцогчид Зөрчлийн тухай хуулиар хориглосон аливаа хууль бус үйлдлээ хүний эрх нэрийн дор халхавчлах замаар хууль зөрчих явдал түгээмэл гарах болоод байна.

Монгол Улсын Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл /Жагсаал, цуглаан зохион байгуулах эрх/-ийн 4.1-д “Жагсаал, цуглааныг Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага зохион байгуулах эрхтэй”⁶⁴ хэмээн жагсаал, цуглаан зохион байгуулах эрхийн талаар заасан байдаг боловч 9 дүгээр зүйл /жагсаал, цуглаан хийх журам/-д заасан журмаар жагсаал, цуглаан зохион байгуулагдахгүй, хууль зөрчих явдал түгээмэл гарах болсон нь цагдаагийн байгууллагын хувьд тулгамдсан асуудал болжээ.

Монгол Улсад 2014-2023 оны хооронд нийтдээ 2982 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдсан байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд зохион байгуулагдсан нийтийг хамарсан арга хэмжээний 60%-ийг жагсаал, цуглаан эзэлж байна. Уг 1359 жагсаал, цуглаанаас 92.4% нь бүртгэлгүй жагсаал, цуглаан эзэлж байгаа нь өнөөдрийн хүчин төгөлдөр хууль тогтоомжоор албадан тараах үндэслэл бүхий арга хэмжээ болж байна.

Сүүлийн үед бүртгэлгүй жагсаал цуглаан зохион байгуулагдах явдал улам нэмэгдэж, төр, засгийн эсрэг бусдыг уриалан турхирах, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэж гэмтээх, цагдаагийн алба хаагчдын хууль ёсны тавьсан шаардлагыг эсэргүүцэх, биед нь халдах, эд хөрөнгийн хохирол учруулах явдал улам нэмэгдэх хандлагатай болж байгаа нь хууль сахиулах байгууллагуудын хувьд байнгын бэлэн байдалд байх шаардлагыг төрүүлж байна. Зөвхөн 2022 оны 12 дугаар сард болсон жагсаал, цуглааны үеэр цагдаагийн алба хаагчдаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэргийн шинжтэй 21 үйлдэлд 30 алба хаагч өртөж хохирсон тохиолдол бүртгэгдсэн байна.⁶⁵

Сүүлийн 5 жилд болсон нийтийг хамарсан арга хэмжээний жагсаалтаас үзэл бодлоо илэрхийлсэн жагсаал, цуглааны тоо судалгааг авч үзэхэд нийтийг хамарсан арга хэмжээ 2019 онд 350 бүртгэгдсэнээс 206 буюу 58.5 хувийг, 2020 онд 323 бүртгэгдсэнээс 255 буюу 78.9 хувийг, 2021 онд 468 бүртгэгдсэнээс 214 буюу 45.7 хувийг, 2022 онд 420 бүртгэгдсэнээс 241 буюу 57.3 хувийг, 2023 оны 5 сарын байдлаар 295 бүртгэгдсэнээс 132 буюу 44.7 хувийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл сүүлийн таван жилийн байдлаар 1856 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулагдсан нь жилд дунджаар 371.2 гэж гарч байгаа бөгөөд үүний 57.02 хувийг жагсаал, цуглаан эзэлж байна.

Энэ нь иргэд Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн эрхээ эдлэх эрх зүйн мэдлэг нэмэгдсэн, нөгөө талаараа жагсаал, цуглаан хийх зайлшгүй шаардлага гараад байгаатай салшгүй холбоотой гэж үзэж байна.

Бид Монгол Улсад жагсаал цуглаан зохион байгуулсан субъектээр нам эвсэл, иргэдийн хөдөлгөөн, хувь хүн гэсэн гурван бүлэгт хуваан авч үзлээ. Тухайлбал, жагсаал, цуглаан зохион байгуулсан аливаа нам, эвсэлээс нийт 334 удаа, хувь хүн нийт 359, төрийн бус байгууллага, иргэдийн хөдөлгөөн нийт 448 удаа зохион байгуулсан байна.

⁶⁴ Төрийн мэдээлэл. 1994. №9. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль

⁶⁵ Лхагвасайхан Н. Цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлын асуудал. Хууль зүйн докторын диссертаци. – УБ., 2023. 154 дэх тал

Жагсаал, цуглаан болгон өөр өөрийн гэсэн зорилго, хэлбэр, агуулгатай байна. Тэр болгондоо өөрийн гэсэн хууль, эрх зүйн зохицуулалт, эрсдлүүдийг дагуулж байна.

Хүний эрхийн үндэсний комиссын 2023 оны тайланд “Хуульд хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй байхаар заасан. Төр засгийн зүгээс энэ эрхийг тэр болгон хангаагүй. Төр засгийн зүгээс “худал мэдээлэл тараах” гэдэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр болсон ба сэтгүүлчдийг хавчин хяхсан тохиолдлууд мэдээлэгдсэн” Хуульд хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй байхаар заасан. Төр засгийн зүгээс энэ эрхийг тэр болгон хангаагүй. Төр засгийн зүгээс “худал мэдээлэл тараах” гэдэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр болсон ба сэтгүүлчдийг хавчин хяхсан тохиолдлууд мэдээлэгдсэн.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх: ТББ-ууд болон сэтгүүлчдийн хэлснээр албан тушаалтнууд Эрүүгийн хуулийн худал мэдээлэл тараах гэсэн заалтыг засгийн газрыг шүүмжилсэн тохиолдолд айлган сүрдүүлэх зорилгоор ашигласан. Дөрөвдүгээр сард төрийн ордонгтойруулан төмөр хашаа барьсны дараа О.Банзрагч хэмээх иргэн төрийн ордныг ард түмнээс тусгаарлалаа хэмээн ерөнхийлөгчийг шүүмжлэн нийгмийн сүлжээнд мийм/меме хийсэн. Банзрагчид эрүүгийн хэрэг үүсгэж, шүүх түүнийг бусдын нэр хүндийг гутаасан мэдээлэл тараасанд буруутай хэмээн үзэн 450,000 төгрөгийн (\$130) торгууль оногдуулсан байна.⁶⁶

Хуульд тайван замаар жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй байхаар заасан бөгөөд төр эдгээр эрхийг ерөнхийдөө хүндэтгэдэг.

Сүүлийн жилүүдэд буюу 2012-2021 онд бүртгэгдсэн жагсаал цуглааны талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд Монгол улсын хувьд улс төрийн нам эвсэлээс жагсаал цуглаан хийх явдал ихсэж байгаа нь харагдаж байна. Энэ нь иргэд өөрийн эрх ашиг сонирхлоо хамгаалахаас эрхээ эдлэхээс илүү улс төрийн аливаа нам эвсэлийн идэвхитэй үйл ажиллагаа давамгайлах хандлага ажиглагдаж байна.

Жагсаал, цуглааны үеийн хэв журам сахиулахад тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, түүний учир шалтгааныг дараах 2 багц асуудлын хүрээнд авч үзлээ. Үүнд:

1. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд үүсч байгаа хүндрэл;
2. Жагсаал, цуглаанд оролцогчдын үйл хөдлөлөөс үүдэлтэй хүндрэл бэрхшээл.

Нэг. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд үүсч байгаа хүндрэл

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль нь 1994 онд батлагдсан бөгөөд энэхүү хууль нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байгаагаас эрх зүйн маргаан байнга гарах болсон нь жагсаал, цуглааны үеийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд хүндрэл бэрхшээл үүсэх нэг хүчин зүйл болж байна.

2015 онд Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд байсан зөвшөөрөл өгөх, зөвшөөрөл олгох гэснийг бүртгэх, бүртгүүлэх гэсэн нэр томъёогоор хэлбэрийн төдий сольсон ч агуулгын хувьд жагсаал, цуглаан хийх зөвшөөрөл өгөх тогтолцоо одоог хүртэл үйлчилж байна. Жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүрэг (аймаг, нийслэл)-ийн Засаг даргад өгдөг. Засаг дарга ажлын 3 өдрийн дотор уг мэдэгдлийг бүртгэсэн эсэх бичгээр хариу мэдэгдэх бөгөөд энэ хугацаанд хариу мэгдээгүй бол төлөвлөсний дагуу жагсах, цуглах эрхтэй болдог.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2-т заасан үндэслэлээр Засаг дарга мэдэгдлийг бүртгэхээс татгалзсан бол зохион байгуулагч шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд шүүгч ажлын 6 өдөрт гомдлыг шийдвэрлэх зохицуулалттай.

⁶⁶ <https://mn.usembassy.gov/mn> //Татаж үзсэн: 12.11.2024

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар бүртгэлгүй боловч тайван жагсаал, цуглаан хийх нь хориотой гэсэн зохицуулалт өнөөдрийг хүртэл үйлчилж байгаа нь тулгамдсан асуудал гэж үзэж байна.

Бүртгүүлээгүй жагсаал, цуглааныг албадан тараах, зохион байгуулагчид торгох, баривчлах шийтгэл ногдуулах хууль үйлчилж байгаа нь үнэн хэрэгтээ зөвшөөрлийн тогтолцоо үйлчилсээр байгааг харуулж байна. Иргэний үндсэн эрхэд тавьж буй аливаа хязгаарлалт нь тохирсон байх ёстой гэсэн шаардлага Монгол Улсын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2-т буй шударга ёсны зарчимд агуулагддаг бөгөөд ИБУТЭТОУП-ын 20-р зүйлд заасан байдаг.

Жагсаал, цуглаан хийх зөвшөөрлийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам зэрэг чухал ашиг сонирхлыг хамгаалахад тохирсон, зайлшгүй арга хэмжээ биш учраас жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг зөрчдөг. Зөвшөөрлийн тогтолцоо нь ардчилсан нийгэм дэх чухал ашиг сонирхлыг хангахад тохироогүй гэдэг нь хоёр үндэслэлээр нотлогддог.

Нэгд, улс төрийн албан тушаалтан болох Засаг дарга нь жагсаан, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэхээс татгалзах бүрэн эрхтэй учраас түүний үзэмжээс энэ эрхийг эдлэх эсэх шууд хамаардаг. Аль нэг албан тушаалтан аливаа үндсэн эрхийн хэрэгжилтийг дур зоргоороо хянадаг байх ёсгүй учраас цуглах эрх чөлөөг ямар ч хязгаарлалтгүйгээр үзэмжээрээ хянах нь уг эрхэд нийдэггүй.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль дахь зохицуулалт нь жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлахыг Засаг даргад зөвшөөрдөг. Нэг талаар, Засаг дарга жагсаал, цуглаан хийх үндэслэлийг дур зоргоороо тайлбарлаж түүнийг хийхийг бүртгэхээс татгалзах боломжтой гэж харагддаг.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3/-т заасны дагуу жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдэл хүлээн авсан Засаг дарга жагсаал, цуглаан нь дараах зорилгоор хийгдэх гэж байгаа бол түүнийг хийхийг бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргаж, ажлын 3 өдрийн дотор зохион байгуулагчид бичгээр мэдэгдэх⁶⁷ зохицуулалттай. Тухайлбал, Дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах, эсхүл үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох, жагсаал, цуглаан ийм зорилготой юу, үгүй юу гэдгийг хэмжих тодорхой шалгуур байхгүй учраас үүнд хэрхэн хариулах нь Засаг даргын эрхлэх асуудлын нэг хэсэг болж байна. Жишээлбэл, болоогүй жагсаал, цуглаан эмх замбараагүй байдал бий болгох эсэхийг урьдчилан тодорхойлоход төвөгтэй.

Жагсаал, цуглааны үеэр эмх замбараагүй байдал үүсгэх маш бага магадлал байхад ийм зорилготой хэмээн үзэж татгалзахыг Засаг даргад зөвшөөрдөг зохицуулалт өнөөдөр үйлчилж байна.

Хоёрт, ардчилсан нийгэм дэх чухал ашиг сонирхлыг хамгаалах үүднээс цуглах эрхийг зохицуулж болох боловч ийнхүү зохицуулахдаа уг эрх чөлөөнд хамгийн бага халдах арга замыг сонгохыг тохирсон байх нөхцөл шаарддаг. Зөвшөөрлийн тогтолцоо нь мэдэгдлийн тогтолцооноос илүү ихээр жагсаал, цуглаан хийх эрх чөлөөнд халдах эрсдэл үүсгэдэг учраас үүнээс татгалзаж мэдэгдлийн тогтолцоог авбал зохистой.

⁶⁷ Төрийн мэдээлэл. 1994. №9. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль

Мэдэгдлийн тогтолцоо нь зөвшөөрлийн тогтолцооноос дутахгүйгээр чухал ашиг сонирхлыг хамгаалж чаддагийн зэрэгцээ тайван цуглах эрхийг эдлэхийг зөрчих эрсдэл илүү багатай, зохион байгуулагчаас эрх бүхий этгээдэд цуглах тухай урьдчилан мэдэгдсэн байхад л хангалттай бөгөөд түүний зөвшөөрөл эсхүл бүртгэлийг хүлээхгүйгээр тайван цуглаж болдог. Тиймээс, энэ тогтолцоо нь "цуглах эрх чөлөөг хэрэгжүүлэхэд зөвшөөрөл заавал авах ёсгүй гэсэн хууль зүйн перзүүмц (presumption) дээр тулгуурладаг. Зөвхөн цуглах эрхийн хэрэгжилтийг дэмнэх болон нийтийн дэг журам, нийтийн аюулгүй байдал, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй арга хэмжээ авах боломжийг төрд олгох зорилгоор л цуглааныг урьдчилан мэдэгдэхийг шаардаж болдог.

Мэдэгдэл нь жагсаал, цуглааны тайван байдлыг хангах үүргээ хэрэгжүүлэх боломжийг цагдаад олгодог⁶⁸. Жишээлбэл, цагдаа замын хөдөлгөөнийг зохицуулах, цуглаж буй хүмүүсийн аюулгүй байдлыг хамгаалах зэрэг арга хэмжээ авч болно.

Зөвшөөрлийн тогтолцоонд цуглааныг зөвшөөрөөгүй (цуглах мэдэгдлийг бүртгэхээс татгалзсан) бол цуглаан хийх хориотой бөгөөд зөвшөөрөлгүй цуглаан хийвэл тухайн цуглааныг албадан тарааж эрүүгийн эсхүл захиргааны хариуцлага хүлээлгэдэг. Тайван цуглах эсэх нь эрх бүхий этгээдийн зөвшөөрөл эсхүл татгалзлаас шууд хамаардаг. Тиймээс, "зөвшөөрөл авах шаардлага нь мэдэгдэх шаардлагаас илүү урвуулан ашиглагдах эрсдэлтэй"⁶⁹. Эрх баригч намын боловсон хүчинд уг зөвшөөрлийг өгөх эрх мэдэл хадгалагддаг бол энэ эрх чөлөөг хоосон зүйл болдог⁷⁰.

Аливаа төр засгийн эрхэд гарсан олонх өөрсдийнхөө эсрэг дуу хоолойг хаахын тулд цуглах зөвшөөрөл өгөхөөс татгалзах эрсдэлтэй байдаг. Зөвшөөрлийн тогтолцоо нь цуглах эрхийн үнэт зүйлийг үгүйсгэдэг төдийгүй хуулиар зохицуулаагүй бүхэн хууль ёсны байх ёстой гэсэн зарчимтай харшилдаг. Тиймээс, цуглаан хийхийн тулд эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авсан байхыг шаардах нь цуглах эрх чөлөөг тодорхой хэмжээнд хязгаарлах боломжийг бий болгож байгаа гэж үзэхэд хүргэж байна.

Дэлхийн зарим улс орнуудын жагсаал, цуглаан зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг авч үзэх нь өөрийн орны эрх зүйн зохицуулалт ямар түвшинд байгааг харьцуулах боломжийг бий болгодог.

Зөвшөөрлийн тогтолцоог халахыг олон улсын хүний эрхийн байгууллагууд зөвлөж ирсэн. НҮБ-ийн тусгай илтгэгч болон Венецийн комисс зөвшөөрлийг тогтолцоог халахыг зөвлөдөг⁷¹. Мөн, зөвшөөрлийн тогтолцоо цуглах эрх чөлөөг зөрчсөн гэсэн шийдвэрийг бусад олон улсын шүүх гаргаж байсан. Жишээлбэл, цуглаан хийх мэдэгдлээс татгалзах бүрэн эрхийг орон нутгийн эрх барих байгууллагад өгсөн хуулийн заалт нь үнэндээ урьдчилсан мэдэгдлийн гэхээсээ урьдчилсан зөвшөөрлийн тогтолцоог үүсгэсэн гэж үзээд Гүржийн Үндсэн хуулийн шүүх уг заалтыг хүчингүй болгосон.

Мөн, "олон нийтийн цуглаан зохион байгуулахын тулд зөвшөөрөл авахыг шаардах нь Үндсэн хуульд баталгаажсан тайван цуглах эрх чөлөөг зөрчдөг учраас Үндсэн хуулийн бус"

⁶⁸ www.mn-nhrc.org.mn //Татаж үзсэн: 22.12.2023. ХЭҮК. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 10 дахь илтгэл. –УБ., 2011

⁶⁹ Belyaeva, Buil, and Goldberger, Guidelines on Freedom of Peaceful Assembly 65

⁷⁰ Rav. Christopher Mricia v. Anomey-General, High Court of Tanzania at Dodoma, Civil Case No. 56

⁷¹ Maina Kiai, "Report of the Special Rapporteur on the Rights to Freedom of Peaceful Assembly and of Association A/HRC/2027 (Human Rights Council, UN, May 21. 21.1 2012) 8, pp/www.zheht.org/ Documents/HR Bodies/HRCouncil/RegularSession/Bession20 A-HRC-20-27 en pat. Belyaeva, Bul anil Goldberger, Guidelines on Freedom of Peaceful Assembly 65

гэж Танзаны Үндсэн хуулийн шүүх шийдсэн⁷². Занби, Нигерийн шүүхүүд бас зөвшөөрлийн тогтолцоог Үндсэн хууль зөрчсөнийг тогтоожээ⁷³.

Тайван цуглааныг албадан тараахад хуулиар тогтоосон журмыг зөрчдөг тухай Цагдаагийн албан хаагчид бүртгэлгүй хийж буй тайван жагсаал, цуглааныг Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд тодорхой заасан журмыг баримтлалгүйгээр албадан тарааж, цуглах эрх чөлөөг зөрчих нь түгээмэл гэж зарим иргэд үздэг ч бүртгэлгүй жагсаал, цуглаан бол өнөөгийн хууль тогтоомжоор хууль бус жагсаал, цуглаан гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Бүртгэлгүй жагсаал, цуглаан зохион байгуулж буй тохиолдолд засаг дарга уг жагсаал, цуглааныг тараах тухай зохион байгуулагчид бичгээр мэдэгдэж, 2 цагийн дотор түүнийг тараахыг бичгээр шаардах ёстой (Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 14-р зүйлийн 2). Уг шаардлагыг сайн дураараа биелүүлээгүй эсхүл 2 цаг өнгөрсний дараа жагсаал, цуглааныг үргэлжлүүлсэн бол цагдаагийн байгууллага хуульд заасан арга, хэрэгслээр албадан тараана⁷⁴ гэж Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 14-р зүйлийн 3-т тодорхой заасан боловч цагдаа жагсаал, цуглааныг тараахдаа энэ журмыг бараг баримталдаггүй.

Жагсаал, цуглааны үед цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл, шаардлага хүргүүлж, хэв журам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Энэ үйл явцад жагсаал, цуглаан зохион байгуулагч, оролцогчдын зүгээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг мушгин гуйвуулах, иргэдийн үг хэлж, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нь хааж байна гэх мэтээр олон нийтэд мэдээлэл түгээж, зориудаар өөрсдөд ашигтай байдал бий болгохыг зорьж, хууль бус эсэргүүцлийн үйл ажиллагаанд олон нийтийг уриалах үйлдэл байнгын давтагдах болсон. Жишээлбэл, 2015 оны 10 сарын 15-ны өдрийн Сүхбаатарын талбай дээрх аяндаа үүссэн цуглааныг цагдаа тараахдаа энэ журмыг баримтлаагүй байна. Мөн, аяндаа үүссэн цуглааны төлөө Ц.Мөнхбатыг торгож шийдвэрлэхдээ шүүгч Ц.Олзод энэ цуглааныг албадан тараасан цагдаагийн үйл ажиллагааны талаар шийдвэртээ огт дурдаагүй, хянаагүй байна.⁷⁵

Дээрхи тохиолдлоос үзвэл жагсаал, цуглааныг 2 цагийн дотор алба тараах тухай зохион байгуулагчид бичгээр мэдэгдсэн боловч тухайн цаг хугацаанд нөхцөл байдал хүндэрч, цагдаагийн байгууллага тавих хяналтаа алдах, улмаар эмх замбараагүй байдал үүсэх нөхцөл байдал үүсвэл хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалт байхгүй байгаатай холбон үзэж болохоор байна.

Дүгнэлт. Өнөөдөр Монгол Улсад жагсаал, цуглаан зохион байгуулах тухай мэдэгдлийг Засаг дарга хүлээн авч бүртгэн, тайван замаар жагсаал, цуглаан зохион байгуулах нөхцөл боломжийг өгч байгаа хэдий ч зохион байгуулагчдын хувьд жагсаал, цуглаанаас үүдэн гарах үр дагаврыг хүлээх хариуцлага хангалтгүй байгаа нь харагдаж байна. Гэвч Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхтэй холбоотой сүүлийн үед Засаг даргад бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулах явдал түгээмэл гарах болсон нь цагдаагийн байгууллагын хувьд эрх зүйн үндэслэлтэй үйл ажиллагаа явуулахад хүндрэлийг үүсгэж байна.

Нөгөө талаараа өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулиар аяндаа бий болсон жагсаал, цуглааныг хэрхэн эрх зүйн хүрээнд

⁷² Rev, Christopher Mtiklis v. Attorney-General, High Court of Tanzania at Dodoma, Civil Case No. 5 of 1993 Vol 1 Commonwealth Human Rights Digest, 1006, p.11

⁷³ All Nigeria Peoples Party v. Inspector General of Police (Unreported, June 24, 2005)

⁷⁴ Төрийн мэдээлэл. 1994. №9. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль

⁷⁵ Сүхбаатар. Чинаптай дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэвэр Дугаар 3263 2015.10.25

боломжтой болгох талаар тусгайлан зохицуулсан заалт байхгүй байгаа нь эрх зүйн хувьд тулгамдсан асуудал болж байна. Цагдаагийн байгууллага аяндаа бий болсон жагсаал, цуглаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, хэв журам сахиулах үүргээ хэрэгжүүлсээр байгаа нь бодит үнэн юм. Тиймээс Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэн даруй шинэчлэн боловсруулах шаардлага тулгарч байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлыг сонгууль болох гэж байгаатай холбогдуулан яаралтай УИХ-аар оруулж батлуулах
2. Аяндаа бий болсон жагсаал, цуглаан, түүнээс үүдэн гарах харилцаануудыг эрх зүйн хувьд нэн даруй Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд оруулж өгөх
3. Жагсаал, цуглаан зохион байгуулах тухай мэдэгдлийг хүлээн авч бүртгэх, бүртгүүлэхтэй холбоотой зохицуулалтыг олон улсын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоо руу шилжүүлэх ажлыг бодлогын түвшинд шийдвэрлэх.

Ашигласан материал

Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Цагдаагийн албаны тухай хууль
3. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль

Ном, сурах бичиг, гарын авлага

4. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 10 дахь илтгэл. –УБ., 2011

Сонин, сэтгүүл:

5. Төрийн мэдээлэл. 1994. №9.
6. Төрийн мэдээлэл. 1993. №1.

Цхим эх сурвалж:

7. www.mn-nhrc.org.mn
8. www.zheht.org

Гадаад хэл дээрх ном бүтээл:

9. Belyaeva, Buil, and Goldberger, Guidelines on Freedom of Feacalul Assembly 65
10. Rav. Christopher Mricia v. Anomey-General, High Court of Tanzania at Dodoma, Civil Case No. 56
11. Maina Kiai, "Report of the Special Rapporteur on t the Rights to Freedom of Peaceful Assembly and of Association A/HRC/2027 (Human Rights Council, UN,
12. Rev, Christopher Mtiklis v. Attomey-General, High Court of Tanzania at Dodoma, Civil Case No. 5 of 1993 Vol 1 Commonwealth Human Rights Lan Digest, 1006
13. All Nigeria Peoples Party v. Inspector General of Police (Unreported, June 24, 2005)

**ОБЪЕКТЫН СУДАЛГАА ЯВУУЛАХАД ХИЙМЭЛ
ОЮУН УХААН АШИГЛАХ НЬ
DO IT FOR OBJECT INVESTIGATION USING INTELLIGENCE**

Д.Бямбахүү
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга. Хиймэл оюун ухаан нь компьютерын програм хангамжаар бүтээгдсэн хүний сэтгэхүйг дууриалгасан ба бараг ижил төвшинд хүргэсэн технологийн төрөл ба аливаа хүний хийдэг үйл ажиллагааг удирдахад зориулагддаг болно.

Энэхүү өгүүлэлд цагдаагийн байгууллага объектын болон субъектын судалгааг гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор ашиглах ажлын бүтээмж, үр дүнг дээшлүүлэхийн тулд алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, цагдаагийн инновацийн тогтолцоог хөгжүүлэх, техник технологийн дэвшлийг өргөн нэвтрүүлэх тэр дундаа хиймэл оюун ухаан ашиглах шинэлэг алхамуудыг хийж, хэрэгжүүлэх замаар сайжруулах талаар авч үзсэн.

Abstract. Artificial intelligence is a type of technology created by computer software that mimics human thinking and brings it to a near-equivalent level, and is designed to control any human activity.

In the future, in order to improve the productivity and results of the use of object and subject research for the purpose of fighting crime, the police organization will increase the professional knowledge and skills of the officers, develop the police innovation system, and widely introduce technical and technological advances, including the use of artificial intelligence, by taking and implementing innovative steps. considered for improvement.

Түлхүүр үг: Объект, гэмт явдал, давтагдашгүй өгөгдөл, хиймэл оюун ухаан, судалгаа

Key word: objects, crime, unique data, artificial intelligence, research

Оршил. «Хиймэл оюун ухаан» (artificial intelligence, AI) гэж хүний адил тодорхой зорилтыг биелүүлэх чадвар, ухаалаг эргэцүүлэл, учир зүйн үйлдлийг тооцоолон бодох болон бусад хиймэл байгууламжийн тусламжтайгаар сэргээх сэтгэн бодох алгоритм бүхий робот-компьютер мөн. 2030 онд өнөөгийн интернет Web 2.0. нь нейрокоммуникацийн зарчим буюу нэг хүний тархи, нөгөө хүний тархитай компьютерийн тусламжтайгаар холбогдох зарчимд үндэслэсэн шинэ Web 4.0. (нейронет)-ээр солигдох ирээдүй харагдаж байна. Өнөөдөр нейро-компьютерийн интерфейс буюу хүний тархи, цахим төхөөрөмжийн хооронд мэдээлэл солилцох тогтолцоо боловсрогдоод байна.⁷⁶

Түүнчлэн хиймэл оюун ухааны чадавхийг нийгмийн янз бүрийн салбарт тухайлбал, боловсрол, эрүүл мэнд, роботтехник, ялгуяа банк, аж үйлдвэр, хөдөө аж ахуй болон ахуйн салбар зэрэг олон салбарт ашиглаж байна. Сүүлийн жилүүдэд хууль зүйн салбарт ашиглах боллоо. Тухайлбал, хуульчдын ур чадварыг сорих (Өмнөд Калифорн болон Стэнфордын их сургууль), хууль зүйн баримт бичиг унших, тайлбарлах, чадвартай боловсруулах талаар туршилт явуулах зэрэг.

Оксфорд, Кембрижийн их сургууль, OpenAI компани болон Electronic Frontier Foundation сангийн бэлдсэн The Malicious Use of Artificial intelligence: Forecasting, Prevention,

⁷⁶ Klaus Schwab. The Fourth Industrial Revolution. World Economic Forum. Cologny/Geneva Switzerland.2017.

and Mitigation хамтарсан илтгэлд дурдсанаар технологийн хөгжил нь гэмт хэрэгтнүүдэд шинэ боломжийг нээхээс гадна AI илүү аюултай учраас түүнийг маш нууц байлгах хэрэгтэй.⁷⁷ Өнөөгийн байдлаар криминологи, виктимологи, криминалистикийн судалгааны нэг гол асуудал бол «шилдэг арга хэрэгслийг шилдгийн шилдэг арга хэрэгслээр», өөрөөр хэлбэл, гэмт явдлыг шинжлэх ухааны техникийн хамгийн сүүлийн үеийн арга хэрэгслээр урьдчилан сэргийлэх, илрүүлэх, нотлох, таслан зогсоох, сөрөн зогсох арга хэмжээ яригдана.

Үндсэн хэсэг

Цагдаагийн байгууллагаас объектын болон субъектын судалгаа явуулах, гэмт хэрэгтэй тэмцэхэд дараах чиглэлийг хөгжүүлж, ашиглах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүнд:

1) мэдээллийг цуглуулах; 2) хадгалах боловсруулах; 3) аналитик болон прогноз загвар; 4) хиймэл оюун ухааны тусламжтайгаар дижитал мөрдөлт явуулах зэрэг; 5) харилцаа холбоо, хамтын ажиллагааны нэгдлийг хангахад оршино.

Ингэснээр «уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхийг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бэхжүүлэх» алсын харааны зорилго биелэх боломж бүрдэх юм.

Гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулах нийтлэг технологи, процедур, бодлогын цогц тогтолцооны талаар эрдэмтэн, судлаачид нэгдсэн байр суурьтай байгаа бөгөөд цагдаагийн байгууллагаас объектын судалгаа явуулах тогтолцоо нэгдмэл байх зарчимд тулгуурлах нь үр дүнтэй гэж бид үзэж болох юм. Мөн профессор Ч.Нямсүрэн бид өнөөдөр аж үйлдвэрийн шинэ эрин үед дэвшин орлоо. Энэ хувьсгалын онцлог шинж нь 1) бидний бие организм, хүрээлэн буй орчин, санхүү хүртэл тоон хэмжигдэхүүнээр илэрхийлэгдэх; 2) удирдлагын шинж чанартай программчилсан шинэ материалууд бий болох; 3) юмсын интернет (Internet of Things, IoT) буюу интернетэд холбоотой бүхий л төхөөрөмж, биетүүд нь өөрийнхөө ажиллагааны хүрээнд мэдээлэл бүрдүүлж түүнийгээ интернетээр дамжуулснаар Big Data үүсгэх нөхцөлийг бүрдүүлэх зэргээр илэрч байна⁷⁸.

Аж үйлдвэрийн IV хувьсгалын ач холбогдол нь хүртээмжтэй, хөгжлийн хурдацтай, тогтолцоот байхын зэрэгцээ шинжлэх ухааны олон тооны судлагдахуун, нээлтүүд нь байнга нийлэгжиж (шинжлэх ухааны зааг ялгаа арилж), төгөлдөржих байдлаар тодорхойлогдож болно. Аж үйлдвэрийн IV хувьсгалд хамаарах үндсэн технологи, элемент, үйл явц нь:

- 1) Нийгмийн бүхий л амьдрал, эдийн засгийн практикт тоон загвар бүтээж ашиглах үзэл санааг нэвтрүүлэх;
- 2) Хиймэл оюун ухаан өөрөө суралцах, төлөвших;
- 3) Робот техникийг өргөнөөр ашиглах, үйлдвэрлэх процессийг роботжуулах, роботууд өөр хоорондоо хамтарч ажиллах;
- 4) Хөдөлгөөний робот хэрэгслүүд бий болох (эхний ээлжинд жолоочгүй ачааны болон хүн тээврийн автомашин);
- 5) 3D-технологийн үндсэн дээр 3D принтерээр хэвлэх үйлдвэрлэлийн хувилах олшруулах шинэ технологи;
- 6) Нанотехнологи, биотехнологи;
- 7) Урьдчилан захиалсан шинж чанартай шинэ материал бүтээх;
- 8) Эрчим хүч нэгэн зэрэг хуримтлуулах, хадгалах, хэрэглэх, сэргээх;
- 9) Квант тооцоололд үндэслэж байна⁷⁹.

⁷⁷ The Malicious Use of Artificial intelligence: Forecasting, Prevention, and Mitigation: February 2018
[//docviewer.yandex.ru/view/522177523](https://docviewer.yandex.ru/view/522177523)

⁷⁸ «Хууль сахиулахуй» онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл.-Уб., 2020 №02 дугаар, 75 дахь тал

⁷⁹ «Хууль сахиулахуй» онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл.-Уб., 2020 №02 дугаар, 76 дахь тал

Хиймэл оюун ухааны асуудал нь техникийн асуудлаар хязгаарлахгүй, мөн нийгэм, ёс суртахууны, эрх зүйн ач холбогдлыг илэрхийлнэ. Гадаадын олон эрдэмтэд хэт өндөр хөгжил, хиймэл оюун ухаанд бас сүүдэртэй талыг харж эхлээд байна. Британийн фикикч Стивен Хокинг «хиймэл оюун ухааныг төгс бүтээх нь хүний нийгмийг мөхөлд хүргэнэ» гэж дахин сануулсан. Microsoft-ыг үндэслэгч Билл Гейтс хиймэл оюун ухаантай болгоомжтой байхыг сануулаад, түүнтэй зохих ёсоор харилцвал аль ч албанд сайн ашиглаж болно гэжээ.

Сүүлийн жилүүдэд хүн төрөлхтний хэрэглэж буй мэдээллийн хэлбэрүүд сүүлийн үед цахим хэлбэрт шилжин тоон зураг, тоон дүрс бичлэг зэрэг өгөгдлийг ихээр ашиглаж байна. Үүнийг дагаад цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа дүрс таних зураг боловсруулах зайлшгүй шаардлага хэрэгцээ гарч ирэн компьютер вижн гэж нэрлэгдэх шинжлэх ухааны салбар үүсч хөгжсөөр байна. Энэ талаар судлаач Э.Мөнхсүх, С.Өлзийбаяр нар дүрс боловруулалтын аргуудыг судлан, объект болон түүний хөдөлгөөнийг танихдаа хүний биометрикийн үзүүлэлтийн үр дүн дээр хийсвэрлэлт хийн тодорхойлж, зургаас хүний гар таниж илрүүлэх, объект таних түүнийг талаар судалсан⁸⁰ үр дүнг цагдаагийн байгууллагаас объектын судалгаанд ашиглаж болно хэмээн үзэж болохоор байна. Үүнд:

1. Объект таних, түүнийг мөрдөх

а).Ирмэг илрүүлэх

Дүрсэн дэх ирмэгүүд нь тухайн дүрснээс таньж ашиглагдах эргэлзээтэй хэсгүүдийн мэдээлэл юм. Ирмэгүүд нь хаана объект байна, тэдгээрийн дүр төрх ба хэмжээ, бүтцийг илэрхийлнэ. Ирмэг илрүүлэлт нь дүрсэн дэх гэрэлтэцийг бага утгаас их утга руу зөөх өөрчлөлтийг тодорхойлдог дүрс боловсруулалтын маш чухал аргуудын нэг юм.

Ирмэг илрүүлэлт нь дүрс хэсэгчлэлийн нэг үе шат бөгөөд дүрсний бүлэг пикселүүдийг тодорхой байрлал руу чиглүүлэхэд хийгдэх үйлдэл юм. Ирмэг илрүүлэлтийн гол үр дүн нь дүрс таних боловсруулалтын чухал ойлголтыг бүрдүүлдэг явдал юм. Дүрсийг тодорхойлохын тулд ирмэгийг нарийн сайн тогтоох хэрэгтэй байдаг. Ирмэг таних боловсруулалтын явцад дараах төрлийн ирмэгийн хувилбарууд гарч ирсэн. Доорхи зураг дээр ирмэг илрүүлэхийн тулд зэргэлдээ пикселүүд дээр хийгдэх үйлдлүүдийг үзүүлээ.

Зураг дээрх өнцөг, булангуудыг олж тодорхойлох нь дүрс боловсруулалтын нэг үндсэн суурь үйлдэл ба үүнийг ашиглан хөдөлгөөн илрүүлэх, панарома зургийг залгах, 3-н хэмжээст загварчлал хийх, биет таних зэрэг дүрсний боловсруулалт хийдэг. Хамгийн өргөн ашиглагддаг алгоритм нь «Ши-Томаси» -гийн (Shi-Tomasi) өнцөг, булан илрүүлэх алгоритм боловч энэ нь «Харрис-Стефенс» -ны (Harris Stephens) алгоритм дээр үндэслэсэн. Алгоритмын талаар дэлгэрэнгүй тайлбарлахдаа математик томъёог ашиглая.

Хар цагаан өнгийн (grayscale) хоёр хэмжээст зураг байг. Үүнийг I гэж тэмдэглэе. I зурагнаас (u, v) жижиг хэсгийг авч (x, y) хэмжээгээр шилжүүлье. Тэгвэл энэ хоёр жижиг хэсэг дэх цэгүүдийн гэрлийн эрчмийн ялгаварын квадратуудын нийлбэр S нь дараах хэлбэртэй бичигдэнэ.

$$S(x, y) = \sum_u \sum_v w(u, v) [I(u + x, v + y) - I(u, v)]^2 (1)$$

Энд: $I(x, y)$ нь (x, y) цэг дээрх гэрлийн эрчим. Цайрах тусмаа ихэснэ. $w(u, v)$ нь жингийн функц. Хэрэв (x, y) нь жижиг хэсэг дотор оршиж байвал 1, эсвэл 0 гэсэн утга авна.

Тэйлорийн задаргааг ашиглан $I(u+x, v+y)$ -ийг дараах байдлаар задалж болно. I_x , I_y -ийг I -ийн тухайн уламжлал гэвэл (I_x – x чиглэл дэх гэрлийн эрчмийн өөрчлөлт, I_y – y чиглэл дэх гэрлийн эрчмийн өөрчлөлт):

⁸⁰ «Шинжлэх ухаан технологийн их сургууль, мэдээлэл холбооны салбарын хөгжилд бидний гүйцэтгэх үүрэг 2014» эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн илтгэл.-УБ.,2014.

$$I(u+x, v+y) \approx I(u, v) + I_x(u, v)x + I_y(u, v)y \quad (2)$$

Дээрх томъёог $S(x, y)$ функц орлуулан хялбарчилбал дараах хэлбэртэй болно.

$$S(x, y) = \sum_u \sum_v w(u, v) [I_x(u, v)x + I_y(u, v)y]^2 \quad (3) \text{ үүнийг матриц хэлбэрт бичвэл:}$$

$$\text{Энд: } S(x, y) \approx \begin{pmatrix} x & y \end{pmatrix} A \begin{pmatrix} x \\ y \end{pmatrix} \quad (3)$$

$$A = \sum_u \sum_v w(u, v) \begin{bmatrix} I_x^2 & I_x I_y \\ I_x I_y & I_y^2 \end{bmatrix} = \begin{bmatrix} \langle I_x^2 \rangle & \langle I_x I_y \rangle \\ \langle I_x I_y \rangle & \langle I_y^2 \rangle \end{bmatrix} \quad (4)$$

Энэ матрицийг Харрисийн матриц гэх ба гурвалжин хаалт нь (u, v) жижиг хэсгийн цэг бүрийн хувьд тооцоолсон нийлбэр гэдгийг илтгэнэ⁸¹.

$(x \ y)$ векторын бүх чиглэлийн хувьд S -ийн утга их хэмжээгээр өөрчлөгдөж байвал (x, y) цэг нь өнцөг хэмээн тодорхойлогддог. Мөн A матрицийн eigen утгуудын хэмжээнээс хамааруулан дараах дүгнэлтийг гаргаж болно ($Av = \lambda v \Rightarrow (A - \lambda I)v = 0 \Rightarrow \det[A - \lambda I] = 0$).

Хэрэв $\lambda_1 \approx 0$, $\lambda_2 \approx 0$ бол (x, y) цэг нь ямар нэг булангийн тод цэг биш.

Хэрэв $\lambda_1 \approx 0$, λ_2 нь их утгатай бол (x, y) цэг нь ирмэг.

Хэрэв λ_1 болон λ_2 нь хоёулаа их утгатай бол (x, y) цэг нь булангийн тод цэг байна.

Ши-Томаси-гийн алгоритмд, $\min(\lambda_1, \lambda_2) > \text{БОСГО УТГА}$ бол (x, y) цэгийг булангийн тод цэг гэж шууд тооцдог.

б). Булангийн тод цэгүүдийг мөшгөх

Канадэ Лукас Томаси буюу КЛТ булангийн тод цэг мөшгөх алгоритм нь хамгийн өргөн хэрэглэгддэг энэ төрлийн алгоритмуудын нэг юм. Үүний зарчмыг тайлбарлахын тулд томъёоны гаргалгааг хийе. I болон J зурагнууд өгөгдсөн гэе. Тэгвэл энэ хоёр зурагны ялгаатай байдлыг тодорхойлох томъёог дараах байдалтай бичиж болно.

$$\epsilon = \iint_w \left[J\left(X + \frac{D}{2}\right) - J\left(X - \frac{D}{2}\right) \right]^2 w(X) dX \quad (1)$$

Энд: $X = [x, y]^T$ - тухайн нэг цэг $D = [D_x, D_y]^T$ - шилжилт $w(X) = 1$ - жингийн функц.


Тэйлорийн цувааг ашиглан $J\left(X + \frac{D}{2}\right)$ болон $J\left(X - \frac{D}{2}\right)$ -ийг дараах байдлаар задлан бичиж болно.

$$J\left(X + \frac{D}{2}\right) \approx J(X) + \frac{D_x}{2} \frac{\partial J}{\partial x}(X) + \frac{D_y}{2} \frac{\partial J}{\partial y}(X) \quad (2)$$

$$J\left(X - \frac{D}{2}\right) \approx J(X) - \frac{D_x}{2} \frac{\partial J}{\partial x}(X) - \frac{D_y}{2} \frac{\partial J}{\partial y}(X) \quad (3)$$

Хүний гар нь бусад дүрснээс ялгарах хэд хэдэн онцлог шинжтэй. Эдгээрээс гарыг танихад хангалттай 3 үндсэн онцлог шинжийг авч үзье.

Зураг № 6. Биометрикс 1 хүний гарын салаанууд нь 90° ихгүй өнцөг үүсгэнэ.




Дээрх хүснэгтэнд бодит гарны өнцгүүдийг оруулсан бөгөөд гарын салааны үүсгэх өнцөг нь 90° -с бага байх нь харагдаж байна.

Зураг №7. Биометрикс 2. Хуруунуудын уртын харьцаа

Хамгийн урт хурууны (дунд хуруу) уртыг 100% гэж үзвэл, хамгийн богино хуруунуудын (эрхий эсвэл чигчий хуруу) уртын зөрүү 35%-с бага байна.

⁸¹ Christian Theobalt. «Interactive Markerless Articulated Hand Motion Tracking Using RGB and Depth Data.» *International Conference on Computer Vision* (2013): n. pag. ICCV 2013. Web.



Биометрикс 3. Гарны дүрсийн үүсгэх олон өнцөгтийн харьцаа

Зураг 2.13 үзүүлснээр гарын салаануудыг холбосон шар шулуунуудын уртын нийлбэрийг l_1 , хуруунуудын өндгийг холбосон улаан шулуунуудын уртыг l_2 гэвэл харьцааг дараах системээр илэрхийлнэ:

$$\begin{cases} \frac{l_1}{l_2} > 0.4 \\ \frac{l_1}{l_2} < 0.6 \end{cases}$$

в). Объект таних

Зурганаас хүний гарыг таниж улмаар түүнийг мөрдөх туршилт нь дараах алхмуудаар гүйцэтгэгдэнэ. Үүнд:

1. Вэб камераас орж ирсэн зургаас босгочлол хийнэ.
2. Тухайн босгочилсон дүрсээс хаяалбар хийнэ. Үүгээр тухайн зурагт агуулагдах объектыг илрүүлнэ⁸².
3. Хүний гарын биометрикийг хийсвэрээр тодорхойлох (Үүнд хурууны оройн цэг буюу peak цэгийг мөн алганы төвийн цэгийг тодорхойлно).
4. Биометрикийн үр дүнд гарах хийсвэрлэл дээр үндэслэн харьцуулалт хийх замаар гарыг тодорхойлж уламаар түүнийг мөрдөнө.

Туршилтаар энгийн вэб камер ашиглан гарын дүрсийг таних, түүнийг мөрдөх үйл ажиллагааг C# хэл дээр боловсруулагдсан програм хангамжийн тусламжтайгаар явуулсан ба гарын ерөнхий хэлбэрт болон бусад онцлог хэлбэрүүдээр танилт хийлгэхэд хүний алганы хэсгийг таних хэсэг амжилттай хийгдсэн ба алганы хэсэг болон мөрийн хэсэгтэй нийлсэн хэсгийг танихад хүндрэл учирч байсан.⁸³ Энэ судалгаагаар гарын хөдөлгөөнийг танихдаа гарын алга болон тохойны өнцгийн байрлал болон мөрийн байрлалыг биометриксд нэмж өгвөл гарын хөдөлгөөнийг танихад үр дүнтэй нь харагдаж байна.

Дээрх томъёололоос үзвэл энэхүү судалгааны ажлын үр дүнд дүрс боловсруулалтын ирмэг илэрүүлэх, өнгөний шүүлтүүр хийх, өнцөг булан илрүүлэх, олон өнцөгтийн хотгор гүдгэр цэгийг олох Скланскигийн арга ашиглан гарыг таниж улмаар гарын биометриксээр хийсвэр загвар үүсгэн харьцуулж гарыг таних, цаашид гарын хөдөлгөөнийг тодорхойлохдоо мөрны байрлал болон тохой болон тохойны байрлалын мэдээллийг биометриксд нэмж тодорхойлох нь илүү дүр дүнтэй болно гэж бид үзэж байна.

Дүгнэлт. Цагдаагийн байгууллага объектын болон субъектын судалгааны цахим сангийн үйл ажиллагааг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг сулруулж болохгүй. Дижитал ертөнц, хиймэл оюун ухааны салбар дахь эрх зүйн шинэчлэлт, тодорхой харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт зэрэг нь цагдаагийн байгууллагаас объектын болон субъектын судалгаа явуулах тулгамдсан асуудлын нэг мөн.

⁸² «Шинжлэх ухаан технологийн их сургууль, мэдээлэл холбооны салбарын хөгжилд бидний гүйцэтгэх үүрэг 2014» эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн илтгэл.-УБ.,2014.

⁸³ Christian Theobalt. «Interactive Markerless Articulated Hand Motion Tracking Using RGB and Depth Data. » *International Conference on Computer Vision* (2013); n. pag. ICCV 2013.Web.

Цахим ертөнцийн өнөөгийн өвөрмөц энэ нөхцөлд цагдаагийн байгууллагаас объектын болон субъектын судалгаа явуулах, ашиглах, дүн шинжилгээ хийх хэн бүхэн, ялангуяа эрх зүйн онол, эрүү, эрүүгийн процесс, криминологи, криминалистикийн салбарын эрдэмтэн, судлаачдын хамтын ажиллагааг нэгтгэх, гэмт явдлын чанарын өөрчлөлтийн онцлогийн ирээдүйг урьдчилан тодохойлж, түүний эсрэг хариу арга хэмжээ хэрэгжүүлэх нь цагдаагийн байгууллагын тулгамдсан асуудал болоод байна.Цаашид хиймэл оюун ухааныг цагдаагийн байгууллагаас объектын болон субъектын судалгаа явуулахад хөгжүүлэхэд ашиглах нь бүртгэл, хяналтын систем буюу Patrol-2 системийн сангийн тогтолцоог үүсгэх, объектын судалгааны мэдээллийн санг төрөлжүүлэн ангилах, баяжуулах, мэдээлэл гаргаж өгөх, боловсруулалт хийх, эргэлтэд оруулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг ажлын үр нөлөөг дээшлүүлэх ач холбогдолтой хэмээн бид дүгнэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслээд дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1.Интернетэд сүлжээ ашиглан хүрээлэн буй орчин, хүн объект, тодорхой нутаг дэвсгэр, түүний онцлог шинжүүдийг хиймэл оюун ухаанаар Big Data үүсгэх;

2.Гэмт явдал нь өнөөдрийн адил нөлөөт толь шиг нийгэм, эдийн засаг, улс төрийн үйл явцын тусгал бөгөөд түүнийг судлахдаа судлаачид математик арга зүйн үндсэн дээр гэмт явдлын чиг хандлагыг тодорхойлж, үр дүнд нь гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга зүй боловсруулж байгаа ч цаашид гэмт явдлын хэтийн төлөвийг урьдчилан таамаглах, бүцэд, хөдөлгөөнийг хянах зэрэгт хиймэл оюун ухааныг ашиглах;

3.Дижитал ертөнц, хиймэл оюун ухааны салбар дахь эрх зүйн шинэчлэлт, тодорхой харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт зэрэг нь хууль зүйн шинжлэх ухааны тулгамдсан асуудлын нэг бөгөөд хиймэл оюун ухааныг ашиглах салбар, түүний хэрэглээний талаарх эрх зүйн зохицуулалт бий болгох;

4.Цахим технологи хөгжихийн хэрээр гэмт явдалтай тэмцэхэд хүндрэл учирч байгааг анхаарч түүний тэмцэх арга, хуучин тогтолцоог өөрчилж, мэдээллийн эрин зууний хууль сахиулагч нарыг цахим техник технологи тэр дундаа хиймэл оюун ухааны өндөр түвшинд бэлтгэж, ашиглах хууль сахиулагчдыг чадваржуулах гэх мэт саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материал

1. Klaus Schwab. The Fourth Industrial Revolution. World Economic Forum. Cologny/Geneva Switzerland.2017.
2. The Malicious Use of Artificial intelligence: Forecasting, Prevention, and Mitigation: February 2018
3. Christian Theobalt. «Interactive Markerless Articulated Hand Motion Tracking Using RGB and Depth Data» International Conference on Computer Vision (2013): n. pag. ICCV 2013.Web.
4. docviewer.yandex.ru

**ЗАМААС ҮҮДЭН ГАРСАН ОСОЛ, ХЭРГИЙГ ШАЛГАХ
ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА
INVESTIGATION OF ROAD ACCIDENTS AND CASES NEED**

Д.Нямдорж

ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн
эрдэм шинжилгээний ажилтан-багш,
доктор, цагдаагийн дэд хурандаа

Nyamdorj D.

Research Institute Crime, police and domestic military
Studies research worker-teacher of the center,
doctor of law, police lieutenant colone

nyamdorj_mvjd@yahoo.com

В.Номинчулуун

ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн
эрдэм шинжилгээний ажилтан-багш, цагдаагийн хошууч

Nominchuluun.V

Researcher and lecturer, police major
Institute of Criminology and Police Studies of the
University of Internal Affairs, Mongolia.

vnomio0201@gmail.com

Товч агуулга: Монгол Улсын хэмжээнд авто замын хийц, арчлалт, хөдөлгөөн зохион байгуулалтын нөхцөл байдал зэргээс үүдэн гарах зам тээврийн осол, хэргийн нөхцөлийг судлан гаргах түүнийг практикт эргэлтэд оруулах асуудал ихээхэн тулгамдаж байна.

Замын нөхцөлөөс үүдэн гарсан зам тээврийн осол, гэмт хэргийг шалгах цогц үйл ажиллагааны ач холбогдол, хэрэгцээ шаардлагын талаар өгүүлнэ.

Abstract: In Mongolia, the research of road traffic accidents from the influence of road design and construction to their practical use is a very pressing problem.

The importance and need for comprehensive investigation of traffic accidents and crimes caused by road conditions will be discussed.

Түлхүүр үгс: Замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам, замын байгууламж, замын хөдөлгөөний зохион байгуулалт, тэмдэг, гэрлэн дохио.

Key words: Traffic safety, roads, road structures, traffic organization, signs and traffic lights.

Оршил хэсэг. Дэлхий дээр жил бүр зам тээврийн ослын улмаас 1.19 сая хүн амь насаа алдаж, олон сая хүн хүнд гэмтэж бэртдэг⁸⁴. Дээрх эмгэнэлт явдлын 90 гаруй хувь нь хөгжиж буй орнуудад тохиолддог байна. Тодруулбал, олон улсын байгууллагаас гаргасан замын хөдөлгөөний аюулгүй байдлын судалгаагаар 5-29 насны хүүхэд, залуучууд гэр, сургууль

⁸⁴ <https://montsame.mn/ru/read/340644>.

хооронд ирж, очих замдаа зам тээврийн осолд хамгийн ихээр өртөж, хүнд бэртэл гэмтэл авах, тахир дутуу болох, цаашлаад амь насаа алдаж байгаагийн багагүй хэсэг нь замын нөхцөлөөс үүдэн гарч байгаа зам тээврийн осол, гэмт хэргээс шалтгаалж байна гэж үзэж байна.

Үндсэн хэсэг. Дэлхийн банкны судалгаагаар Номхон далайн баруун хэсэгт дунджаар 100000 хүн тутмын 15.4 тохиолдол, Европт 6.7 тохиолдол нь зам тээврийн ослоор нас барж байна⁸⁵. Харин Монгол Улсад 100000 хүн тутмын 21 тохиолдол нь зам тээврийн ослоос үүдэн нас барж байна гэсэн мэдээллээс харахад энэ төрлийн нас баралтаар дэлхийд дээгүүр бичигдэж байгааг Үндэсний Статистикийн Хороо танилцуулжээ⁸⁶.

Замын чанар, түүний эвдрэл, гэмтлээс шалтгаалж замын хөдөлгөөний аюулгүй байдал алдагдах тохиолдол Монгол Улсын хэмжээнд бүртгэгдэхгүй байгаа нь энэ төрлийн шалтгаант холбоосыг нээн гаргах, зам хариуцсан байгууллагуудад хариуцлага тооцон эргэж түүний чанарыг сайжруулах ажлын арга зүй, хандлага, хэрэг бүртгэх туршлага маш бага байгааг харуулж байна.

Зам түүний орчны аюулгүй байдлыг хэмжих арга зүй, хандлага төлөвшихгүй байх нь тухайн улсын зам, замын байгууламжийг барьж, байгуулах, арчлалт, засвар дагаад хөгжиж чаддаггүй. Замаас шалтгаалсан хөдөлгөөний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг тооцохдоо түүний өөрт нь тавигдах шаардлага ямар вэ? гэдгээс эхлэн холбогдох эрх зүйн баримтуудыг нэгтгэн судалж, хэрэгцээ шаардлагагүй болсон актуудыг жагсаалтаас хасаж, хэрэгцээт дэд актуудыг шинээр бий болгон мөрдүүлэх асуудалд бодлого боловсруулах нь зүйтэй.

Замаас шалтгаалах зам тээврийн ослын шинжид автозамын бүтцийн элементүүд, түүний нөхцөл байдал, тээврийн хэрэгслийн болон явган зорчигчийн хөдөлгөөний эрчим, автозамын байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, жилийн улирлын, сарын, хоногийн болон цагийн нөхцөл байдал гэх зэрэг обьектив шинжтэй хүчин зүйлсээс гадна жолоочийн болон зорчигч, явган зорчигчийн биеийн байдал, тэдний замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гаргаж байгаа үйлдэл, шалтгаан нөхцөл зэрэг субъектив шинжтэй хүчин зүйлсийн нөлөөлөл зэрэг бүгд багтдаг.

Зам, орчны нөлөөллөөс үүдэн гарсан зам тээврийн осол, хэргийн газарт дараах ерөнхий шинж, нөхцөлүүдийг хамруулан тооцох нь оновчтой. Үүнд:

- Замын уулзварын зохион байгуулалтын оновчгүй төсөллөлт;
- Замын хийцийн алдаа, хотын сүлжээний уулзваруудын дарааллын сөргөлдөх гажиг;
- Замын хөдөлгөөний чиглүүлэх хэрэгсэл, хайс, хашлаганы чанар тэдгээрийн байршуулалтын алдаа;
- Авто замын эвдрэл гэмтэл;
- Замын ойролцоох зогсоол, талбай, хашаа, хороолол, шатахуун түгээгүүр, үйлдвэр, албан байгууллага зэрэг тээврийн хэрэгслийн дамжин өнгөрөх хөдөлгөөнд зориулагдаагүй нутаг дэвсгэрээс гарахад үзэгдэлтийг хязгаарлах тэмдэг, самбар, бусад байнгын саад;
- Өдрийн цагт, нарны гялбалтаас үл хамгаалагдсан замын хэсэг, шөнийн цагт жолооч руу хандуулсан нүд гялбуулах хяналтын камерын болон гудамж, замын гэрэлтүүлгийн тохиргоо;
- Цаг уур, орчны тааламжгүй байдлаас хамгаалах хэрэгслийн бусад эвдрэл, гэмтэл, алдааны сөрөг нөлөөллийг хамруулан ойлгоно.

Дэлхий дахинаа жижиг хэмээн алдаршсан, доктор Уильям Хаддон /William Haddon 1926-1985/ нь Массачусетс мужийн технологийн институт, Харвардын анагаахын их

⁸⁵ <https://montsame.mn/ru/read/340644>.


⁸⁶ <https://ikon.mn/n/2p7g>.

сургуулийг дүүргэсэн, инженер, эмч мэргэжилтэй бөгөөд бүхий л амьдралынхаа карьерын туршид, оюун ухаанаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын судалгааны ажилд зориулсан байдаг.

Тэр бээр хамгийн хүнд үе буюу 1966 онд АНУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний агентлагийг удирдаж байжээ. Тэр бээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Хүн-автомашин-зам-орчин /ХАЗО/ системийн элементүүдийн хамаарлыг У.Хаддоны матрицын дагуу авч үздэг. Мэдээжээр дараах загвар хөгжсөөр өнөөг хүрсэн ба нэршлийн хувьд ч сонгодог болгосон.⁸⁷

Доктор Уильям Хаддоны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Хүн-автомашин-зам-орчин /ХАЗО/ системийн элементүүдийн хамаарлыг матрицын дагуу тэдгээрийн хамаарлаар тооцон Дэлхийн олон улсуудад нийтээр жишиг үзүүлэлт болгон хэрэглэж байна. Уг матрицаар Зам тээврийн 1000 осол тутмын хэдэн хувийг ХАЗО системийн ямар элемент эзэлж байгааг болон тэдгээрийн харилцан хамаарлыг харуулдаг байна. Сүүлийн 20 жилийн дунджаар Америкийн Нэгдсэн Улсад ХАЗО системийн замын хүчин зүйлийн нөлөөлөл, харилцан хамаарал 35% буюу 350 осол хэрэг замын тодорхой нөхцөл, хүчин зүйлээс шалтгаалдаг бол өндөр хөгжилтэй Европын холбооны Улсуудад 28% буюу 280 орчим бүртгэгджээ.

Энэ мэдээлэл, тоон үзүүлэлт нь Дэлхийн өндөр хөгжилтэй, зам үйлдвэрлэл нь сайн хөгжсөн улсуудад асар ихээр тэмдэглэгдсэн нь эргээд улсын хөгжилд нь чухал түлхэц болдог байна.



Зураг №1. Доктор Уильям Хаддоны ХАЗО системийн харилцан хамаарлын бүрдүүвч.



Зураг №2. ХАЗО системийн харилцан хамаарал Монгол Улсад.

Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын үр дүнг зам тээврийн осол, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийн статистик дүн шинжилгээнээс харж болно. Өөр хоорондоо харилцан хамааралтай Хүн-Автомашин-Зам-Орчин системийн өнөө цагийн бодит байдал зураг 2-оос харагдаж байна.

⁸⁷ https://en.wikipedia.org/wiki/Haddon_Matrix.

Энд нийт Зам тээврийн ослын 99.9% нь хүний хүчин зүйлээс, 0.1% нь автомашины хүчин зүйлээс шалтгаалан үйлдэгддэг бол замын хүчин зүйлээс шалтгаалсан осол 0 буюу байхгүй гэдэг нь Монгол Улсын хэмжээнд замын нөхцөл байдал туйлын сайн гэж үзэхээр байна. Үнэн хэрэг дээрээ Монголчууд Америкийн болон Европын иргэдийн зорчдог замаас хол дутуу, эвдрэл, гэмтэл ихтэй маш муу, арчилгаагүй замаар зорчиж байгаа билээ. Мөн орчны хүчин зүйлээс шалтгаалах осол, хэргийн талаар ойлголт ч байхгүй гэхэд хилсдэхгүй.

Замаас шалтгаалах зам тээврийн ослын объектив шинжтэй хүчин зүйлсийг төрөөс авах арга хэмжээд сүүлийн үед хийгдсэн эрх зүйн шинэчлэлийн нэг бол 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр шинээр батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль”⁸⁸ нь томоохон алхам болсон. Энэ хуулийн үзэл санааны тэргүүлэх хэсэг бол хотын авто замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах явдал юм. Түүнчлэн шууд бусаар нөлөөлж буй шалтгаан болон Зам тээврийн осол хэргийг багасгах үүднээс авто зогсоолын асуудлын шийдлийг тусгасан нь нэлээд ач холбогдолтой юм.

Авто зам нь ачаа ба замын хөдөлгөөнд оролцогсдын тав тухтай байдлыг хангахын зэрэгцээ автомашины хөдөлгүүрээс гарах бохирдлыг багасгах, өөрөөр хэлбэл тээвэрлэлтийн өртгийг хямд байлгах нөхцөлийг хангах ёстой. Тодруулбал, замын эвдрэлтэй хэсэгт хурдаа хассан тээврийн хэрэгсэл, хөдөлгүүрийн мушгих моментыг нэмэгдүүлэн дахин хурд авахдаа, хэвийн хурдтай явсан үеийнхээс 2.5 дахин энерги зарцуулан, тийм хэмжээний их хорт бодисыг ялгаруулдаг.

Замаас үүдэлтэй зам тээврийн осол, хэргийн талаар статистик хангалтгүй үзүүлэлт зааж байгаа нь энэ төрлийн хүчин зүйлийн талаар төрөөс барих бодлого бага байгааг харуулж байна. Дэлхийн нийтээр Зам тээврийн осол, хэргийн тоон үзүүлэлтийг бууруулахын тулд У.Хаддоны матрицаар замын хөдөлгөөний аюулгүй байдлын ХАЗО системийн хамаарал, алдагдлаар хэмжиж, өөрсдийн улс, орнуудынхаа газар зүй, цаг уурын байдалд тохируулан ажиллаж байгаагаас суралцаж, хамтран ажиллах хэрэгтэй байна.

Замаас үүдэлтэй зам тээврийн осол, хэргийн судалгааг явуулахад саад болж байгаа олон хүчин зүйлийн нөлөөлөл байдаг. Үүнд:

- Хууль эрх, зүйн орчны өөрчлөлт;
- Зам тээврийн осол, гэмт хэрэгтэй тэмцэх бодлого;
- Зам, замын байгууламжийн үйлдвэрлэлд хийх технологийн шинэчлэлт;
- Зам үйлдвэрлэлийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог сайжруулах;
- Хууль сахиулах байгууллагын алба хаагч нарыг энэ чиглэлээр мэргэшүүлэн сургах;
- Шүүх эрх мэдлийн байгууллагуудын нэгдсэн ойлголт, харилцаа шинээр бий болгох;
- Замаас үүдэн гарах осол, хэргийг илрүүлэн тогтоох, шалгах, туршлага, технологийн хөгжил сайтай гадаадын улсуудад өөрийн орны хүний нөөц, мэргэжилтнүүдийг бэлтгэх, мэргэшүүлэн давтан сургах зэрэг бусад олон асуудлуудыг эхний ээлжид шийдэх хэрэгтэй юм.

Тээврийн цагдаагийн албаны мэргэжилтнүүдэд замаас үүдэн гарах осол, хэргийг шалган шийдвэрлэхэд нийтлэг зарим нэгэн бэрхшээл хүндрэл байдаг. Үүнд:

- Замаас үүдэн гарсан осол, хэрэгт акт, дүгнэлт гаргахад хариуцлага тооцуулах зам хариуцсан байгууллагууд нь ихэвчлэн орон нутгийн өмчийн харьяа байх ба тэдгээр байгууллагууд босоо удирдлагын нөлөөлөл ихээхэн саадтай;

⁸⁸“МУ-ын Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль” УБ., 2023.

- Замаас үүдэлтэй осол, гэмт хэргийг цагдаагийн байгууллагаас шалгах эрх зүйн практик харилцаа, хандлага тааруу;

- Шинээр сургууль төгсөж ирсэн алба хаагчдын сургалтад энэ чиглэлийг тусгах, хандлагыг төлөвшүүлэх;

- Замаас үүдэн гарах осол, хэргийн шинжилгээг хөндлөнгийн байгууллагуудаар дүгнэлт гаргуулах саналтай байдаг ч мэргэжлийн байгууллагууд дутмаг;

- Зам тээврийн осол, хэргийг мөрдөх байгууллагуудын алба хаагчид өөрийн санаачилгаар бус ажлын хэрэгцээ, шаардлагад тулгуурласан судалгаа хийх боломжгүй;

- Замаас үүдэн гарах осол, хэрэгт ихэвчлэн эрүүгийн хэрэг нээн шалгадаг ба үзлэг, хэмжилт, тооцоолол хийх онолын мэдлэг, номлол байхгүй зэрэг бусад хүндрэлүүд байна.

Замын нөхцөлөөс үүдэн гарсан ослоудад уулзвар болон эргэлттэй газруудад автомашины төвөөс зугтах хүчний эсрэг налууг хийх нь жолоочийн автомашинаа жолоодох явцад нэлээд нэмэр, тулгуур, түшиг болдог. Энэхүү өгүүллээр замын эргэлттэй хэсэгт хүчнүүд ямар ямар чиглэлд үүсдэг, замын өөрийнх нь аюулгүй байдлын үзүүлэлтүүд хэрхэн хангагддаг талаар товч орууллаа.

Ачаа эргэлтийн хугацаа нь тээврийн хэрэгслийн хурд, замаар нэвтрэх тээврийн хэрэгслийн тоо буюу хөдөлгөөний эрчим, тэдгээрийн хоорондох зай, өдрийн цагийн ачаалал зэргээс шууд хамаарна. Хүнд даацын автомашины дугуйны даралт замын гадаргуудад ачааллан, эргэлт дээр 4 м хүртэл радиустай тойрог үүсгэдэг ба захын тойрогт илүү даралт үүсгэн агаарын болон нарны элчинд халсан гадаргуу зарим тохиолдолд ховил татдаг. Энэ нь бас л замаас үүдэн гарах осол хэргийн эрсдэлийг нэмэгдүүлэн бий болгодог.

Эргэлт- Эргэх хэмжээ, эргэх хэм⁸⁹: Муруйн замын гадна захын буюу нэгдүгээр эгнээний зорчих хэсгээр явж байгаа автомашин нь тус зурвасын хөндлөн налуу чиглэлд төвөөс зугтах хүчийг үүсгэдэг ба проекцын чиглэлтэй давхацдаг болохоор дотор талын зорчих хэсгээр яваа авто автомашиныг бодвол илүү тогтворжилттой байдаг⁹⁰. Нөгөө талаас эсрэг урсгалын угталцан ирэх автомашиныхыг бодвол түүний дугуйн хөндлөн хазайлтын хэмжээ илүү байдагтай холбоотойгоор жолоодлого хийхэд хүндрэлтэй байдаг.

Гэтэл газрын хэвгий, зайн нөхцөл бусад барилга байгууламжуудаас шалтгаалан тэр болгон том радиустай эргэлтүүдийг хийх бололцоогүй байдаг. Ийм учраас автомашины тогтворжилтыг сайжруулах ба жолоодлогын итгэлтэй байдлыг ихэсгэх зэргийн үүднээс замын муруй хэсэг дээр нэг налуутай хөндлөн огтлол бүхий эргэлтийг байгуулдаг.

Зураг №3. Зам дээрх эргэлтийн схем.

L - эргэлтийг гүйцээх хэсэг ба шилжилтийн муруйн урт;

R – Муруйн радиус;

K - тойрог муруй;

B -зорчих хэсгийн өргөн;


i_o - Зорчих хэсгийн ус буулгах налуу;

i_{dag} - дагуу чиглэлийн налуу;

$i_{эрг}$ – эргэлтийн налуу;

A - үндсэн муруйн өргөссөн хэсэг.

Хөдөлгөөний үед замын мурийсан хэсэгт тээврийн хэрэгслийн



⁸⁹<https://mongoltoli.mn> //Татаж үзсэн: 15.11.2024

⁹⁰Проектирование автомобильных дорог.Учебни.

эргэлтийн дагуу төвөөс зугтаах хүчийг тооцоолох томьёо:

$$G = \frac{mv^2}{R}$$

m - тээврийн хэрэгслийн жин;

v – тээврийн хэрэгслийн хурд.

Мэдээжээр эргэлтийн зорчих хэсэг болон хөвөө нь муруйн төв рүү налсан чиглэлтэй байна. Өмнө нь удаан хугацааны туршид эргэлтийг замын бага радиустай муруй дээрх автомашины хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай нэмэлт элемент гэж үздэг байж.

Зураг 4. Гэтэл гол шугам замын ашиглалтын туршлагаас харахад эргэлт нь жолоочид муруй хэсгийг шулуун хэсгийн хурдтайгаар туулахад сэтгэл зүйн эерэг нөлөөлөл ба үйлчлэл үзүүлдэг болохыг баталсан.

Хэрэв эргэлт үгүй бол муруй дээр хурд буурдаг. Хөрш ОХУ-ын Барилгын норм ба дүрмээр I ангиллын авто замын хувьд радиус нь 3000 м ба түүнээс бага байхад, бусад ангиллын замуудын хувьд радиус нь 2000 м-ээс бага байхад тус тус эргэлтийг байгуулах шаардлага тавьдаг байсан.

Манайд хэрэглэгдэж байсан барилгын норм ба дүрэм үндсэндээ тухайн үеийн ЗХУ-ын БНБД-ийг орчуулан найруулж ашиглаж байжээ. Гэтэл орчин үеийн автомашиныудын хурд, зүтгэх хүчний хэмжээ өндөр болсонтой уялдаж Монгол оронд өнөө үед мөрдөж байгаа "Авто зам төсөвлөх" БНБД 32-01-00-р эргэлт төсөвлөх шаардлагагүй хэвтээ муруйн хамгийн бага радиусыг доорх Хүснэгт 1-д харуулсан.

Хүснэгт №1.

Хэвтээ муруйн радиус, м	Эргэлт дээрх зорчих хэсгийн хөндлөн налуу, %							
	140	120	100	80	60	50	40	30
6000-5500	20							
5500-5000	20	20						
5000-4500	30	20	20					
4500-4000	30	20	20					
4000-3500	40	30	20					
3500-3000	40	30	20					
3000-2500	40	30	20					
2500-2000	50	40	20	20				
2000-1500	60	40	30	20				
1500-1000	60	50	40	20	20			
1000-900		60	50	30	20	20		
900-800		60	50	30	20	20		
800-700		60	50	40	20	20		
700-600			60	40	30	20		
600-500			60	40	30	20	20	
500-450			60	50	30	20	20	
450-400			60	60	40	30	20	
400-300				60	40	30	20	



300-250				60	50	40	30	20
250-200				60	50	40	30	20
200-150					60	50	30	20
150-100					60	60	40	30
100-75						60	50	40
75-50							60	50
50-30							60	60

Үүгээр бид замаас үүдэн гарах зам тээврийн осолд үзүүлэх нөлөөлөл, хийцийн алдааны талаар зохих хэмжээний ойлголт, төсөөлөлтэй болсон гэж үзэж байна.

Ойлголт, мэдлэгийн түвшнээ нэмэгдүүлэн хөгжүүлж улмаар замаас үүдэн үйлдэгддэг зам тээврийн осол, хэргийн шийдвэрлэлт хийсний дараа зохих байгууллагуудын ажлын гүйцэтгэл, үр өгөөж нэмэгдэн замын нөхцөл эрс сайжирч, гэмтэл, нас баралт багасах нь тодорхой юм.

Дээрх өгүүлэмжээр зөвхөн замын хийцийн эргэлттэй хэсэгт авах арга хэмжээ, түүний ач холбогдлын талаар мэдэж авч байгаа мэт боловч цаашид замын уг хэсгийн хийцийн өөрчлөлтийг тооцооллын тусламжтайгаар хийх, түүний хэрэгцээ шаардлага байгаа эсэх талаар дүгнэлт гаргах асуудлыг юм.

Дүгнэлт. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг шинэ шатанд гаргахад Тээврийн цагдаагийн албаны мөрдөгч, хэрэг бүртгэгч шинжээч зэрэг халуун цэгт зам тээврийн осол, хэрэгтэй нүүр тулан ажилладаг алба хаагч нарыг мэргэшүүлэн сургах нь практикийн асар хэрэгцээ, шаардлагатай.

Өнөөгийн нөхцөлд зам дээр үүссэн нүх, эвдрэл, гэмтэл, борооны тогтоол ус, бусад саадыг тойрон гарахдаа эсрэг урсгалд орж зам тээврийн осол гаргасан жолооч нарыг

- Замын хөдөлгөөний дүрмийн 11.3 дахь хэсэгт эсрэг хөдөлгөөнтэй хоёр эгнээгээр зорчдог замд гүйцэж түрүүлэх буюу саадыг тойрон гарахаас бусад тохиолдолд эсрэг урсгал сөрөхийг хориглоно

- Мөн дүрмийн 12.1 дэх хэсэгт “Жолооч хөдөлгөөний эрчим, тээврийн хэрэгсэл болон тээж яваа ачааны онцлог, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан тээврийн хэрэгслийн хурдыг энэ дүрэмд тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр тохируулан сонгож явна.”

- 12.3 дахь хэсэгт “Жолооч хөдөлгөөнд аюул, саад тулгарахыг мэдсэн үед тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоох арга хэмжээ авна”⁹¹ гэснийг болон бусад холбогдох дүрмийн заалтуудаар асуудалд позитив хандлагаар хандан шийдвэрлэж ирсэн нь ихээхэн хоцрогджээ.

- Замын цагдаагийн алба хаагч нарын хэргийн газарт хийгдэж байгаа ажлуудыг иргэдийн зүгээс ихээхэн шүүмжлэн, ослын зураг зурах, хэмжилт хийх, замын хөдөлгөөний дүрмээс тохирох заалтыг эшлэл болгон хуулан бичих зэрэг нь эрдэм, чадал, оюуны тооцоолол шаардагдахгүй, шинжлэх ухааны мэдлэг ашиглагдахгүй байна гэжээ.

Зөвхөн жолоочийг /хүнийг/ буруутгагдан шийтгэгдэн шийдвэрлэгдэж байгаа олон мянган зам тээврийн осол, гэмт хэргийн цаад талд хэн нэгэн иргэн, хуулийн этгээд ял завшиж байгааг нэн даруй таслан зогсоох шаардлагатай байна.

Харин хууль, техникийн шинжлэх ухааны шинэ дэвшил, технологийг шингээсэн мэдлэг оюунаар хэрэг шийдвэрлэлтэд хандах нь манай нийгмийн эрх зүйн тогтолцооны цаашдын хэдийн төлөвийг гэгээнээр тодорхойлох юм. Замын нөхцөлөөс үүдэн үйлдэгдэг зам

⁹¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2018., №42. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм

тээврийн осол хэргийг шүүхээр шийдвэрлээд л орхидог зүйл бас биш гэдгийг судлаач бид хэрхэвч мартаж болохгүй.

Санал. Замаас үүдэн үйлдэгдэг зам тээврийн осол, хэргийн оновчтой шийдвэрлэлт нь дараах хэрэг хэрэгцээ, шаардлагыг хангах ба дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд :

1. Зам тээврийн осол, хэргийн бүртгэлтэд шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлээр онол, арга зүй хэлэлцүүлэг, семинарыг Тээврийн цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс болон Тээврийн прокурорын газартай хамтран хамгийн багадаа улиралд нэг удаа зохион байгуулж байх;

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд зам, орчны нөлөөллөөс үүдэн гарсан зам тээврийн осол, хэргийн онцлог, шинжийн талаар зүйлчлэн оруулах;

3. Орон нутагт үйлдэгдэж байгаа зам, орчны нөлөөллөөс үүдэн гарсан зам тээврийн осол, гэмт хэргийн шийдвэрлэлтэд хөндлөнгийн шалгах алба хаагчийг томилон ажиллуулж, мөн тийм шинжээчдийн багаар акт, дүгнэлт гаргуулах журам боловсруулан хэрэгжүүлэх;

4. Зам, орчны нөлөөллөөс үүдэн гарсан зам тээврийн осол, хэргийн онцлогт чиглэгдсэн урьдчилан сэргийлэх ажлыг хэсгийн төлөөлөгч, олон нийтийн байцаагч нарын хамтаар зохион байгуулан урамшуулал олгож хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;

5. Зам, орчны нөлөөллөөс үүдэн давтамжтай үйлдэгдсэн зам тээврийн осол, хэргийн газарт замын эвдрэл, гэмтэл, объектын судалгаа, саналыг иргэдээс цахимаар авч Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх ажил, үүргийн хүрээнд өрнүүлэн үр дүнг олон нийтэд танилцуулах, уг ажлыг бүтэн жилийн хугацаанд тогтмол зохион байгуулж хэвшүүлэх;

6. Сэдвийн хүрээнд хамаарагдах зам тээврийн осол, хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч нарын гэм буруугийн үйлдэл эс үйлдлийг бодитоор тогтоох, зүйлчлэлд Тээврийн прокурорын хяналтыг сайжруулах;

7. Зам, орчны нөлөөллөөс үүдэн гарсан зам тээврийн осол, хэргийг шийдвэрлэсэн дэлхий нийтийн жишиг, техник, хяналтын болон эрх зүйн туршлагаас судлан Монгол Улсад нутагшуулан хөгжүүлэх;

8. Зам, орчны нөлөөллөөс үүдэн гарсан зам тээврийн осол, хэргийн шийдвэрлэлтэд хэрэгцээт гарын авлага, ном, сурах бичгийг бичиж боловсруулах ажлыг дэмжих;

9. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан эх сурвалж

1. Проектирование автомобильных дорог. Учебник. Бабков.В.Ф, Андреев.О.В 2-е изд. Москва 1987.
2. Д.Нямдорж “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэс” УБ., 2024.
3. МУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015 он, №28
4. МУ-ын Замын хөдөлгөөний дүрэм // Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2018 он, №42
5. МУ-ны Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль УБ., 2023.

Цахим холбоос:

1. <https://montsame.mn>
2. <https://ikon.mn>
3. <https://mongoltoli.mn>

**ХҮҮХЭД ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗОРЧИГЧ ХЭЛБЭРЭЭР
ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛД ӨРТӨЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**
BY PASSENGER TYPE OF VEHICLE FOR CHILDREN
CURRENT SITUATION OF TRAFFIC ACCIDENTS

С.Индра

Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн дэд хурандаа,
хууль зүйн магистр

Indra.S

Lecturer of the Law Department at the Police
School, police lieutenant colonel, master of Laws

Хураангуй: Монгол Улсын нийгмийн хөгжил дэвшил, хүн амын амьжиргааны түвшний дээшилж байгаа зэргээс хамааран сүүлийн жилүүдэд тээврийн хэрэгслийн тоо хурдацтайгаар нэмэгдэж байгаа нь зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчил олноор гарахад нөлөөлж байна. Тэр дундаа хүүхэд тээврийн хэрэгслийн зорчигч хэлбэрээр зам тээврийн осолд өртөж, хохирч байгаа нь сэтгэл эмзэглүүлсэн асуудлын нэг болоод байгаад анхаарал хандуулах шаардлагатай болоод байна.

Энэхүү өгүүлэлд зам тээврийн осолд тээврийн хэрэгслийн зорчигч хэлбэрээр оролцож байгаа хүүхэд өртөж байгаа явдал, үүнд нөлөөлж буй хүчин зүйл, түүнийг бууруулах арга замын талаар товч авч үзсэн болно.

Abstract: Due to the social development of Mongolia and the improvement of the living standards of the population, the number of vehicles has been increasing rapidly in recent years, which has contributed to the occurrence of traffic accidents, crimes, and violations. In particular, it is necessary to pay attention to the fact that a child is a passenger in a vehicle and is injured in a traffic accident.

This article briefly discusses the impact of children who are passengers in traffic accidents, the factors that influence it, and ways to reduce it.

Түлхүүр үг: Зам тээврийн осол, зам тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хүүхэд өртсөн зам тээврийн осол

Key words: Road traffic accidents, road vehicles, road safety, road accidents involving children.

Үндсэн хэсэг. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 239 дүгээр тогтоолоор⁹² баталсан Монгол Улсын замын хөдөлгөөний шинэчлэгдсэн дүрэмд хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалах хэд хэдэн заалт оруулсан нь маш чухал заалт болсон. Тухайлбал:

- “Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл” таних тэмдэг бүхий автобусаас хүүхэд буулгах, түүнд суулгах үедээ ослын дохионы гэрлээ асааж байх, тус автобусанд ойртон ирсэн жолооч хурдаа хасаж анхаарал болгоомжтой явах, хүүхдүүд зам хөндлөн гарч байвал зогсож урьдчилан өнгөрүүлэх;

⁹² <https://legalinfo.mn>. //Татаж үзсэн: 15.11.2024. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм

- Замын хөдөлгөөнд жагсаалаар оролцож яваа хүүхдийн тоо дөчөөс олон бол жагсаалын зөвхөн урд болон ардаас гадна дунд хэсэгт нь насанд хүрсэн хүн хамгаалж явна;

- Хүүхэд тээвэрлэх автобусан доторх суудал бүрийг хамгаалах бүсээр тоногдосон байх шаардлага нэмсэн;

- Долоон нас хүрээгүй хүүхдийг насанд хүрсэн харгалзах хүнгүйгээр тээврийн хэрэгсэлд үлдээхийг хориглосон;

- 10 хүртэлх насны хүүхдийг тээвэрлэхдээ биеийн жин, өсөлтөд нь тохирсон зориулалтын нэмэгдэл суудал буюу хамгаалах хэрэгсэл ашиглана гэх мэт олон улсын стандартад нийцсэн хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалах заалтууд орсон байдаг.

Мөн дүрмийн 23.9. Дараахь тохиолдолд хүн тээвэрлэхийг хориглоно⁹³:



е/ 10 хүртэлх насны хүүхдийг мотоциклын арын суудалд;

ж/ жолоочийн өвөр дээр, эсхүл энэ дүрмийн 23.8-ын тайлбарт дурдсанаас бусад тохиолдолд суудлын автомашинд болон ачааны автомашины жолоочийн бүхээгт зорчигчийн өвөр дээр тээвэрлэхийг хориглоно гэж заасан байдаг.

Гэвч дээрхи заалтууд эцэг эх, асран хамгаалагчдын хайнга, хариуцлагагүй хандаснаас үүдэн хүүхэд өртсөн зам тээврийн осол гарсаар байгаа нь анхаарах зайлшгүй байгааг харуулж байна. Иймд эцэг эх, асран хамгаалагч нар хүүхэд тээвэрлэх үедээ зориулалтын суудалд суулгаж хэвших, хүүхдийн нас өндөрт тохирсон зориулалтын суудал, суудлын бүсийг хэрэглэх нь зам тээврийн ослоор нас барах, хүнд гэмтэх эрсдэлийг бууруулдаг нь бусад улс орнуудын туршлага зэргээс харагддаг.

Монгол Улсад хүүхэд өртсөн зам тээврийн ослын үзүүлэлтийг өнгөрсөн мөн үетэй харьцуулахад нийслэлд 31 нэгжээр буюу 7.0 хувиар, орон нутагт 40 нэгжээр буюу 12.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байгаа нь шинэчилсэн замын хөдөлгөөний дүрэм төдийлөн мөрдөгдөхгүй байгаа нь харагдаж байна.

Зам тээврийн ослын статистик үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:




Дээрхи графикуудаас харвал хүүхэд өртсөн зам тээврийн ослыг 2022 онтой харьцуулахад 2023 онд улсын хэмжээнд өртсөн зам тээврийн осол өмнөх оныхоос нийт бүртгэгдсэн тоо нь 71 нэгжээр өссөн. Үүнээс нийслэлд бүртгэгдсэн нь 473 буюу 55.9 % нь 373 буюу 44.1 % нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Бид өнөөдөр зам тээврийн осол, зөрчилд хүүхэд өртөж байгаа шалтгаан нөхцлийг судалж, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг төрийн болон төрийн бус, нутгийн захиргаа, аж ахуйн нэгж, байгууллага гээд бүх түвшинд бүгдийн идэвхи оролцоонд дээр тулгуурлан

⁹³ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Дүрэм шинэчлэх тухай” 239 дүгээр тогтоол Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм

оролцох, хууль эрх зүйн орчныг сайжруулах зэрэг бүхий л түвшинд зохион байгуулах



хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн гэр, сургууль, цэцэрлэг гэсэн маршрутаар явж байгаад зам тээврийн осолд өртдөг байна. Энэ маршрутаар явахдаа анхаарал боломжгүй, зам хөндлөн гарахдаа гарц, гарамтай хэсгээр гарахгүй байх, асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр осолд өртөж байна.

Улсын хэмжээнд хүүхэд өртсөн 846 зам тээврийн осол бүртгэгдснээс 53 хүүхэд амь насаа алдаж, 900 хүүхэд эрүүл мэндээрээ хохирсноос 172 буюу 19.1 хувийг хүнд, хүндэвтэр гэмтэл, 728 буюу 80.9 хувийг хөнгөн зэргээр гэмтсэн байна.

Зам тээврийн ослын улмаас 2023 онд амь насаа алдсан нийт 551 хүний 53 буюу 9.6 хувийг хүүхдийн нас баралт, гэмтэл, бэртэл авсан 3059 хүний 900 буюу 29.4 хувийг хүүхдийн бэртэл гэмтэл эзэлсэн байна. Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн 55.9 хувь нь нийслэлд бүртгэгдсэн боловч хүүхдийн амь нас хохирсон зам тээврийн ослын 94.3 хувь нь орон нутгийн замд байна.

Орон нутгийн замд Ховд, Хэнтий, Дархан-Уул аймгуудад хүүхэд өртсөн зам тээврийн осол давамгайлж байна⁹⁴.

График №2 2022 оны осол





График №3. 2023 оны осол



⁹⁴ Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл цуврал №13 70 дахь тал

Нийслэлийн хэмжээнд 2023 онд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүүхдийн тоог өмнөх оныхтой харьцуулахад 25.4 буюу нийт амь насаа алдсан хүүхдийн тоо 74.6% болж буурсан, гэмтэл бэртэл авсан хүүхэд 86 буюу 10.6%, хүнд, хүндэвтэр бэртэл авсан хүүхэд 13 буюу 88.5% ⁹⁵болж өссөн байна.


Нийслэлд 2023 онд бүртгэгдсэн хүүхэд бүртгэгдсэн зам тээврийн осолд өртсөн хүүхдүүдийг хөдөлгөөнд оролцсон хэлбэрээр нь авч үзвэл нийт хүүхдийн 71 буюу 15.5 хувь нь явган ба дугуйтай хүүхдийн буруутай үйлдэл, 50 буюу 10.9 хувь нь эцэг, эх, асран хамгаалагчийн буруутай үйлдлээс гарсан байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 13.2.7 дахь хэсэгт “Эцэг, эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртлэх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх”⁹⁶ гэж заасан байдаг.

Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр бүлгийн 7 дугаар зүйлийн 54 дэх хэсэгт “Эцэг, эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртлэх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргахад хүргэсэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”⁹⁷ гэсэн заалтын дагуу 2023 онд 74 хүнд торгох шийтгэл оногдуулсан байна.

Зам тээврийн осолд өртөж, хохирсон нийт 900 хүүхдийн 569 буюу 63.2 хувь нь явганаар, 244 буюу 27.1 хувь нь тээврийн хэрэгслээр зорчигч, 55 буюу 6.1 хувь нь унадаг дугуйгаар, 31 буюу 3.4 хувь нь бусад /тээврийн хэрэгсэл жолоодсон, гэртээ байсан,

Зураг №1. Осолд өртсөн хэлбэр



Дээрхи зурганд үзүүлсэн хэлбэрээс гадна нийслэлд явган зорчигч, орон нутагт зорчигч хэлбэрээр замын хөдөлгөөнд оролцох үедээ зам тээврийн осолд өртөх нь өндөр үзүүлэлттэй байгаа нь өндөр үзүүлэлттэй байгаа нь Замын хөдөлгөөний дүрэм төдийлөн хэрэгжихгүй байгаа нь харагдаж байна.

⁹⁵ Тээврийн цагдаагийн албаны 2022, 2023 оны статистик тоо мэдээнээс хэсэгчилэн авав.

⁹⁶ Төрийн мэдээлэл. 2015., №28 Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

⁹⁷ Төрийн мэдээлэл. 2017., №24. Зөрчлийн тухай хууль

Улсын хэмжээнд 2023 онд хүүхэд өртсөн зам тээврийн 846 ослын 473 буюу 55.9 хувь нь нийслэлд 373 буюу 44.1 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Үүнээс гадна хүүхдийн амь нас хохорсон осол бүртгэгдсэн сараар гаргасан бүртгэлд зун, намрын улирал буюу 6, 9 саруудад хүүхэд осолд их өртсөн байгаа бол 2022 онд 2023 онд хүүхдийн амь нас хохорсон осол бүртгэгдсэн сараар гаргасан бүртгэлд зун, намар, буюу 6, 9 саруудад хүүхэд осолд өртөж амь насаа алдсан тохиолдол их байгаа нь амралт зугаалгын улирал болон хичээл сургууль эхлэхтэй зэрэгцэж байгаа нь мөн л эцэг, эх, асран хамгаалагчид Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 239 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын замын хөдөлгөөний шинэчлэгдсэн дүрэмд заасан хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалах заалтуудыг дагаж мөрдөхгүй байгаа нь харагдаж байна.

Иймээс бид бүхэн бага насны хүүхдийг зориулалтын суудалд суулгаж тээвэрлэх, хамгаалах бүсийг тогтмол зүүлгэж хэвшүүлэх, 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, хорооллын доторх хөдөлгөөнд зогсож буй тээврийн хэрэгслийн дундуур хүүхэд гэнэт гарч ирэх тул хурдаа тохируулж явах, гэр хорооллын хашаа болон зогсоол талбай дээрээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг эхлүүлэхдээ байнга тойрч шалгаж байхад анхаарах шаардлагатай байна.

Мөн 2 нас хүртэл: Хүүхдийн суудлыг хойш харуулан байрлуулна. Хүүхэд суудлынхаа жин болон өндрийн хязгаарт хүрэх үе эсвэл 2 хүртэлх насны хүүхэд болон нярайг хамгийн тохиромжтой үндсэн байрлал нь хүүхдийн суудлыг буруу харуулан бэхэлж тогтоох юм. Жин болон өндрийн хязгаарыг суудал үйлдвэрлэгчийн гарын авлага болон шошгон дээрээс харах хэрэгтэй.

2-оос 5 нас хүртэл: Хүүхдийн суудлыг урагш харуулан байрлуулна. 2-с дээш насны болон хүүхдийн суудлыг хойш нь харуулан байрлуулахад тухайн хүүхдийн өндөр суудлаас илүү гарсан буюу тухайн үйлдвэрлэгчийн заасан жин, өндрийн хязгаарт хүртэл буюу ойролцоогоор 5 нас хүүхдийн суудлыг урагш харуулан байрлуулна. 5 наснаас дээш суудлын бүс зүүж чадах хүртэл: Өндөрлөгөөтэй суудал хэрэглэнэ.

Хүүхэд суудлын хэмжээнээс томорсон тохиолдолд суудлын даруулгыг зүүж чадах хүртэл нь өндөрлөгөөтэй суудлыг ашиглах шаардлагатай. Бүсний доод хэсэг нь гуяны дээгүүр (Гэдсэн дээгүүр биш) ба босоо бүс нь цээжин дээгүүр (Мөрөн дээгүүр биш) таардаг болсон үед энгийн суудлын бүсийг ашиглаж болно.

Суудлын бүс хэрэглэх нь хүүхдийг хамгаалах хамгийн шилдэг арга юм. Хүүхдийг арын суудлын голд суулгах: Боломжтой бол хүүхдээ арын суудлын голд нь суулгах хэрэгтэй. Яагаад гэвэл энэ нь тээврийн хэрэгслийн хамгийн аюулгүй цэг байдаг учир эдгээр зөвлөмжийг дагаж, мөрдөж хэвшвэл хүүхэд тээврийн хэрэгслийн зорчигч хэлбэрээр зам тээврийн осолд өртөж, хохирох цаашлаад амь нас, эрүүл мэндээрээ хохирох нь багасах юм.

Зам тээврийн осолд өртсөн хүүхдүүд ихэвчлэн гэр, сургууль, цэцэрлэг гэсэн маршрутаар явах үедээ анхаарал болгоомжгүй хөдөлгөөнд оролцох, зам хөндлөн гарахдаа гарц, маршрутаар явж байгаад зам тээврийн осолд өртдөг байна.

Энэ маршрутаар гарамтай хэсгээр гарахгүй байх, асран хамгаалагчгүй хөдөлгөөнд оролцох, ойртон ирж буй тээврийн хэрэгслийн урдуур гүйх зэргээр өөрсдийн замын хөдөлгөөний мэдлэг дутмагаас осолд өртдөг хэдий ч жолоочийн хариуцлагагүй үйлдэл, замын байгууламжаас хамаарч осолд өртөх тохиолдол гарсаар байна. Хүүхэд өртсөн зам тээврийн ослыг 2022 онтой харьцуулахад 2023 онд улсын хэмжээнд зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоо өмнөх оныхоос өссөн үзүүлэлтэй байгаа нь 7-14 насны хүүхдүүд нь замын хөдөлгөөнд бие даан оролцдог, эцэг, эхийн хараа хяналт тодорхой хэмжээгээр

буурдаг, бие даах чадвар нь нэмэгддэг, энэ насны хүүхдүүд хөдөлгөөнтэй, анхаарал сарнимтгай байдаг гэх мэт тухайн насны хүүхдийн онцлогтой холбон үзэж сургалт, сурталчилгаа, мэдлэг, мэдээллийг илүү олгох нь чухал юм.

Улаанбаатар хотод хүүхдүүд замын хөдөлгөөнд явганаар оролцож байхдаа амь нас алдсан нь илүү хувийг эзэлж байна. Улсын хэмжээнд зам тээврийн осолд өртсөн хүүхдийн нас, хүйсийг харьцуулахад осол өртсөн хүүхдийн байдал 2023 онд өмнөх оныхоос өссөн үзүүлэлттэй байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 13.2.7-т “Эцэг эх, асран хамгаалагч, бүх шатны боловсролын байгууллагын холбогдох албан тушаалтан 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх”⁹⁸ гэж зааж өгсөн байдаг.

Дүгнэлт. Хүүхэд өртсөн зам тээврийн осол гарсан цаг хугацаа, гариг, сар улирал нь амралт, зугаалга болон хүүхдийн сургууль хичээлийн цаг хугацаатай давхцаж байгаа ба хүүхдүүд гэр-сургууль-гэр маршрутаар явахдаа өртөх тохиолдол их байна мөн амралт зугаалгын улиралд эцэг, эх, асран хамгаалагчид бага насны хүүхдийг зориулалтын суудалд суулгаж, хамгаалах бүс хэрэглээгүйгээс үүдэн гарч байна.

Хүүхэд зам тээврийн осолд өртөж буй тохиолдол нь эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгчид, жолооч нар хамгийн их буруутай гэж үзэж болно. Мэдээллийн технологи, мэдээлэл зүй, цахим ертөнц эрчимтэй хөгжиж буй энэ нийгэмд эцэг, эх, багш, томчууд бид тэдний мэдээллийн технологи, интернэтийн орчинд ажиллах эсвэл хэлний мэдлэг гэх мэтчилэн бусад мэдлэг боловсролд анхаарал хэт хандуулаад Замын хөдөлгөөнд зөв оролцох, замын хөдөлгөөний мэдлэг боловсролд анхаарал хандуулахгүй орхигдуулж байна. Иймд хүн бүрт замын хөдөлгөөний мэдлэг олгож, тэднийг замын хөдөлгөөнд зөв боловсон оролцох дадлыг нь эзэмшүүлэх нь зүйтэй юм.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Бүх насны хүүхдийг өөрт тохирсон хүүхдийн хамгаалалтын суудалтай явах хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагч нарт таниулан ойлгуулах сургалтыг явуулах

2. Авто машины аюулгүй ажиллагааны стандартад нийцсэн хүүхдийн хамгаалалтын суудлыг ашиглахыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд тусгаж өгөх

3. Хүүхдийн хамгаалалтын суудлыг ашиглахдаа үйлдвэрлэгчийн зааварчилга, ашиглалтын хугацааг чанд мөрдөн ашиглах талаар арга зүйн зааварчилгаа гаргаж, бага насны хүүхэд тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн жолооч нарт тарааж өгөх

4. Хүүхдийн хамгаалалтын суудал болон суудал өндөрлөгчийн аюулгүй ажиллагааны зааварчилга, стандартыг дагаж мөрдөх чиглэлээр видео контент бэлтгэн цахим орчинд түгээх ажлыг зохион байгуулах

Ашигласан материал:

1. Зөрчлийн тухай хууль
2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
3. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Дүрэм шинэчлэх тухай” 239 дүгээр тогтоол Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм

⁹⁸ Төрийн мэдээлэл. 2015., №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

4. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Түр журам батлах тухай” 388 дугаар тогтоол
5. Зам тээврийн ослын өнөөгийн байдал. ҮСХ. Уб., 2022
6. Төрийн мэдээлэл 2017. №24
7. Төрийн мэдээлэл 2019 он
8. Монгол улс дахь замтээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхтгэл 2022
9. Монгол улс дахь замтээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхтгэл 2023

Е-СУРГАЛТ ТҮҮНИЙ МӨН ЧАНАР, ДАВУУ БОЛОН СӨРӨГ ТАЛ
E-LEARNING ITS PERMANENT QUALITY, ADVANTAGES,
AND DISADVANTAGES

Н.Пүрэвдорж

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн

Замын цагдаагийн тэнхимийн багш,

цагдаагийн хошууч

N.Purevdorj

A Lecturer at the Traffic police department
of Police School at the University of Internal
Affairs, Police Major

Хураангуй: Цахим, зайн сургалт нь орчин үеийн сургалтын нэгэн хэлбэр бөгөөд өдгөө XXI зууны иргэд өөр хоорондоо болон дэлхий нийттэй чөлөөтэй харилцаж, нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцоход шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг сургалтын уламжлалт хэлбэрийн зэрэгцээ цахим сургалт (e-Learning), интернэт вэб-д суурилсан сургалтаар эзэмшиж эхлээд байна.

Е-Сургалт гэдэг нь мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан зайн болон цахим сургалтын аль алийг өөртөө багтаасан орчин үеийн сургалтын нэг төрлийн хэлбэр гэж ойлгож болох юм. Е-сургалтын мөн чанар нь оюутны мэдээллийн технологи хэрэглэх чадвар, зорилго, бие даасан цагийн хуваариар суралцаж багштай харилцах боломжтой байх явдал юм. Сурах ба сургах үйл явцад ашиглагддаг цахим агуулга хөгжүүлэлт нь уламжлалт багш төвтэй хандлага гэхээсээ илүү суралцагч төвтэй сургалтад зориулагддаг.

Е-сургалтын хэлбэрийг ашиглан суралцахад орон зай, үл хамааран батлагдсан хуваарийн дагуу дэлхийн аль ч улсаас тухай багшийн лекцийг мэдээлэл харилцаа холбооны төхөөрөмж, интернэт ашиглан шууд үзэх, харилцах боломжтойгоос гадна тухай лекц, семинарын хичээлийн бичлэг хийгдэн хадгалагдсан бол өөрийн боломжтой цагтаа дахин давтан үзэх боломжтой тул мэдлэгээ илүү батлах, ойлгоход амар.

Abstract: Electronic and distance learning is a form of modern learning, and in the 21st century, citizens of the 21st century can freely communicate with each other and with the world, and along with traditional forms of learning, electronic learning (e-Learning), Internet web- have started mastering through training based on.

E-Learning is a type of combined learning that includes distance and electronic learning based on information and communication technology. The essence of e-learning is the student's ability to use information technology, the ability to learn on their schedule and communicate with the teacher. Electronic content development used in the learning and teaching process is designed for learner-centered learning rather than the traditional teacher-centered approach.

In addition to being able to directly watch and communicate with the teacher's lectures from any country in the world using information and communication devices and the Internet, regardless of the space or approved schedule, the lectures and seminars can be watched again and again at your own time if the recordings of the lectures and seminars are saved. so it is easier to confirm and understand your knowledge.

Түлхүүр үг: Е-сургалт, цахим, онлайн, зайн сургалт, холимог сургалтын арга

Keywords: E-learning, electronic, online, distance learning, blended learning methods

Удиртгал: Технологийн ямар нэг дэвшил, хөгжил бүхэн боловсролд тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлж байсан. Анхны радио гарч ирэхэд хүмүүс боловсролыг хүн бүрд хүргэх арга хэрэгсэл болно гэж төсөөлж байсан бол телевизор гарч ирснээр багш дутагдалтай байгаа асуудлыг шийдэх өргөн нэвтрүүлгийн систем болгож ашиглаж болох юм гэсэн санаа гарч байсан. Тэгвэл өнөөдөр технологи маш хурдтай хувьсан өөрчлөгдөж байна.

Дэлхий нийтээр 1990-2010 оны хооронд албан байгууллага, айл бүр, хүн бүр компьютертой болох гэж зүтгэж, тэр дундаа манай улс 2003 оноос эхлэн “Өрх бүр компьютертой” аяныг Монгол Улсын Засгийн газраас өрнүүлж компьютер болон түүний дагалдах хэрэгслийн татварыг тэглэж байсан нь саяхан. Мөн 2000-2010 оны хооронд хүн бүр гар утастай болж, 2010-2020 оны хооронд хүн бүр ухаалаг утас, таблет, ухаалаг цаг зэрэгтэй болсон байна. Дэлхийн хүн амын гуравны нэг нь буюу 2.5 тэрбум хүн интернэтэд холбогдсон байдаг бөгөөд харин манай улсын хүн ам цөөн ч өнөөдрийн байдлаар гар утас хэрэглэгчийн тоо 4.3 саяд хүрчээ. Үүний 3.4 сая ухаалаг гар утас хэрэглэгч байгаагаас 64 хувь нь 4G өндөр хурдны интернэт хэрэглэдэг байна.

Нийт ухаалаг гар утас хэрэглэгчдийн 93 орчим хувь нь санхүүгийн байгууллагад данстай бөгөөд 22 орчим хувь нь уг дансаа гар утсаараа дамжуулан удирддаг байна. Ухаалаг гар утас хэрэглэгчдийн дийлэнх хувь буюу 2.5 сая хэрэглэгч нийгмийн сүлжээнд /facebook, twitter, Instagram, tiktok г.м/ идэвхтэй оролцдог. Мөн манай улсад нийт 96 их, дээд сургуульд 160 орчим мянган оюутан суралцаж байгаагийн 2.3 хувь нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын чиглэлээр сонгон суралцдаг аж.⁹⁹

Сэдвийн судлагдсан байдал: Хэдхэн жилийн өмнө зайн сургалт, цахим сургалт, мобайл сургалт гэж ярьж байсан бол өнөөдөр дижитал суралцахуй, нээлттэй боловсрол, нийтэд зориулсан нээлттэй онлайн хичээлүүд буюу MOOCs (Massive Open Online Courses) зэргийг чанартай боловсролыг хямд зардлаар хүссэн хүн бүрд хүртээмжтэйгээр хүргэх арга хэрэгсэл гэж үзэх болсон.

Манай улсын хувьд зайн сургалтыг 2000 оны эхэн үеэс хөгжүүлж эхэлсэн байдаг. Төр засгийн түвшинд хэд хэдэн хөтөлбөр гаргаж хэрэгжүүлсэн байдаг. Үүнд:

- 2002 оноос “Зайн сургалтын үндэсний хөтөлбөр”,
- 2005-2012 оны хооронд хэрэгжүүлсэн “Цахим Монгол үндэсний хөтөлбөр”,
- 2012-2016 оны хооронд “Нэг Монгол санаачилга”

Энэ мэтээр тодорхой ажлууд хийгдэж байсан боловч яг орчин үеийн түвшинд суралцагчдын эрэлт хэрэгцээг хангахуйц хууль эрх зүйн орчныг ч, хэрэгжүүлэх системийг ч цогцоор нь бий болгож хараахан чадаагүй байна. Жишээлбэл, зайн болон цахим сургалтаар сургалтыг зохион байгуулж буй иж бүрэн платформыг бий болгож чадаагүй, мөн зайн сургалтаар судалж мэдсэн зүйлийг баталгаажуулах, кредит тооцох гэх мэт асуудлууд шийдэгдээгүй байна.

Тухайлбал 2007 оноос ШУТИС-ийн сургалтад хэрэгжүүлэх е-Сургалтын хөтөлбөр батлуулж, Монголд анх удаа электрон сургалтын удирдлагын систем болох UNILMS системийг боловсруулж, бакалавр, магистрын е-Сургалтад ашиглаж эхлүүлсэн. е-

⁹⁹ <https://www.1212.mn>. // Татаж үзсэн: 18.11.2024. Статистик мэдээллийг нэгдсэн сан

Сургалтын LMS систем нь 2008 оны БСШУЯ-ны шилдэг программ хангамжийн бүтээл шагналаар шалгарсан.¹⁰⁰

Судалгааны ажлын объект, судлах зүйл. Уг судалгааны ажлын объект нь Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн 2, 3-р дамжааны 118 оюутнуудад болон багшлах эрхийн сургалтад хамрагдаж байгаа 26 багш нараас Е-сургалтын талаарх ойлголтын судалгааг авч хэрэгжүүлэхэд тулгамдаж буй хүчин зүйл, өнөөгийн байдалд хийсэн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн зэрэг болно.

Судалгааны ажлын зорилго. Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн бакалаврын түвшний зарим сургалтын хөтөлбөрт Е-сургалтын хэлбэрийг хэрхэн нэвтрүүлэх арга замыг танин мэдэхүйн судалгааны үндсэн дээр дэвшүүлэн гаргаж үнэлэлт, дүгнэлт өгөх нь судалгааны ажлын үндсэн зорилго юм.

Судалгааны арга зүйн. Цахим агуулга хөгжүүлэлтийн дидактик боловсруулалт, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, ажиглах, харьцуулах зэрэг ерөнхий аргуудаас гадна социологийн тоон судалгааны арга, чанарын судалгааны арга, баримт бичигт дүн шинжилгээ хийх зэрэг аргуудыг ашиглаж дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Хосолсон сургалтын зарчим, онцлог, төрөл, арга хэлбэр, хэрэглэгдэхүүний талаарх судлаачдын үзэл баримтлал, олон улсад хэрэгжиж байгаа хөтөлбөр, туршилт сургалтуудын үр дүнг түүвэрлэн тойм шинжилгээ хийх.

- Е-сургалтын платформуудыг судлан их сургуулийн хэмжээнд тохиромжтойг сонгон судалгаа хийх.

- Танхимын болон цахим сургалтын хэлбэрийн харьцуулалт хийх.

Судалгааны ажлын онолын ба практикийн ач холбогдол. Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн 2, 3-р дамжааны оюутнуудад болон Цагдаагийн сургуулийн багш нараас авсан судалгаанд дүн шинжилгээ хийж Е-сургалт түүний мөн чанар, боломж, түүний давуу ба сөрөг талыг гарган цаашид сургалтын хөтөлбөрт хэрхэн нэвтрүүлэх талаар шинжлэх ухааны үндэслэлтэйгээр санал дүгнэлт дэвшүүлсэнд уг судалгааны ажлын онол, практик ач холбогдол оршино.

Е-Сургалтын тухай ойлголт, онцлог, мөн чанар

Е-сургалтын тухай ойлголт: Цахим, зайн сургалт нь орчин үеийн сургалтын нэгэн хэлбэр бөгөөд өдгөө XXI зууны иргэд өөр хоорондоо болон дэлхий нийттэй чөлөөтэй харилцаж, нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцоход шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг сургалтын уламжлалт хэлбэрийн зэрэгцээ цахим сургалт (e-Learning), интернэт вэб-д суурилсан сургалтаар эзэмшиж эхлээд байна.

Сургалт гэдэг нь боловсролын тодорхой зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн багш сурагч 2-ын хамтын бүтээлч үйл ажиллагаанаас бүрдэх, хоёуланд нь чанарын өөрчлөлт гаргах зорилготой түүний зорилго, агуулга нь суралцагчийн хэрэгцээ нийгмийн шаардлагаар тодорхойлогдож, тэдгээрийг хэрэгжүүлэх чиг хандлага, арга технологийг багш тодорхойлж чиглүүлэн жолоодох үйл явц юм.

Цахим сургалт гэдэг нь мэдээлэл харилцаа холбооны технологид суурилсан сургалт гэж тодорхойлж болох бөгөөд компьютерт суурилсан, веб-д суурилсан, виртуал, телевиз, радиогийн зэрэг агуулгыг өөртөө багтаасан байдаг.


Цахим сургалтын материалыг боловсруулах нь танхимын сургалтын материал боловсруулахаас үнэтэй, цаг хугацаа, хүн хүч, хөдөлмөр их шаарддаг ба харин

¹⁰⁰ <https://www.wikipedia.org/> /Чөлөөт нэвтэрхий толь/ Татаж үзсэн: 08.09.2024

боловсруулсны дараа цахим сургалтыг явуулах нь ангид сургалтыг явуулахаас илүү агуулгын хувьд чанартай бэлтгэгдсэн байдаг.

Зайн сургалт гэдэг нь харилцаа холбоо, интернэт ашиглан суралцагчтай орон зай, цаг хугацааг үл хамааран зайнаас холбогдох боломж олгодог бөгөөд ингэхдээ интернэтэд суурилсан платформ, программ хангамжийг ашиглан шууд сургалт явуулах аргыг хэлнэ.

Е-Сургалт гэдэг нь мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан зайн болон цахим сургалтын аль алийг өөртөө багтаасан орчин үеийн сургалтын нэг төрлийн хэлбэр гэж ойлгож болох юм. “Е-сургалтыг интернэтийг ашиглан сургалтын материалд хандах, хичээлийн агуулга, багш болон бусад оюутнуудтай харилцах, сургалтад оролцох, мэдлэг эзэмших, өөрийгөө хөгжүүлэх ба суралцах туршлага эзэмших явдал юм” гэж тодорхойлжээ.



Манай улсын багш, судлаачид Е-сургалтын аргыг тодорхойлохдоо ихэвчлэн онлайн сургалт гэсэн нэр томъёог ашигласан байдаг нь олон улсын нэршил болох E-Learning /Е-сургалт/ гэсэн зөрүүтэй ойлголт үүсдэгээс зарим багш нарын хувьд Е-сургалтыг цахим сургалт, зайн сургалтын хэлбэртэй андуурах тохиолдлууд байдаг.

Үүний нэг жишээ нь Алимаа.Ж. “Онлайн сургалтын агуулга хөгжүүлэх арга зүйн судалгаа нэг сэдэвт бүтээл”-д “Онлайн сургалтыг хэрэгжүүлэх нь танхимын сургалтад хэрэглэгдэж байгаа хичээлийн агуулгыг цахим болон интерактив хэлбэрт шилжүүлж сургалт удирдлагын системд байрлуулснаар шийдэгдэх асуудал биш сургах болон суралцах цогц үйл ажиллагаа болгон хөгжүүлж загварчлах асуудалд хүргэж байна.”¹⁰¹ гэж тодорхойлсон нь үнэндээ Е-Сургалтын хэлбэрийг тодорхойлсон байдаг.

Е-сургалтын хичээлийг асинхрон (ялгаатай цаг), синхрон (тодорхой цагт) танхимд уулзахгүйгээр явуулж болно гэж Фарахани (2003) дүгнэсэн бол Бадрул Хан онлайн сургалтыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх, үнэлэхэд нөлөөлөх гол хүчин зүйлүүдийг тодорхойлон нээлттэй, уян хатан, бүх нийтийг хамарсан “е-Сургалтын загвар” орчныг дэвшүүлжээ.

Е-сургалтын мөн чанар нь оюутны мэдээллийн технологи хэрэглэх чадвар, зорилго, бие даасан цагийн хуваариар суралцаж багштай харилцах боломжтой байх явдал юм. Сурах ба сургах үйл явцад ашиглагддаг цахим агуулга хөгжүүлэлт нь уламжлалт багш төвтэй хандлага гэхээсээ илүү суралцагч төвтэй сургалтад зориулагддаг. Иймд сургалтыг үр ашигтай явуулахад туслах мультимедиа болон программ, тоног төхөөрөмж хэрэглэх шаардлага үүсдэг.¹⁰²

Уламжлалт танхимын сургалт болон Е-сургалтыг харьцуулан судалсан олон улсын судалгаа цөөнгүй байдаг. Жишээ нь, Charlotte Neuhauser, 2002 оны судалгааг харвал оюутнуудын тестийн оноо, гэрийн даалгавар, хичээлийн дүн нь танхимын сургалт болон цахим сургалт хоёрын хооронд ялгаагүй байсан бөгөөд нийт онлайн сургалтад хамрагдсан оюутны 96 хувь нь цахим сургалтыг танхимын сургалтаас илүү үр дүнтэй гэж үзсэн байдаг.

Колумбын их сургуулийн судалгааны үр дүнгээс (Shanna Smith Jaggars, 2014) оюутнуудын дийлэнх хэсэг нь энгийн амархан хичээлүүдийг онлайн хэлбэрээр үзэх

¹⁰¹ Алимаа Ж. Онлайн сургалтын агуулга хөгжүүлэх арга зүйн судалгаа. –Уб., 2013. 35 дахь тал

¹⁰² Ганбат.Ц. Сурах ба сургах үйл явцад ашиглагдах цахим контент хөгжүүлэх ара зүй ба хэрэгслүүд. -Уб., 2012. 15 дахь тал

сонирхолтой байдаг бөгөөд мэргэжлийн хэцүү хичээлүүдийг танхимын сургалтаар үзэх нь илүү дээр гэж үзсэн байдаг.

Тиймээс манай тохиолдолд их сургуулийн ерөнхий эрдмийн болон сонгон суралцдаг хичээлүүдийг цахим, зайн хэлбэрт шилжүүлэх нь илүү үр дүнтэй арга байж болох юм.

Танхимын болон Е-сургалтын хэлбэрийн харьцуулалт: Танхим болон цахим хосолсон /Е-сургалт/ сургалтын хэлбэрүүд хоорондоо төсөөтэй хэдий ч сургалтын үйл ажиллагааны загвар, зохион байгуулалт, аргачлал зэрэгт ялгаатай талууд нэлээд байдаг.

Тухайлбал, нэг талаас оюутнуудын сурахуй буюу хичээлд оролцох, хичээлийн агуулгыг судлах, даалгавар гүйцэтгэх, багаараа ажиллах гэх мэт үйлдлүүд нөгөө талаас багшийн хөтөлбөр боловсруулах, төлөвлөх, оюутнуудыг сэдэлжүүлэх, дасгал ажиллуулах, даалгавар өгөх, шалгах, үнэлж дүгнэх зэрэг сургахуйн үйл ажиллагаануудыг нэрлэж болно.

Сүүлийн үед боловсрол судлаачдын нэлээд анхаарлын төвд байгаа сэдэв бол идэвхтэй буюу суралцагч төвтэй сургалтын арга технологи юм. Уламжлалт буюу танхимын сургалтын явцад хичээлийг төлөвлөх, лекц унших, тайлбарлах, зохион байгуулах, шалгах, үнэлэх зэргээр бүхий л үйл ажиллагааг багш удирддаг учир хичээлийн үеэр оюутнууд сонсох, тэмдэглэл хөтлөх, асуултад хариулах, шалгуулах, дүгнүүлэх зэргээр идэвхгүй үйлдлүүдийг голлон гүйцэтгэдэг.

Харин онлайн буюу Е-сургалтын явцад оюутан нэмэлт мэдээллийн эрэл хайгуул хийх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, сурах үйл явцаа төлөвлөх, өөрийн үнэлгээ хийх, эргэлзээтэй асуудлыг нягтлан судлах, асуулт бэлтгэх, багшаас зөвхөн тодруулга авах замаар хичээлд оролцдог. (Salcedo, 2010)

Уламжлалт болон цахим сургалтын хэлбэрийг харьцуулсан сүүлийн үеийн судалгаанд танхимын сургалт нь багш төвтэй учир оюутнаас суралцахуйн идэвхгүй үйлийг шаарддаг харин цахим сургалт нь суралцахуйн идэвхтэй үйлд суралцагчийг чиглүүлдэг гэж үзэх хандлага нэлээд ажиглагддаг. Тиймээс танхим болон цахим сургалтын давуу талуудыг хослуулан боловсруулсан сургалтын холимог-blended, хосолмол-hybrid, тонгоруу-flipped гэсэн хэлбэрүүд өнөөдөр хүчтэй хөгжиж үндэсний болон олон улсын түвшинд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд цөөнгүй байна.

Бид танхим болон цахим хосолсон сургалтын хэлбэрүүдийн талаар хийсэн судалгааны ажлуудаас өөрсдийн цуглуулсан мэдээлэлд үндэслэн хосолсон сургалтын зарим талуудыг харьцуулж үзлээ.¹⁰³ /Хүснэгт 1/

Хүснэгт 1. Сургалтын хэлбэрүүдийн харьцуулалт

Сургалтын зарим үйл ажиллагаа	Танхимын сургалт	Танхим болон цахим хосолсон сургалтын хэлбэр			Е- Сургалт
		Тонгоруу (Flipped)	Холимог (Blended)	Хосолмол (Hybrid)	
Заавар, зөвлөгөө	Танхим	Танхимд		Танхимд болон цахимаар	Цахимаар
Сургалтын орчин	Танхим	Танхим, цахим хослуулан	Танхим-75% Цахим-25%	Танхим -50% Цахим-50%	Цахим-100%
Үнэлгээ	Танхимд	Танхимд	Танхим болон цахим хослуулан		Цахим
Оюутны оролцох хэлбэр	Оюутан хуваарийн дагуу танхимд явагддаг лекц, семинар,	Оюутан лекц, семинарын материалыг цахим буюу дижитал	Оюутан лекц, хэлэлцүүлэг, лаборатори ажил зэрэг биечлэн	Оюутан хичээлийн хөтөлбөрийн агуулгын 50%-ийг цахим	Оюутан хичээлийн хөтөлбөрийн агуулгыг 100% бие даан

¹⁰³ Төгсөө.Ж, Оюун-Эрдэнэ.Т, Сайнзаяа.С. Хосолсон сургалтын онол, арга зүй зарим асуудал. –Уб., 2020. 6 дахь тал.

	хэлэлцүүлэг, багийн ажил, дасгал ажил, сорил шалгалт, үнэлгээ зэрэг сургалтын үйл ажиллагаанд багшийн удирдлага дор оролцоно	хэлбэрээр хүлээн авч бие даан урьдчилж судлах ба танхимын сургалтад дадлага хийх хэлэлцүүлэг өрнүүлэх хэлбэрээр оролцоно	оролцох шаардлагатай даалгавруудыг танхимд гүйцэтгэх боловч ихэнх дасгал даалгаврыг заасан хугацаанд багтаж цахимаар хийж илгээн сургалтад оролцоно	хэлбэрээр үлдсэн 50%-ийг танхимаар судална. Оюутан цахим хичээлд орон зай, цаг хугацаанаас хамааралгүйгээр оролцоно.	судлах бас сургалтын үйл ажиллагаанд орон зай, цаг хугацаанаас хамаарахгүй байдлаар оролцоно.
Давуу тал	- Нийгэмших амьд харилцаа. - Биет бодит хэрэглэгдэхүүн - Уян хатан үнэлгээ - Хамтран суралцах орчин	- Бие даан суралцах чадвар - Мэдлэгээ гүнзгийрүүлэх боломж - Мэдлэгээ хуваалцах боломж, чадвар - Хам цагийн шууд харилцаа	-Цаг хугацаа, орон зайн уян хатан тодорхой нөхцөл -Бие даан суралцах чадвар -Мэдлэгээ гүнзгийрүүлэх боломж - Мэдлэгээ хуваалцах боломж, чадвар -Цагийн шууд харилцаа -Бүтээлч байдал -Эдийн засгийн хэмнэлт	- Цаг хугацаа, орон зайн уян хатан нөхцөл -Бие даан суралцах чадвар -Бүтээлчээр суралцах боломж -Мэдлэгээ хуваалцах чадвар -Хам цагийн шууд харилцаа - Хариуцлагатай байдал - Эдийн засгийн хэмнэлт - Байгальд ээлтэй суралцахуй	- Орон зай, цаг хугацааны чөлөөт сонголт - Бие даасан бүтээлч байдал - Эдийн засгийн хэмнэлт - Байгальд ээлтэй суралцахуй

Сургалтын хэлбэрийг харьцуулсан хүснэгтээс харахад танхим болон цахим хосолсон хэлбэр нь бусад сургалтын төрлүүдийг бодвол өнөө цаг үед тохирсон давуу тал ихтэй байна. Үүнд цаг хугацаа, орон зайн уян хатан тодорхой нөхцөл, бие даан суралцах чадвар, мэдлэгээ гүнзгийрүүлэх боломж, мэдлэгээ хуваалцах боломж, чадвар, цагийн шууд харилцаа, бүтээлч байдал, эдийн засгийн хэмнэлт зэргийг дурдаж болно.

Midwestern их сургуулийн инженерийн коллежийн тэнхимийн багш нар энэхүү сургалтыг явуулахдаа дараах гурван саад бэрхшээлтэй тулгарсан байна (Ilg, 2015). Үүнд:

1. Цаг хугацаа их шаардагддаг,
2. багш, оюутны харилцаа хөндийрдөг,
3. техникийн асуудал.

Үүнийг дэлгэрүүлэн тайлбарлавал, тохирсон агуулга бэлтгэн, хөгжүүлэхэд жил гаруй хугацаа зарцуулсан нь эхний бэрхшээл байв. Мөн түүнчлэн танхимд явуулах нарийн төвөгтэй дасгалуудыг боловсруулах нь судлаачдын хувьд цаг хугацаа шаардсан өөр нэг ажил байв.

Сонирхолтой, бодит дасгалуудыг бий болгох нь зөвхөн сурах бичгээс жишээ авахаас огт өөр зүйл байсан тул багш, ажилчдаас багагүй хүчин чармайлт шаардсаныг онцолсон

байна. Хоёрдох бэрхшээл нь оюутнуудтай холбоо тогтоохгүй байх явдал байв. Энэ нь энэхүү сургалтын уян хатан байдлын нөгөө тал гэж үзэж болох юм. Оюутнуудад хэт их ачаалал үүсгэхгүйн тулд онлайн дасгал даалгаварт зарцуулах цаг хугацаанаас хамаарч оюутнуудтай харилцах цагийг бууруулсан нь эмх цэгц, зохион байгуулалттай сургалтын арга барилыг илүүд үздэг зарим оюутнуудад энэ нь сул тал байж болох талтай. Мөн гурав дахь бэрхшээл нь, шинэ сургалтын дизайн, онлайн агуулгыг хөгжүүлэх, видео лекц засах, асуулт хариултын тест хийх зэрэг сургалтын бэлтгэл ажилд техник технологийн өндөр мэдлэгтэй баг хамт олон шаардлагатай болж байсан гэжээ.

Е-сургалтын хэлбэрийг өнөөгийн байдал, түүнд хийсэн хэрэглэгчийн судалгаа: Манай оюутан залуусын хувьд орчин үеийн мэдээлэл харилцаа холбооны технологийн боломжийг өөрийгөө хөгжүүлэхдээ болон суралцахдаа хэр үр дүнтэй ашиглаж байгаа талаар тодорхой судалгаа байхгүй. Ихэвчлэн Facebook, Instagram, Twitter, TikTok, Podcast сонсоход ашиглаж буюу цагийг зугаатай өнгөрөөх чиглэлд илүү цаг гаргаж ашиглаж байна. Залуу үеийн өндөр технологийг үр бүтээлтэй ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих, бие даан суралцах боломж болгож ашиглах боломжтой талаар Цагдаагийн сургуулийн сонсогч, багш нараас дараах судалгааг авсан.

Судалгаа нь Дотоод хэргийн их сургуулийн багш, сонсогчид Е-Сургалтын хэлбэрийг хэрэгжүүлэхэд хувь хүн болон техникийн хэрэгслийн ашиглалт, мэдлэгийн түвшин тогтоох зорилгоор дараах 20 асуултаар авч SPSS программ ашиглан дүн шинжилгээ хийсэн.

Багш нараас авсан судалгаа: Судалгаанд багшлах эрхийн сургалтад хамрагдсан болон Цагдаагийн сургуулийн нийт 26 багш хамрагдсанаас тэнхимийн эрхлэгч 2, дэд профессор 1, ахлах багш 6, багш 17 байна. Мөн ажилласан жилээр 1-3 жил ажилласан багш 20, 4-6 жил ажилласан багш 2, 11-15 жил ажилласан багш 3, 16-20 жил ажилласан багш 1 тус тус байна.

Судалгаанд хамрагдсан багш нар бүгд ухаалаг утас ашигладаг бөгөөд “Та интернэтэд ихэвчлэн ямар төрлийн төхөөрөмжөөр холбогддог вэ?” гэсэн асуулгад 73.1 хувь нь ухаалаг утас, 15.4 хувь нь зөөврийн компьютер, 11.5 хувь нь суурин компьютер гэж хариулсан байна. Мөн багш нараас интернэт хэрэглээний чиглэлээр “Та өдөрт хэдэн цаг интернэт хэрэглэдэг вэ?” гэсэн асуултад 0-1 цаг 26.9 хувь, 1-3 цаг 30.8 хувь, 3-5 цаг 15.4 хувь, 5-аас дээш цаг 26.9 хувь тус тус хэрэглэдэг гэж хариулсан нь манай багш нарын интернэт хэрэглээ өндөр байгааг харуулж байна. /График 1/

График 1. Та өдөрт хэдэн цаг интернэт хэрэглэдэг вэ?




График 2. Та ямар төрлийн цахим сургалтад хамрагдаж байсан бэ?



Судалгаанд хамрагдсан багш нарын 84.6 хувь нь өмнө нь Е-сургалт /цахим сургалт/-д хамрагдсанаас zoom, teams, google meeting ашигласан 46 хувь, сургалтын цахим портал сайт ашигласан 18 хувь, гар утасны сургалтын аппликейшн ашигласан 9 хувь, ТВ видео контент ашигласан 1 хувь байгаа нь багш нар тодорхой хэмжээнд цахим сургалтад хамрагдаж, ашиглаж үзсэн нь харагдаж байна. /График 2/

“Та өөрөө Е-сургалт /цахим сургалт/ зохион байгуулж байсан уу?” гэсэн асуулгад багш нарын 46.2 хувь нь тийм гэж хариулсан бөгөөд шинээр томилогдсон багш нараас бусад олон жил ажилласан багш нар ямар нэг байдлаар цахим сургалтыг Zoom, MsTeams, Google meeting ашиглан зохион байгуулсан туршлагатай байна.

Багш нараас сургалтыг ямар хэлбэрийг ашиглах сонирхолтой талаар судалгаа авахад холимог /Лекц онлайн, Семинар танхим, Дадлага ажил лаборатори/ сонголтыг 57.7 хувь, Танхим /Лекц танхим, Семинар танхим, Дадлага ажил лаборатори/ 38.5 хувь нь санал өгснийг харахад тухай хичээл агуулгаас хамаарч холимог сургалтын аргыг ашиглах боломжтой гэж харагдаж байна.

“Та зааж буй хичээлээ цахим /видео контент/ хэлбэрт оруулахад хүндрэл гарна гэж үзэж байна уу?” гэсэн асуулгад 46.2 хувь нь “өөрийнхөө боломжоор цахим хэлбэрт шилжүүлэхийг хичээнэ”, 26.9 хувь нь “өмнө оруулж байсан туршлага байгаа болохоор чадна гэж үзэж байна” гэж хариулсан нь багш нар цахим сургалт, контент бэлдэхэд өөрийнхөө нөөц бололцоог ашиглан боловсруулах боломжтой гэж үзэж байна. /График 3/

График 3. Та зааж буй хичээлээ цахим /видео контент/ хэлбэрт оруулахад хүндрэл гарна гэж үзэж байна уу?



Судалгаанаас харахад багш нар өөрийн зааж буй хичээлээ цахим хэлбэрт шилжүүлэхэд мэдлэг, чадвар, программ хангамжийн ашиглалтаас үүдсэн асуудал тулгардаг байна. Иймд цахим хэлбэрт шилжүүлэх сонирхол байгаа ч өөр хэн нэгнийг гуйж ажиллах гэдэг нь хүндрэлтэй байна.

Е-сургалтын давуу болон сул талыг тодорхойлох зорилгоор багш нараас 1-5 /муу-маш сайн/ оноо өгөх байдлаар түүвэрчилсэн судалгааг авлаа. Хүснэгт 2.


Асуулга	Оноо				
	1	2	3	4	5
1.Танхимын сургалт нь багштай нээлттэй байж, ойлгоогүй зүйлээ асууж тодруулах, амьд харилцаа үүсгэх	0	1	3	3	18

боломжтой.					
2.Танхимын сургалт нь анхаарал сарнихгүй төвлөрч чаддаг, хичээлийг сайн ойлгодог, бүтээмж өндөртэй.	1	0	5	8	11
3.Танхимын сургалт нь бусдаас суралцах, харилцан мэдлэг туршлагаа хуваалцаж, багаар ажиллах боломжтой.	0	0	2	8	15
4.Танхимын сургалт нь номын санд суух, хэрэгцээтэй ном сурах бичгээ хүссэн үедээ авч хэрэглэх боломжтой.	0	0	4	12	9
5. Цахим сургалт нь цаг хугацаа хэмнэдэг (замын түгжрэлд цаг хугацаа алдахгүй)	0	1	4	9	11
6. Цахим сургалт нь хаанаас ч, өөрийн цаг зав, хурдад тааруулж суралцах боломжтой.	0	1	4	9	11
7. Цахим сургалт нь бие даан суралцах чадвар нэмэгддэг (өөртэйгөө ажиллах)	0	2	7	9	7
8. Цахим сургалт нь хичээл их ойлгомжтой, давтаж үзэх боломжтой учир хоцрогдол үүсдэггүй	0	1	10	6	8
9. Цахим сургалт нь гэртээ тав тухтай, чимээгүй, чөлөөтэй орчинд хичээллэх боломжтой	0	3	7	6	9
10. Цахим сургалт нь цагаа зохицуулж, өөрийгөө илүү хөгжүүлэх цаг завтай болдог	0	3	7	7	8
11. Цахим сургалт нь эдийн засагт хэмнэлттэй: унааны мөнгө, хоолны мөнгө гэх мэт	1	0	5	6	13
12. Цахим сургалт нь компьютер мэдээллийн технологитой ажиллаж сурна	0	0	5	5	15
13. Цахим сургалт нь байгальд ээлтэй, эрүүл мэндэд эрсдэлгүй	1	0	9	4	11

Сонсогчдоос авсан судалгаа: Судалгаанд Цагдаагийн сургуулийн “Цагдаагийн ажил-эрх зүй” хөтөлбөрийн бакалаврын 2, 3-р дамжааны 118 сонсогч хамрагдсан бөгөөд нийт хамрагдсан сонсогчдын 72.9 хувь нь орон нутаг, 27.1 хувь нь Улаанбаатар хотоос элсэн суралцаж байгаа ба судалгаанд хамрагдсан сонсогчдын 96.6 хувь нь ухаалаг утастай бөгөөд үүнийгээ ашиглан интернэтэд ордог бол энгийн утас ашиглаж байгаа сонсогчдын хувьд зөөврийн компьютероор холбогддог гэж мэдүүлсэн.

Сонсогчдоос интернэтийн хэрэглээний талаар “Та өдөрт хэдэн цаг интернэт хэрэглэдэг вэ?” гэсэн асуулгад 41.5 хувь нь 1-3 цаг тогтмол интернэт хэрэглэдэг гэж санал өгсөн нь интернэтэд тогтмол хэрэглэдэг гэсэн байна. /График 4/


График 4. Та өдөрт хэдэн цаг интернэт хэрэглэдэг вэ?



Судалгаанд хамрагдсан сонсогчдын дийлэнх нь “Ковид 19” цар тахлын үед төгсөх ангийн сурагчид байсан тул цахим сургалтад их, бага хэмжээгээр хамрагдсан бөгөөд цахим

сургалтын ямар төрлөөр хамрагдсан талаар санал асуулга авахад 73.3 хувь нь Zoom, MsTeams, Google meeting ашиглаж байсан туршлагатай байна. /График 5/


*График 5. Хэрэв **тийм** бол ямар төрлийн цахим сургалтад хамрагдаж байсан бэ?*



Суралцагчдаас сургалтын ямар төрлийн хэлбэрээр суралцах сонирхолтой талаар, цаашид сургалтын ямар аргыг ашиглавал илүү үр дүнтэй гэж үзэж байгаа талаар асуулгад 56.8 хувь нь холимог /лекц онлайн, семинар танхим, дадлага ажил лаборатори/ суралцахыг дэмжсэн байна.

Мөн зарим хичээлээ Е-сургалт /цахим сургалт/-ын хэлбэрээр хүлээн авахад хүндрэл, бэрхшээл байгаа эсэхэд 67.8 хувь нь хүлээн авч үзэх бүрэн боломжтой гэж хариулсан нь суралцагчид цахим хэлбэрээ Е-сургалтыг хүлээн авах сонирхолтой байна. Мөн суралцагчдад давуу байдал үүсгэх зорилгоор интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас үнэгүй багцад оруулах боломжтой талаар Юнител ХХК-ийн менежер хэлсэн. /График 6/.

График 6. Танд зарим хичээлээ Е-сургалт /цахим сургалт/-ын хэлбэрээр хүлээн авахад хүндрэл, бэрхшээл гарах уу?



Судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан сонсогч, суралцагчдын дийлэнх нь цахим сургалтыг хүлээн авах боломжтой гэсэн бөгөөд тодорхой хэсэг нь интернэт, дата хэрэглээг шийдвэрлэж өгвөл бүрэн боломжтой гэсэн хариултыг өгсөн байна.

Е-сургалтын давуу болон сул талыг тодорхойлох зорилгоор сонсогчдоос судалгаа авлаа. /Хүснэгт 3/

Асуулга	Оноо				
	1	2	3	4	5
1. Би өөрийн сурах үйл явцыг бүрэн удирдаж чаддаг.	3	1	34	46	34
2. Е-Сургалтаар хичээлийн материалуудаа авснаар дахин дахин үзэх боломжийг олгодог.	4	2	21	33	58
3. Е-сургалтын дасгал, даалгаврууд тухайн хичээлийг ойлгоход дэмжлэг болж чаддаг.	3	6	25	42	42
4. Е-сургалтад цаг хугацааг үр дүнтэй зарцуулахад надад хүндрэлгүй байдаг.	3	4	24	42	45
5. Е-сургалт нь орон зай, цаг хугацаанаас хамааралгүй суралцах боломж олгодог.	3	3	20	31	61
6. Е-сургалтад хамрагдсанаар бусад сонсогч нартай санаа бодлоо хуваалцахад хүндрэлтэй байдаг.	10	13	40	30	25
7. Е-сургалтад хамрагдсанаар зарим ойлгохгүй байгаа зүйлээ багшаас асуухад хүндрэлтэй байдаг.	7	9	44	32	26
8. Е-сургалтаар авсан мэдлэг, танхимын сургалтаар авсан мэдлэгтэй ялгаагүй үр өгөөжтэй байдаг.	6	3	38	33	38
9. Цаашид би танхим болон онлайн хосолсон хөтөлбөрөөр дуртайяа суралцахад бэлэн.	7	1	28	32	50
10. Танхим болон онлайн хосолсон сургалт сонсогчийн суралцах чадварыг улам хөгжүүлж чадна.	6	3	30	32	47

Судалгаанд хамрагдсан багш, сонсогчдыг асуулгын дүнгээс харахад тэд нэг зорилгоор Е-сургалтын хэлбэрийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд цаашид багш, сонсогчдын хувьд илүү үр дүнтэй сургалтыг зохион байгуулахад Е-сургалтын орчныг илүү сайжруулах, мөн холимог сургалтын аргыг ашиглан суралцах нь илүү дээр гэж үзсэн байна.

Е-сургалтын хэлбэрийн давуу тал: Е-сургалтын хэлбэрийг ашиглан суралцахад орон зай, үл хамааран батлагдсан хуваарийн дагуу дэлхийн аль ч улсаас тухай багшийн лекцийг мэдээлэл харилцаа холбооны төхөөрөмж, интернэт ашиглан шууд үзэх, харилцах боломжтойгоос гадна тухай лекц, семинарын хичээлийн бичлэг хийгдэн хадгалагдсан бол өөрийн боломжтой цагтаа дахин давтан үзэх боломжтой тул мэдлэгээ илүү батлах, ойлгоход амар.

Мөн гар утас, таблет, зөөврийн болон суурин компьютер, ухаалаг телевизор зэрэг интернэтэд холбогдох боломжтой техник хэрэгсэл ашиглан сургалтад хамрагдах боломжтойгоос гадна эдгээр төхөөрөмж дээр суурилагдсан программ хангамж, цахим портал /веб/ хуудас, олон төрлийн аппликешн, платформуудыг зөв ашиглаж сурах, интернэтээс мэдээлэл хайх, олох, сонголт, дүн шинжилгээ хийх, хэрэглээний программ хангамжийг ашиглах дадалд суралцдаг.

Суралцагч өөрийн сонгосон хичээлийн хүрээнд өөрийгөө хөгжүүлэх, сэдвийн хүрэн дэх өргөн хэмжээний мэдээллээс өөрт чухлыг нь сонгож, цагаа оновчтой зөв төлөвлөж зарцуулахад суралцаж, сурах арга барилыг удирдана.

Танхимын сургалтыг бодвол Е-сургалт нь суралцагчийн эдийн засаг, санхүүгийн хувьд хэмнэлт авчрах бөгөөд үүнд унаа, хоол, байрлах байр болон бусад суралцагчаас гарах нэмэлт зардлыг тооцож болно.

Эцэст нь дүгнэхэд, Е-сургалтын онцлог нь суралцагч сурах зорилгоо ухамсарласан, суралцах хүсэл, хувийн хариуцлагатай байхыг онцгойлон шаарддаг ба хэрэв сурах зорилгыг эрхэм болгож чадваас дэлхийн боловсролыг эх орондоо эзэмших боломжтой юм.

Цаашид Е-сургалтын хэлбэр нь виртуал, хиймэл оюун ухаанд суурилагдан хөгжих тул дурдагдаагүй давуу талууд, шинэ боломжууд өдөр бүр нээгдсээр байна.

Е-сургалтын хэлбэрийн сөрөг тал: Е-Сургалтын хувьд мэдээлэл, харилцаа холбооны техник хэрэгслээс хараат бөгөөд интернэтийн хурд, технологийн дутмаг байдлаас

шууд нөлөөлнө. Мөн цаг хугацааны хувьд байршлаас хамаарч цагийн зөрүү гарах, багшаас сэдвийн хүрээнд асууж тодруулах зүйл төдийлөн чөлөөтэй бус, харилцан ярилцах боломж хязгаарлагдмал амьд харилцаа үүсэхгүй зэрэг хүндрэлүүдтэй.

Электрон номын сан, эрдэм шинжилгээний бүтээл, видео танилцуулга гэх мэт тухайн улсын хэл дээрх цахим эх сурвалж, сургалтын материал хангалтгүй байх бөгөөд ямар ч шүүлтүүргүй худал мэдээллийг эх сурвалж болгох аюултай.

Багаар, хамтран ажиллах амьд харилцаа үүсэхгүйгээс анги хамт олон, найз нөхдийн холбоо хязгаарлагдмал тул хамтын ажиллагаа, бусдаас суралцах чадвар дутмаг, багш суралцагчийг мэдэрч хичээлийг удирдан зохион байгуулах, түүнд нийцүүлэн “сурах” арга зүй өөрчлөх боломж хомс.

Лаборатори, дадлага, дасгалын аргаар үзэх хичээлүүдийг цахимаар авах боломж тун бага тул зарим гардан тулаан, галт зэвсэг, бие хамгаалах зэрэг хичээлүүдийг онлайнгаар үзэхэд үр дүн төдийлөн гарахгүй.

Эцэст нь дүгнэхэд хүн бол нийгмийн амьтан бөгөөд бусдаас суралцах, тэдний дунд биеэ авч явах байдал, харилцааны соёл, өөрийгөө бусдад илэрхийлэх, ойлгуулах арга барилд суралцах боломжгүй, нэг үгээр нийгэмшихэд хүндрэлтэй зэрэг сөрөг талуудыг дурдаж болно.

Дүгнэлт. Манай сургуулийн хувьд зайн, цахим болон танхимын сургалттай хослуулж явуулах нь хамгийн тохиромжтой арга бөгөөд судалгаанд хамрагдсан оюутнуудын дийлэнхэд хосолсон сургалтын аргаар суралцах хүсэлтэй ба бие даан суралцах чадварыг нь хөгжүүлнэ гэж үзжээ.

Е-сургалтыг илүү үр дүнтэй, өгөөжтэй байлгая гэвэл цахим сургалтад хичээл заах багш нартаа шат дараалсан сургалт явуулах, гарын авлага, зөвлөмж гаргаж өгөх цахим хичээлийн агуулга бэлтгэх үйл явц нь ихэвчлэн багш нарын санаачилгаар хэрэгжиж байгаа нь судалгаагаар харагдсан бөгөөд техникийн ажилтнууд (хичээлийн дизайн, зохиомж, студи, монтаж)-ын тусламжтайгаар медиа агуулгыг бэлтгэхэд анхаарах шаардлагатай байна.

Мөн дээр дурдсан, дэвшилтэт технологиуд болох AR/VR/MR технологиудыг үр дүнтэй ашиглаж дадлага ажлыг 3d орчин хэргийн газрын нөхцөл байдлыг харуулах, зэрэг бодитоор хийх боломжгүй хичээлийн өгөгдлүүдийг ашиглах нь илүү давуу талтай.

Сургах-суралцах процесс нь багш-оюутны хамтын ажиллагаа оролцооны үр дүнд бий болдог учраас цахим сургалтыг амжилттай явуулахын тулд багш нараа цахимаар орчин үеийн дэвшилтэт технологийн бүхий л боломжуудыг ашиглан хичээл заах, сургах, оюутны суралцах үйл явцыг үр дүнтэй зохион байгуулах арга зүйд сургах, дадлагажуулах, нөгөө талаас оюутнуудаа дунд сургуульд сурч байхаас нь эхлэн цахим орчинд суралцах арга барилд сургах нь чухал болж байна.

Багш бүр өөрийн заадаг хичээлээр чанартай сургалтын материал хэрэглэгдэхүүн бэлтгэж, бэлтгэснээ бусад хүмүүст ашиглах боломжтойгоор нээлттэй лицензтэйгээр ил болгох ингэснээр бие биеэсээ харилцан туршлага судалж суралцах, улмаар олон тооны чанартай сургалтын материалууд суралцагчдад хүртээмжтэй, нээлттэй болох боломж бүрдэнэ.

Санал: Дээрх дүгнэлтийг үндэслэн дараа саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрх зүйн орчныг тодорхой болгож, одоо шаардлагатай байгаа болон ирээдүйг харсан зохицуулалтыг хийж зөв сургалтын системийг сонгох

2. Хэд хэдэн сургуулиуд хамтран эрэлттэй мэргэжлүүдээр эсвэл ижил агуулгаар заадаг хичээлүүдийн хувьд дундын чанартай цахим хичээлийг хамтран бэлтгэж сургалтыг зохион байгуулах

3. Чанартай сургалтын нөөц материал, нийтэд зориулсан нээлттэй хичээлүүдийг тодорхой бодлого дэмжлэгтэйгээр бэлтгэх

4. Хосолсон сургалт, тонгоруу анги зэрэгт дижитал сургалтын элементүүдийг өргөнөөр ашиглах боломжийг дэмжих, дуу, дүрс таних болон хиймэл оюун ухааны дэвшлийг боловсролын салбарт нэвтрүүлэх

5. Сургалтын процессыг удирдан явуулах, хяналт тавих, үнэлэх хэрэгсэл болгох, виртуал болон бодит суралцахуйн орчныг хөгжүүлэх чиглэлээр тодорхой төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах

6. Е-сургалтын аргыг ашиглан цахим хичээл, контент бэлдсэн багшийн кредит цагийг суралцагчийн хандалт, давтамжаар танхимаар заасан хичээлтэй ижил түвшинд үнэлж А цагийг тооцох

7. Багшийн эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөөнд е-сургалтын чиглэлээр /хиймэл оюун ухаан, виртуал сургалтын материал, дижитал технологийн ашиглалт/ хийсэн бүтээлийг тооцох

Ашигласан материал

1. Д.Цэдэвсүрэн. Цахим сурах бичиг боловсруулах онол, арга зүй. –Уб., 2007.
2. Ц.Чимэдлхам. Боловсролын салбарт мэдээлэл холбооны технологийг нэвтрүүлэх онол, арга зүйн асуудал. –Уб., 2005.
3. М.Мөнхбаатар. О.Дүнжиннамдаг. Мэдээлэл, Холбооны Технологи Боловсролд, ММТ хурлын илтгэл, -Уб., 2017.
4. Салман Хан. (2014). Нэг дэлхийн сургууль. Филипе, Карьера. (2016). Харилцаа 2.0.
5. Ц.Ганбат. Сурах ба сургах үйл явцад ашиглагдах цахим контент хөгжүүлэх арга зүй ба хэрэгслүүд. -Уб., 2012.
6. Ж.Төгсөө, Т.Оюун-Эрдэнэ, С.Сайнзаяа. Хосолсон сургалтын онол, арга зүй зарим асуудал. –Уб., 2020.
7. <https://www.learnupon.com/>
8. <https://www.sreb.org/>
9. <https://www.wikipedia.org/>
10. <https://www.1212.mn/>
11. <https://www.melearn.mn/>
12. <https://www.1234.mn/>
13. <https://www.skills.mn/>

**ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН БАГШ, СОНСОГЧ,
СУРАЛЦАГЧДЫН ХАРИЛЦААНД АНХААРАХ АСУУДЛУУД**
**SOME ISSUES TO CONSIDER COMMUNICATION BETWEEN TEACHERS
AND STUDENTS OF UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS**

*Дотоод хэргийн их сургуулийн
Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн багш,
цагдаагийн ахлах дэслэгч Ц.Өнөболд*

Senior police lieutenant Unubold. Ts, teacher
of the Department of Social Sciences, School
of Law and Social Sciences, University of
Internal Affairs

Хураангуй Энэхүү судалгаагаараа Дотоод хэргийн их сургуулийн багш нар, сонсогч, суралцагчдын харилцааны нөхцөл байдал, тулгамдаж байгаа зарим асуудлыг хөндөж тодорхойлохыг зорьсон болно. Түүхийн өмнөх жилүүдтэй харьцуулахад амьдарч буй нийгэм цаг үеэс шалтгаалаад өнөөгийн сонсогч, суралцагчдын багшийг хүндэтгэх уламжлал, нэг үгээр хэлбэл тэр соёл тодорхой хэмжээгээр алдагдаж байгаа нь олон зүйл дээр харагдаж байна. Тиймдээ ч орчин үеийн багш нар өөрийн хөгжлийг тасралтгүй хийж цаг хугацаатай уралдаж багш, сонсогч, суралцагчдын хоорондын харилцааг сайжруулах түүнчлэн оюутан залуусд хүсэж буй мэдлэг чадварыг олгох тал дээр илүү анхаарах цаг болсон байна гэж үзсэн.

Судалгаанд хамрагдсан нийт 100 сонсогч, суралцагчдын 44 хувь нь сайн, 56 хувь нь дунд зэрэг гэж үзсэнийг шинжилвэл багш нарын зүгээс сонсогч, суралцагчидтай харилцах ажиллагаанд дутагдалтай тал байна гэж харагдаж байна. Дотод хэргийн их сургуулийн хувьд нэг талаараа цэргийн сургууль учраас сонсогч, суралцагчид багшаас эмээх хандлага өндөр, багшид хандсанч хүссэн үр дүнд хүрэхгүй гэж боддог байх жишээтэй байна. Энэхүү сэдвийн хүрээнд хийсэн судалгааг нэгтгэн дүгнэж үзвэл багш нарын харилцаа, оюутанд хандах хандлага, сурган хүмүүжүүлэх арга барилыг сайжруулах, өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Abstract: In this study, aimed to identify some of the problems and situations of communication between teachers and students of University of Internal Affairs

Compared to the years of history, the traditional respectfulness communication to the teachers by student being lost due to the each society times. In a word, that culture is being lost to a certain extent, which can be seen in many things. Therefore, modern teachers constantly develop themselves and improve their communication between students by racing against time and It's time to focus more on providing students with the skills they want. A total of 100 students participated in the study, 44% counted good marks 56% middle marked. On the one hand, because it is a military school, students have a high tendency to fear teachers and students feel that even if they approach their teachers, they will not get the desired result between teachers and students of University of Internal Affairs.

Summarize the research on this topic, there is an urgent need to change the relationship between teachers and students, to improve teaching and learning methods.

Түлхүүр үг: Багш, сонсогч, суралцагч, харилцаа, хандлага
Key Words: Teacher, student, learners, communication, attitude

УДИРТГАЛ

Монгол Улсад сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургууль, коллежийн тоо хамгийн сүүлийн нэгдсэн байдлаар 88 байгаагийн 37 (42.1%) нь их сургууль, 45 (51.1%) нь дээд сургууль, 3 (3.4%) нь коллеж, 3 (3.4%) нь гадаадын их сургуулийн салбар байна.

Энэ бүх сургуулиудад суралцаж байгаа оюутан залуус маань нэн түрүүнд хүн болж төлөвших тэр дундаа Монгол хүн болж төлөвших цаашлаад өөрийн эзэмшсэн мэргэжлээрээ дотооддоо төдийгүй гадаадад ажиллаж амжилт гаргах чадвар, мэдлэгийг эзэмших зайлшгүй шаардлагатай. Иймийн тулд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төгсөгчдийг бэлтгэхийн тулд их, дээд сургуулиуд сургалтын чанарыг урт болон богино хугацааны бодлогын турш сургалтын чанарыг дээшлүүлэх, илүү сайжруулах явдал маш чухал юм. Үүнд нөлөөлөх хамгийн том хүчин зүйл нь багш оюутны харилцааны асуудал болоод байна.

Дотоод хэргийн их сургуулийн хувьд багш оюутны харилцааны асуудал нь зөвхөн оюутанд төдийгүй багш нарын анхаарвал зохих чухал асуудал буюу чадварлаг, мөн нэр хүндтэй багш байх, олон сонсогч, суралцагчдад ямагт үлгэр дуурайлал үзүүлэх явдал зайлшгүй чухлаар тавигдаж байна.

Өнөөгийн нийгэм цаг үед боловсролын аль ч түвшний багш нарын нэр хүнд өмнөх түүхийн он жилүүдтэй харьцуулахад харьцангуй буурсан нь олон жишээ нотлох баримт нь дээр харагддаг. Тэр ч утгаараа энэ судалгааг Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн 40, Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн 30, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 10, Хилийн албаны сургуулийн 20 сонсогч, суралцагчдыг хамруулан авсан. Судалгааг асуулгын аргаар авч боловсруулсан. Багш, оюутны харилцаанд тулгамдаж буй асуудлыг илрүүлж шалтгаан нөхцөлийг тодорхойлж үнэлэлт дүгнэлт өгөх зорилгыг агуулсан.

Нэг. БАГШИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ БА БАГШИЙН ЁС СУРТАХУУН

БОДЛОГЫН АСУУДАЛ

Дээд боловсролын тухай хууль¹⁰⁴ “Дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх төрийн бодлого, дээд боловсролын хөгжлийн дунд болон урт хугацааны төлөвлөгөөнд нийцүүлэн Их дээд сургуулийг хөгжүүлэх чиглэл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх”, “Багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, тэдний болон төгсөгчийн мэргэшлийг дээшлүүлэх” “Их, дээд сургууль, коллеж нь сургуулиа хөгжүүлэх ойрын болон хэтийн бодлого, хөтөлбөр төлөвлөгөөтэй байна.”

Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль¹⁰⁵. “Багшийн хөгжил” гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг”, “Бүх шатны боловсрол сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байх”, “Дээд боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг тухайн сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулна.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого¹⁰⁶

¹⁰⁴ Төрийн мэдээлэл. 2023., №27. Дээд боловсролын тухай хууль

¹⁰⁵ Төрийн мэдээлэл. 2018., №31. Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль

¹⁰⁶ Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого

“Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ”, “Боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор сууршилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ”, “Багш, ажилтан, суралцагчийн хөгжлийг дэмжих, нийгмийн асуудлыг шийдвэрлэх санхүүгийн уян хатан, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.”

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого¹⁰⁷

“Шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжилд дээд боловсролын сургалтын байгууллагуудын оруулах хэвь, нэмэр, оролцоог нэмэгдүүлж, бүс нэтэгтаа өрсөлдөх чадвартай үндэсний судалгааны их сургууль байгуулна.”

“Боловсролын салбарын хүний нөөцийн цогц бодлого хэрэгжүүлж, чадварт суурилсан зарчмаар албан тушаал, мэргэжлийн хөгжлөө тодорхойлох боломжтой тогтолцоог бий болгох, салбарын хүний нөөцийн жендерийн тэгш байдлыг хангах, хөдөө орон нутагт очиж ажиллах хүний нөөцийг орон байраар хангах зэрэг арга хэмжээг авна”.

Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр¹⁰⁸

“Шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжлийн орчин үеийн тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэшсэн чадварлаг эрдэмтэн, судлаачдыг судалгаанд суурилсан их сургуулиудад төвлөрүүлэх замаар ахисан түвшний сургалт, судалгааг хөгжүүлнэ”

Монгол улсын Дотоод хэргийн их сургуулийн “Багшийн хөгжлийн хөтөлбөр” (Бодлогын баримт бичиг 2021-2025)¹⁰⁹

Их сургуулийн алсын хараа, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан багшийн мэргэжлийн мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ур чадварыг хөгжүүлэх, манлайлал, харилцаа хандлага, ёс суртахууны үнэлэмжийг нэмэгдүүлэх, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх замаар хөгжлийн эрэлт хэрэгцээг сэтгэл ханамж болгоход чиглэнэ.

Дотоод хэргийн их сургуулийн стратеги төлөвлөгөө 2016-2025¹¹⁰

“Орчин үеийн Их сургуулийн жишиг нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх сургалтын хөтөлбөр, багшийн заах арга зүйг сайжруулах замаар сургалтын чанар үр дүнг дээшлүүлж захиалагчийн хэрэгцээ шаардлагыг хангасан цогц чадамж бүхий мэргэжилтэн бэлтгэнэ”.

Дотоод хэргийн их сургуулийн 2022.04.05-ны өдрийн А/234 “Дүрэм шинэчлэн батлах тухай” Багш, албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм Д 03-ын Зургаадугаар бүлэг Багшийн баримтлах ёс зүйн хэм хэмжээ

6.1 Багш нь суралцагчтай хүндэтгэлтэй хандаж, харилцааны өндөр соёлтой байж түүний суралцахуйн чадварыг хөгжүүлэн чиглүүлэгч байна.

6.2 Суралцагчийн мэдлэг чадвар, хичээл, зүтгэл, оролцоо сурлагын амжилтыг ил тод бодитоор дүгнэнэ.

6.3 Суралцагчдыг нийгмийн гарал, нас, хүйс, шашин шүтлэг, гадаад үзэмж, бие эрүүл мэндийн онцлог, эцэг эхийн амжиргааны түвшин өолон хувийн шалтгаант байдлаар ялгавралаж харьцахгүй байх.

¹⁰⁷ “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого

¹⁰⁸ Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр

¹⁰⁹ Монгол улсын Дотоод хэргийн их сургуулийн “Багшийн хөгжлийн хөтөлбөр” (Бодлогын баримт бичиг 2021-2025)¹⁰⁹

¹¹⁰ Дотоод хэргийн их сургуулийн стратеги төлөвлөгөө 2016-2025¹¹⁰

6.4 Багш, суралцагчдын хоорондын харилцаан Монгол Улсын цэргийн нийтлэг дүрэм, Их сургуулийн үйл ажиллагааны дүрэм журмыг баримтлан ажиллана.

6.5 Багшийн ёс зүй нэр хүндийг ямагт эрхэмлэн дээдэлж биеэ авч явах байдал, сургах үйл ажиллагаа, хариуцсан ажил үүргийнхээ төлөө хариуцлага хүлээж бүрэлдэхүүнд үлгэр дуурайл үзүүлнэ.

БАГШИЙН ЁС СУРТАХУУН

Багшийн сургалтын үйл ажиллагаа нь мэдээж тухайн багшийн өөрийнх нь үндсэн төлөв байдал, хөгжил, ёс суртахуун ба ёс зүйтэй нь салшгүй холбоотой байдаг. Зарим багш нарын хувьд ёс суртахуун ёс зүйн хувьд мэдлэг, мэдрэмж дутагдадгаас шалтгаалан харилцааны соёлын үнэлэмжийн асуудал яригддаг.

Ёс суртахуун дутмаг багш чадвар, мэдлэг бусад дадлага туршлагатай байгаа хэдий ч хичээл заалгуулж байгаа шавь нарынхаа итгэл бөгөөд хүндэтгэлийг төдийлөн хүлээж чаддаггүй тохиолдлууд элбэг байдаг. Энэ байдалд хүргэх хүчин зүйл, үйлдэл нь багшийн үг яриа өөрөөр хэлбэл харилцаа юм. Үг яриа бол мэдээж багш нарын харилцааны хамгийн чухал хэсэг юм. Ингэснээр сурган хүмүүжүүлэх ая дан гэдэг ойлголт гарч ирнэ. Сурган хүмүүжүүлэх ая данд дараах үйлдлүүд ордог. Үүнд.

- Чин сэтгэлээсээ мэдрэмжтэй намуухан ярьж тайлбарлах
- Шавьдаа итгэхдээ дур зоргоор нь тавихгүй байх.
- Үглэж залхаалгүйгээр удирдаиж зөвлөгөө өгөх
- Санал асуулга, санамж анхааруулгын хэлбэрээр нөлөө үзүүлэх
- Шавийн бие даасан байдлыг дарж сөргөхгүйгээр итгүүлж шаардах
- Шоолж шоглохгүйгээр егөөдөж алиалах
- Зулгуйдаж доигнохгүй сайн сайхныг хүсэж ерөөх
- Зөрүүдэж гөжүүдэлэлгүй шаргуу зан гаргах
- Ажил хэргийн харилцаанд цухалдалгүй хандах
- Ёс журам номлолгүйгээр ярилцах Ж.Тунгалаг¹¹¹

Багш, оюутны харилцааны түвшинг УБИС-ийн багш Д.Баярмаа багш оюутны хамтын үйл ажиллагааг үндсэн 3 түвшинд байна гэж үзсэн. Үүнд:

1. Дээгүүр- харилцаа хандлага нь халуун дотно, бие биеэ сайн ойлгодог, харилцан итгэдэг, 2. Дунд зэрэг- Төдийлөн дотно биш, бие биеэс зай барьсан, тухайн үеийн нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг

3. Доогуур-хөндий хүйтэн, үл ойлголцдог, харилцан туслалцаж чаддаггүй

Харилцааны түвшин нь багшийн оюутанд нөлөөлөх чадвартай шууд холбоотой байдаг.

Хоёр. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Дэвшүүлсэн сэдэвтэй уялдуулан Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн 40, Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн 30, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 10, Хилийн албаны сургуулийн 20 сонсогч, суралцагчдыг хамруулан авсан. Үүнд:

Хүснэгт 1 Багшийн үндсэн үүрэг

Сургууль	Сурган хүмүүжүүлэгч	Мэдлэг өгөгч	Найз нөхөр	Дургүй хүн	Дотны хүн
ЦС	36.4	57.5	4.5	1.6	-
ЭЗНУС	54.5	39.5	3.0	3.0	-
ШШГАС	43.0	56.0	1.0	-	-

¹¹¹ Ж.Тунгалаг-ын Их дээд сургуулийн багш, оюутны харилцааны талаарх судалгаа

ХАС	44.0	48.8	2.8	5.2	-
-----	------	------	-----	-----	---

Хүснэгт 1 судалгаанаас үзэхэд багш, сонсогч, суралцагчдын ерөнхий харилцаа шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Хүснэгт 2 Багш оюутны харилцаа

Сургууль	Сайн	Дунд	Хангалтгүй
ЦС	26.5 хувь	62.7 хувь	10.8 хувь
ЭЗНУС	42.4 хувь	57.6 хувь	0 хувь
ШШГАС	42.2 хувь	55.6 хувь	2.2 хувь
ХАС	47.0 хувь	49.0 хувь	4.0 хувь

Хүснэгт 2 судалгаанаас үзэхэд багш нарын дунд ялгаварлах явдал багагүй гардаг гэж оюутнууд үзэж байгаа нь анхаарвал зохих хэмжээний асуудал мөн байна.

Хүснэгт 3 Ялгаварлалтад нөлөөлөх хүчин зүйл

Сургууль	Гадаад төрх, хувцаслалт	Сурлагаар	Оюутны зан харилцаатай холбоотой	Хариулаагүй
ЦС	22.3	28.9	41.0	7.8
ЭЗНУС	12.1	39.4	42.4	6.1
ШШГАС	28.9	17.8	17.8	35.5
ХАС	15.0	39.0	37.0	9.0

Хүснэгт 3 судалгаанаас үзэхэд багш оюутантай ялгаварлан харьцах гэдгийг оюутнууд янз бүрээр ойлгодог. Зарим багш нар сонсогчидтой тэгш харилцдаггүй явдал гардаг, гэхдээ энэ нь зарим тохиодолд сонсогчид өөрийгөө зөв ойлгуулж чөлөөтэй чадахгүй байгаатай холбоотой гэж ихэнх хувь нь үзсэн байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Дотоод хэргийн их сургуулийн багш, сонсогч, суралцагчдын харилцааг сонсогч, суралцагчдын 40 гаран хувь нь сайн, 50 гаран хувь нь дунд зэрэг гэж үнэлж байгаагаас үзэхэд багшийн зүгээс сонсогч, суралцагчидтай харилцах үйл ажиллагаанд учир дутагдалтай тал багагүй байна. Тухайн харилцаанаас шалтгаалж зарим сонсогчид өөрт тулгарч буй бэрхшээлийг тэр бүр багшид хэлдэггүй, ярьдаггүй зарим тохиолдолд эмээдэг учраас сайн үр дүн дөдийлөн гарахгүй байсаар байна.

2. Багш нар сонсогч, суралцагчдыг ялгаварлан харилцах явдал гардаг гэж сонсогч, суралцагчид үздэг. Үүнд: Гадаад төрхөөр ялгаварлах, сурлагаар ялгаварлах, зарим сонсогч, суралцагчидын зан байдлаас зэргийг өгүүлж байна. Үүнээс үзэхэд багш нар сурлага сайнгүй болон бүрэг ноомой, дуу цөөтэй сонсогчидтой илүү ойрхон тулж ажиллах талаар анхаарал хандуулах шаардлагатай байна.

3. Сонсогч, суралцагчид багш нарыг үргэлж шинэлэг хэлбэрээр сонирхолтой заах сонсогчдийг сайн ойлгох, хүндэтгэлтэй дотно хандах, шударга дүгнэх, ялгаварлахгүй харьцахыг хүсэж байгаа нь нөгөө талаараа багш бид өөрсдийгөө улам илүү хөгжүүлэх талаар илүү анхаарах шаардлагатай болж байна.

4. Сонсогч, суралцагчид улирлын хичээл дуусч дүн гарсны дараа хичээл заасан багштайгаа мэндлэхээ болих явдал заримдаа тохиолддог нь нэг талаараа багш, сонсогч, суралцагчийн харилцаатай холбоотой байна. Ямарч тохиолдолд хүн хүнтэй мэндлэх тэр дундаа хичээл заасан багштай мэндлэхээ больж байгаа нь тухайн сонсогчийн үндсэн төлөвшил, гэр бүлийн хүмүүжил ёс суртахуун, мөн багшийн ёс суртахуунтай холбогдож байна.

5. Багш, сонсогч, суралцагчдын харилцаанд түүхийн өмнөх жилүүдтэй харьцуулахад ахиц гараагүй байгаа нь орчин цагийн багш нар үүнд илүү анхаарал хандуулж ажиллах цаг нэгэнт ирснийг илтгэж байна.

6. Дотоод хэргийн их сургуулийн багш, сонсогчид Монгол Улсын цэргийн нийтлэг дүрэмд заасны дагуу харьцана гэж заасан нь зарим тохиолдолд сонсогч чөлөөтэй, ардчилсан байж багштай харьцах цаашлаад сурч боловсроход хүндрэл үүсэж болзошгүй байна.

Багш, сонсогчдын харилцааны талаар хийсэн энэхүү судалгааг нэгтгэвэл багш нарын харилцаа, сонсогч, суралцагчидтай харилцах хандлага, сурган хүмүүжүүлэх арга барилаа илүү сайжруулах үргэлж шинийг эрэлхийлэх, өсөж дэвших шаардлага албан ёсоор тавигдаж байна.

Ашигласан материал

1. Дээд боловсролын тухай хууль
2. Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
3. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого
4. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
5. Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
6. Монгол улсын Дотоод хэргийн их сургуулийн “Багшийн хөгжлийн хөтөлбөр” (Бодлогын баримт бичиг 2021-2025)
7. Дотоод хэргийн их сургуулийн стратеги төлөвлөгөө 2016-2025
8. Ж.Тунгалаг-ын Их дээд сургуулийн багш, оюутны харилцааны талаарх судалгаа
9. Дотоод хэргийн их сургуулийн багш, албан хаагч, ажилтаны ёс зүйн дүрэм